

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН  
ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ .....	1
1.1. Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн нөхцөл байдал .....	1
1.2. Олон улсын конвенц, хэлэлцээрээр Монгол Улсын хүлээсэн үүрэг, хэрэгжүүлэх зорилтууд .....	13
1.3. Төрийн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үүрэг .....	18
1.4. Хууль тогтоомж .....	19
1.5. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой процессын хувьд зохицуулах шаардлагатай асуудлууд .....	21
1.6. Зайлшгүй үүсгэх шаардлагатай тогтолцоо, институц, хүний нөөцийн дүн шинжилгээ .....	22
1.7. Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүгийн тогтолцоо .....	26
1.8. Ногоон таксаноми .....	31
1.9. Стратегийн төлөвлөлт болон дунд хугацааны төсвийн хүрээ .....	34
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ .....	35
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ .....	37
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ .....	40
4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө .....	41
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө .....	43
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө .....	46
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө .....	48
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙСЭН БАЙДАЛ	50
ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙСЭН БАЙДАЛ .....	53
6.1. Их Британи Улс .....	54
6.2. Герман Улс .....	55
6.3. Австри Улс .....	56
6.4. Йордан Улс .....	57
6.5. Гана улс .....	59
6.6. Кени улс .....	61
6.7. Филиппин улс .....	65
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ .....	73

## НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Уур амьсгалын өөрчлөлт гэдэг нь хүний үйл ажиллагааны улмаас агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламж нэмэгдэж, дэлхийн уур амьсгалын тогтолцоонд урт хугацааны өөрчлөлт бий болох үйл явцыг хэлнэ. Ялангуяа чулуужсан түлшний хэрэглээ, уул уурхай, аж үйлдвэр, газар ашиглалтын өөрчлөлт, ой модны доройтол зэрэг хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүрсхүчлийн хий ( $\text{CO}_2$ ), метан ( $\text{CH}_4$ ), азотын давхар исэл ( $\text{N}_2\text{O}$ ) болон бусад хүлэмжийн хийн ялгарал эрчимтэй нэмэгдсэнээр дэлхийн дулаарал хурдацтай явагдаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дэлхийн дундаж температур өсөх, хур тунадасны горим өөрчлөгдөх, ган, зуд, үер, халуун давалгаа, ой, хээрийн түймэр, цөлжилт, мөсөн голын хайлалт, усны нөөцийн хомсдол, биологийн олон янз байдлын доройтол зэрэг сөрөг үр дагавар улам эрчимжиж байна. Эдгээр өөрчлөлт нь байгаль орчны тэнцвэрт байдалд төдийгүй хүн амын амьжиргаа, хүнсний аюулгүй байдал, усны нөөц, эрүүл мэнд, эрчим хүч, хөдөө аж ахуй, эдийн засгийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийг дэлхий нийтийн тулгамдсан сорилт болгож байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь хил хязгаар үл хамаарах шинжтэй бөгөөд нэг улсын ялгаруулсан хүлэмжийн хий агаар мандалд хуримтлагдан дэлхийн хэмжээнд нөлөөлдөг онцлогтой. Иймд аливаа улс дангаараа энэ асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй бөгөөд олон улсын хамтын ажиллагаа, хамтын хариуцлага зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ хүрээнд улс орнууд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн хүрээнд “хамтын боловч ялгаатай хариуцлагын” зарчимд тулгуурлан хамтран ажиллаж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон хөгжлийг дэмжих, санхүүжилт, технологи, мэдлэг, чадавхын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүрэг хүлээж байна.

Иймээс улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлого, төлөвлөлт, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, тогтвортой, нүүрстөрөгч багатай хөгжлийн загварт үе шаттай шилжих шаардлагатай болсон. Энэ нь зөвхөн өнөөгийн эрсдэлийг бууруулах төдийгүй ирээдүй үеийн аюулгүй орчинд амьдрах эрх, тогтвортой хөгжил, эдийн засгийн өрсөлдөх чадварыг хамгаалах стратегийн ач холбогдолтой асуудал юм.


### 1.1. Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн нөхцөл байдал

#### 1.1.1. Хүлэмжийн хийн ялгарал

Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд бага (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их юм. Монгол Улс 2020 онд нийт 43,081.62 мян. т  $\text{CO}_2$  -экв. (газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ойн салбарыг тооцоогүй) ялгаруулсны 51.97% нь хөдөө аж ахуй, 44.78% нь эрчим хүч, 2.66% нь аж үйлдвэр, үлдсэн 0.58% нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Хүлэмжийн хийн бүтцээр нь авч үзвэл 42.40%-ийг нүүрсхүчлийн давхар исэл буюу нүүрсхүчлийн хий ( $\text{CO}_2$ ), 33.82%-ийг метан хий ( $\text{CH}_4$ ), 22.46%-ийг азотлог исэл ( $\text{N}_2\text{O}$ ), 1.33%-ийг гидрофторт нүүрстөрөгчид (HFCs) тус тус эзэлж байна.<sup>1</sup>


<sup>1</sup> Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хоёр жил тутмын тайлан-илтгэл 2023,

**Хүлэмжийн хийн өөрчлөлт:** АНУ-ын Агаар мандал, далай судлалын үндэсний газар (NOAA)-ын Дэлхийн системийн судалгааны лаборатори (ESRL)-тай хамтран Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэн Монгол орны агаар дахь хүлэмжийн хийн мониторингийн хэмжилт судалгааг Дорноговь аймгийн Эрдэнэ суманд 1992 оноос хойш 2020 оныг дуустал тасралтгүй хийж байсан. Энэхүү мэдээгээр хүлэмжийн хийн дундаж агууламж Монгол орны нутаг дэвсгэр дээр тасралтгүй нэмэгдэж, нүүрсхүчлийн /CO<sub>2</sub>/ хийн жилийн дундаж агууламж 354.6-аас 413.3 ppm хүрч, 16.5%-аар нэмэгдсэн байна (Зураг 1). Харин агаар дахь метаны (CH<sub>4</sub>) агууламж 1808-аас 1968 ppbv хүрч 8.8%-иар нэмэгдсэн.



Зураг 1. Агаар дахь нүүрсхүчлийн хийн агууламжийн өөрчлөлтийн хандлага


**Агаарын температурын өөрчлөлт:** Монгол орны нутаг дэвсгэр дээр жигд шахам тархан байрласан цаг уурын ажиглалтын урт цуваат 45 өртөөдийн мэдээгээр буюу бодит ажиглалтын мэдээгээр 1940-2025 оныг хүртэл хугацаанд Монгол орны газрын гадарга орчмын агаарын температур 2.58°C-ээр градусуар дулаарсан бөгөөд 1988 оноос хойш эрчимшил эрс нэмэгдсэн байна (Зураг 2). Энэхүү дулааралт нь газар нутгийн онцлогоос хамаарч харилцан адилгүй илэрч байна.



Эх сурвалж: УЦУОСМХ

Зураг 2. Жилийн агаарын дундаж температурын олон жилийн дундажаас хазайх хазайлт


Орон зайн тархалтыг авч үзвэл хамгийн их дулааралт Улаанбаатар хот, Увсын Улаангом, Хөвсгөлийн Мөрөн, Сэлэнгийн Баруунхараа, Сүхбаатарын Баяндэлгэр сум орчмоор ажиглагдаж байгаа бөгөөд 3.3-аас 3.8°C-ээр дулаарчээ (Зураг 3).



Эх сурвалж: УЦУОСМХ

Зураг 3. Монгол орны жилийн дундаж агаарын температурын өөрчлөлт, түүний газар зүйн тархалт


Хур тунадас: Монгол орны жилийн нийлбэр хур тунадас 1940-2025 оны хооронд тодорхой өссөн буурсан хандлага илрээгүй ч нийт хандлагаар бага зэргийн өсөлт ажиглагдаж байна (Зураг 4). Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явцаас харахад 1997-2011 оны хооронд удаан хугацааны турш олон жилийн дунджаас бага хур тунадас орсон бол сүүлийн 2012,2013,2016,2018,2020,2021,2023,2024 онуудад дунджаас ахиу тунадас оржээ.



Эх сурвалж: УЦУОСМХ

Зураг 4. Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн дунджаас хазайх хазайлт

Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн хэлбэлзэлд тодорхой өссөн буурсан хандлага илрээгүй ч газарзүйн тархалтаар авч үзвэл Архангайн Эрдэнэмандал, Төвийн Эрдэнэсант, Дундговийн Мандалговь, Говьсүмбэр Чойр, Сүхбаатар Эрдэнэцагаан нутгаар 10-40%-иар буурсан хандлага харагдаж байна (Зураг 5).



Эх сурвалж: УЦУОСМХ

Зураг 5. Монгол орны жилийн нийлбэр хур тунадасны өөрчлөлт, түүний газар зүйн тархалт

**Уур амьсгалын эрс, тэс байдлыг илэрхийлэх үзүүлэлтүүд:** Агаарын үнэмлэхүй их ба бага температур болон халуун өдрийн тоо нэмэгдэж, хүйтэн өдрийн тоо нийт нутгаар буурсан хандлагатай байна. Хоногт орсон хамгийн их хур тунадсыг ажиглагдсан хугацаагаар нь авч үзэхэд нийт тохиолдлын 54%-ийг 2000-2020 оны үе эзэлж байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн улмаас аадар тунадас улам эрчимжиж байгааг харуулж байна. Ууршилт нэмэгдсэн, 1997-2011 онд хуурайшилтын индекс -0.5...-1.0 буюу онцгой хуурай байв.

**Уур амьсгалын бусад үзүүлэлтүүдийн өөрчлөлт:** Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (УЦУОСМХ)-гээс гаргасан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал эрсдэлийн үнэлгээний тойм<sup>2</sup> дурдсанаар Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдал дараах байдалтай байна. Үүнд:


- хүйтэн өдрийн тоо дунджаар 15 хоногоор буурч, эсрэгээр халуун өдрийн тоо 24 хоногоор нэмэгдсэн;
- дараалсан халуун өдөр тохиолдох тоо 13 хоногоор нэмэгдсэн;
- ургамал ургалтын хугацааны хур тунадас буурч байгаа, түүнд аадар борооны эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа;
- дараалан орох хур тунадастай өдрийн тоо ялимгүй буурч байна;
- гандуу байдал ерөнхийдөө эрчимжиж гангийн давтагдал нэмэгдэж байгаа;
- хэдийгээр хүйтний эрч суларч байгаа хэдий ч өвлийн тунадас нэмэгдэх, гандуу байдалтай холбоотойгоор зудын давтагдал нэмэгдэж байна.

Монгол орны уур амьсгал дэлхийн дундажтай харьцуулбал ихээхэн эрчимтэй өөрчлөгдөж хуурайших, цаг агаарын гаралтай аюултай, гамшигт үзэгдлийн эрчим, давтамж ихээхэн нэмэгдэх эрсдэл өндөр байгааг судалгаа харуулж байна.

**Уур амьсгалын ирээдүйн өөрчлөлтийн төлөв:** Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний хорооны сүүлийн тайлан илтгэлд (IPCC AR6) CMIP төслийн (Coupled Model Intercomparison Project) 6 дахь үе шатны загваруудаар нийгэм-эдийн засгийн хамтын замнал (SSP Shared Socio-economic Pathway) болон хүлэмжийн хийн их, бага, дунд ялгаруулалтын хувилбаруудаар тооцож гаргасан уур амьсгалын ирээдүйн өөрчлөлтийн төсөөлөлд тулгуурлан үнэлгээ хийсэн байдаг (Зураг 6).

Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтийг хүлэмжийн хийн ялгаралтын ssp126, ssp245, ssp370, ssp585 хувилбаруудаар, уур амьсгалын динамик загваруудын үр дүнгийн дундаж (ensemble) байдлаар хийсэн байна. 2100 он хүртэлх уур амьсгалын өөрчлөлтийн ерөнхий төлөвөөс үзэхэд 2030, 2050, 2080-аад оны үеүдэд:

- Улирлын агаарын температур тогтвортой нэмэгдэж дулаарах хандлагатай бөгөөд өөрчлөлтийн тоон утга 2030 оны үед 0.7-1.4°C, 2050 оны үед 1.1-2.9°C, 2080 оны үед 1.2-6.5°C нэмэгдэхээр байна.
- Өвлийн хур тунадас харьцангуй их (8.7-55.4%), намар болон хаврын хур тунадас ялимгүй их, зуны тунадас бараг өөрчлөлтгүй байх төлөвтэй байна.
- Зуны хамгийн их температур 1.6-5.3°C-аар, өвлийн хамгийн бага температур 1.4-5.3°C-аар нэмэгдэж дулаарах, жилд хүйтэн өдөр 8.8-36.9 хоногоор багасах, зун хэт халалт 2.8 хоногоор нэмэгдэх, өвөл хэт хүйтрэлт 2.6 хоногоор буурахаар байна.
- Хоногийн хур тунадасны хэмжээ бараг өөрчлөгдөхгүй, зун дараалсан хуурай өдөр нэмэгдэх, өвөл дараалсан цастай өдөр багхан нэмэгдэхээр төлөвтэй.
- 1 болон 5 хоногийн хамгийн их тунадасны хэмжээ өсөх хандлагатай байна.



Зураг 6. Монгол орны агаарын температурын уур амьсгалын ирээдүйн өөрчлөлтийн ерөнхий хандлага: а) өвөл б) хавар в) зун г) намар

### 1.1.2. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэл

Монгол Улсын сүүлийн 85 гаруй жилийн хугацаанд агаарын температурын жилийн дундаж хэм 2.58°C-ээр нэмэгдсэн нь дэлхийн дундаж өөрчлөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн хэлбэлзэлд тодорхой өссөн буурсан хандлага

илрээгүй ч газарзүйн тархалтаар авч үзвэл Архангайн Эрдэнэмандал, Төвийн Эрдэнэсант, Дундговийн Мандалговь, Говьсүмбэр Чойр, Сүхбаатар Эрдэнэцагаан нутгаар 10-40%-иар буурсан хандлага харагдаж байна<sup>3</sup>.

Монгол улсын далайд гарцгүй газар зүйн байршил, агаарын температур нь эрс тэс, өндөр хэлбэлзэл, жилийн дундаж температур нь -8°С-ээс +6°С –ийн (зуны дундаж температур 10°С-26°С, өвлийн дундаж температур -15°С-аас -30°С) хооронд хэлбэлздэг, жилийн нийт хур тунадас нь говийн бүсэд 50 мм, нутгийн хойд уулархаг нутагт 400 мм ордог нь монголыг уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд илүү өртөмтгий, эмзэг байдалд оруулдаг байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар 2009 болон 2014 онуудад хийсэн үнэлгээгээр<sup>4</sup> монголын экосистем ихээхэн эмзэг, эдийн засаг нь мал аж ахуйгаас хамааралтай, хур борооны хэмжээнээс шууд хамааралтай газар тариалантай, хүн ам нь хурдацтай нэмэгдэж байгаа, уламжлалт нүүдлийн ахуйтай боловч хотжилтын хандлага давамгайлж байгаа зэрэг олон хүчин зүйл нь Монгол улсыг уур амьсгалын өөрчлөлтөд маш эмзэг, өртөмтгий болгож байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл нь:

- (1) Усны хомсдол - өндөр уулсын цас, мөсөн голууд хайлж, гадаргын усны нөөц цөөрснөөр,
- (2) Цөлжилт - хөрсний болон газар, бэлчээрийн доройтол нэмэгдсэнээр,
- (3) Ойн экосистемийн доройтол - хортон шавж, түймрийн аюул ихэссэнээр
- (4) Ядуурал, хүнсний аюулгүй байдал нь байгалийн нөөц баялаг, хөдөө аж ахуй, газар тариалангийн нөөц, хомсдол үүссэнээр,
- (5) Хүний эрүүл мэндийн хохирол - экологийн тэнцвэрт байдлын алдагдал, байгаль орчны бохирдсоноос,
- (6) Биологийн олон янз байдлын доройтол нь дээрх сөрөг нөлөөллийн улмаас зарим төрөл зүйлийн ургамал, зэрлэг ан амьтан устаж, тоо толгой цөөрснөөр,
- (7) Үер, ган, зуд, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн улмаас нийгэм, эдийн засгийн их хэмжээний хохирол, хор уршгийг үзүүлж байгаагаар тус тус илэрч байна.

Тухайлбал, судлаачдын тогтоосноор 1971 оны байдлаар нийт газар нутгийн 63%-д олон жилийн цэвдэг тархсан байсан бол 2016 онд 29.3% болсон байна. 2000-2015 оны хооронд нийт нуур цөөрмийн 21%, гол мөрний 12%, горхи булгийн 15% нь хатаж ширгэсэн гэсэн судалгаа байдаг. Гэхдээ мөсөн гол, цэвдгийн хайлалтын улмаас зарим газар булаг шанд эргэн сэргэх, шинээр гарах тохиолдол бас ажиглагдаж байна. Манай улсад хүчтэй салхи, цасан шуурга, аадар бороо, аянга цахилгаан, үер, ой хээрийн түймэр, ган, зуд зэрэг цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиодог бөгөөд харин тэдгээрийн давтамж сүүлийн 20 жилд хоёр дахин нэмэгджээ<sup>5</sup>.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, үр дагаврыг байгалийн нөөц, экосистемийн гол бүрэлдэхүүн болон нийгэм-эдийн засгийн гол салбаруудаар хураангуйлан тоймлосныг Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний 2014 оны тайланд тусгажээ<sup>6</sup>. Үүнд (1) өнөөгийн уур амьсгалын элементүүдийн өөрчлөлт, (2) байгаль, нийгэм-эдийн засгийн салбарт гарсан гол

<sup>3</sup> Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн 2026,

<sup>4</sup> Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан 2009, 2014 он,

<sup>5</sup> Үндэсний тодорхойлсон хувь нэмэр 2019,

<sup>6</sup> Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан 2014,

нөлөөлөл, (3) ирээдүйн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний гол үр дүн, (4) шаардлагатай авч хэрэгжүүлэх, арга хэмжээ, үйл ажиллагаа зэргийг оруулсан байна.

Монгол улсын уур амьсгалын нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн тоо баримт, мэдээллүүдээс үзэхэд Монгол орны нутаг дэвсгэрт бүх улирлын агаарын температур цаашид тогтвортой нэмэгдэж дулаарах, хур тунадас өвөл нэмэгдэх хэдий ч, зуны улиралд нэмэгдэхээргүй төсөөлөгдөж байгаа явдал нь ерөнхийдөө уур амьсгалын ган, хуурайшлыг улам эрчимжүүлж, манай орны байгаль, нийгэм-эдийн засгийн салбаруудад шууд ба шууд бус байдлаар нөлөөлөхөөр байна.

Иймд цаашид Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын өнөөгийн болон ирээдүйн стратегийн үнэлгээг холбогдох салбаруудаар гаргах, түүний үр дүнг үндэслэн хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилт, арга хэмжээ, үйл ажиллагааг хууль, бодлого, стратеги, төлөвлөлттэй уялдуулж хэрэгжүүлэх хууль, эрх зүйн тодорхой орчныг бий болох шаардлагатай байна.

### 1.1.3. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ

Үндэсний 4 дүгээр тайлангийн хүрээнд байгалийн нөөц, нийгэм эдийн засгийн салбаруудын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээг усны нөөц, мөстөл мөсөн гол, цэвдэг, бэлчээр хөрс, ойн нөөц, зэрлэг амьтан, байгалийн гамшиг, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, дэд бүтэц, нийгмийн эрүүл мэнд зэрэг нийгэм эдийн засгийн гол салбаруудаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн тоон үнэлгээг дэлхийн болон бүс нутгийн уур амьсгалын динамик загварын үр дүнг ашиглан хийсэн.

Хүснэгт 1-т эдгээр салбаруудын өнөөгийн болон ирээдүйн нөлөөллийн үнэлгээний гол үр дүнг тоймлон бичив. Ингэхдээ ирээдүйн нөлөөллийн үнэлгээний үр дүнг 2046-2065 он буюу 2050 оны үеээр Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн засгийн газрын мэргэжилтний бүлэг (IPCC) –ээс гаргасан 6 дугаар илтгэлийн хүлэмжийн хийн хамгийн их ялгаралттай ssp85 болон 5 дугаар илтгэлийн RCP85 гэсэн сценарит үндэслэсэн болно.

*Хүснэгт 1. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээний гол үр дүн*

№	Уур амьсгалын өөрчлөлт	Өнөөгийн өөрчлөлт	Нөлөөллийн үнэлгээний гол үр дүн
1	Усны нөөц	-Монгол орны гол мөрний нийт урсац 1978 оноос хойш аажим нэмэгдсээр 1993 онд 78.4 шоо км хүрч, үүнээс хойш аажим буурсаар 2002 онд хамгийн бага 16.7 шоо км устай байв. Бага устай үе 1996 оноос 2017 он хүртэл 23 жил үргэлжилж байсан бол 2018 оноос услаг нэмэгдэж байна. -ДЦУБ-ын зөвлөмжийн дагуу шинэчилсэн нормын хугацаагаар буюу 1991-2020 оны дунджаар тооцоход 30.6 км <sup>3</sup> /жил болж, өмнөх норм болох 34.6 км <sup>3</sup> /жилээс 10%-иар багассан байна. -Монгол орны ихэнх нууруудын усны түвшин сүүлийн 1996-2020 оны 25 жилд ерөнхийдөө буурах хандлагатай байна. 1945 оны	-Энэ зууны дунд үе гэхэд Хойд мөсөн далайн ай савын гол мөрний урсац дунджаар 8%-иар ихсэх, харин Номхон далайнх 40% орчим буурах, Монгол орны хэмжээнд гол мөрний урсац дунджаар 24%-иар буурах төлөвтэй.

		мэдээтэй харьцуулахад нуурын нийт талбай нь 7.79%- иар буурав.	
2	Мөстөл, мөсөн гол	- Монгол орны мөстөл, мөсөн голын талбай 1940-өөд онд 535 орчим, 1990 онд 470 орчим, 2002 онд 453.8, 2019 онд 338 км <sup>2</sup> болж эрчимтэй багасаж байна.	-Түргэн, Потанин, Цамбагарав, Сутай хайрханы мөстөл,мөсөн голын хайлалт 2050 оны үед 40-86% байж, дунджаар 65%-иар хайлах төлөвтэй.
3	Цэвдэг	-Цэвдгийн тархалтын боломжит талбай сүүлийн 45 жилийн (1971-2016) хугацаанд Монгол орны цэвдгийн тархалтын боломжит талбайн хэмжээ 33.7%-аар буурсан болно. Мөн цэвдгийн өмнөд хил Хэнтийн нурууны хэсэгт 178км, Хангайн нурууны хэсэгт 94км хойш шилжсэн бол Алтай нурууны хэсэгт 240-900 м дээш шуугдсан байна.	-Монгол орны цэвдгийн талбай 2050 оны үед 33-61%-иар буурахаар төсөөлөгдөж байна.
4	Бэлчээр, хөрс, газрын доройтол	-Монгол орны бэлчээрийн төлөв байдлыг 2020 оны байдлаар үнэлсэн дүнгээс нийт бэлчээр нутгийн 70% орчим нь ургамлын зүйлийн бүрэлдэхүүн лавлагаа түвшнээсээ өөрчлөгдөж доройтсон байна. - Цөлжилтийн үнэлгээгээр 2020 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9% нь ямар нэг хэмжээгээр цөлжилтөд өртсөн байна. -Газрын бүрхэвчийн 2020 оны үнэлгээгээр цөлийн талбайн эзлэх хувь 2.4%, хээр 2.6%, хуурай хээр 13.9%-аар тус тус нэмэгдсэн бол мөн хугацаанд холимог ойн талбайн хэмжээ 126,084 км.кв-аас 122,692 км.кв, мөнх цасны талбайн хэмжээ 945 км.кв-аас 733 км.кв болж багасав.	-Манай орны хөрсний органик нүүрстөрөгчийн агууламж нийт нутгаар тасралтгүй буурахаар байгаа бөгөөд энэ зууны дунд үед байгалийн янз бүрийн бүсэд 18-28%-иар буурахаар байна.
5	Ойн нөөц	-Ойгоор бүрхэгдсэн талбай 2006-2020 онд 729 мян.га буюу 5.5 хувь хорогдсон. -Шатсан ойн талбай 2006-2020 оны хооронд 939 мян.га буюу 133 хувь нэмэгдэв. -Хөнөөлт шавжид нэрвэгдэж сүйдсэн ойн талбай 2010-2015 оны хооронд 76 мян.га буюу 127 хувь нэмэгдсэн.	-Ойн талбайн өөрчлөлт ирээдүйд 2050 оны үед 0.32% (723.1 км <sup>2</sup> )-иар багасах төлөвтэй.
6	Биологийн олон төрөл зүйл	-Уур амьсгалын өөрчлөлт манай орны амьтны аймгийн бүлгүүдийн зарим зүйл амьтдын амьдрах орчин, идээшил нутагт эерэг болон сөргөөр нөлөөлж байна.	-Том соотгой хөхтний (Plecotus austriacus) голомт нутаг 14.7%, өвөгт тогорууных (Grus virgo) 7.1%-иар тэлэх бол хулан жороо (Podoces hendersoni) шувууных 6.8%-иар буурахаар байна.
7	Мал аж ахуй	Ямаан сүргийн тоо толгой ерээд он гарсаар байнга нэмэгдэж 2020 оны байдлаар нийт сүргийн 41%-ийг эзэлж байна. -Нас гүйцсэн монгол эм хонины амьдын жингийн бууралт ойт хээр, хээрийн бүсэд орших мал аж ахуйн цаг уурын харуулуудын олон жилийн хэмжилтээр илэрч байна. -Уур амьсгалын дулааралтай холбоотой ямааны ноолуур хөөрөх хугацаа хавар 5-10 хоногоор эртэссэн байна -Малыг усалсан өдрийн тоо нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.	-Бэлчээрийн маллагаатай хонин сүргийн өвлийн амьдын жингийн бууралтын хэмжээ 2050 оны үед 4.47 кг хүртэл байна. Малын жингийн бууралт хээрийн бүс төлөөлсөн Баян-Овоо, Баян-Өнжүүл сумдад илүү их байна. -Ган-зуншлага, зудын эрчимшил нэмэгдэж малын зүй бус хорогдол энэ зууны дунд үед гэхэд оны эхэнд байсан сүргийн 5.5% хорогддог болох магадалтай. Ингэж үзвэл энэ

			зууны дунд үе гэхэд малын зүй бус хорогдол өнгөрсөн хугацаанд байсан хэмжээнээсээ 50 гаруй хувиар нэмэгдэх нь байна.
8	Газар тариалан	<p>-Монгол орны хэмжээнд 2020 оны байдлаар газар тариалангийн талбайн 80% нь Төвийн бүсэд, 11% нь зүүн бүс, 9% нь баруун бүсэд байдаг байна. Эдгээр нь голчлон усалгаагүй тариалан бөгөөд тухайн газар орны агро-уур амьсгал болон жил жилийн агро-цаг агаарын нөхцлөөс шууд хамаарч байдаг.</p> <p>-Нэг га-гаас хурааж авсан улаанбуудай, төмсний ургацын олон жилийн явцаас харахад тухайн жилийн цаг агаарын нөхцөлөөс хамааран хэлбэлзэл их хамааралтай хэдий ч 1990 он хүртэл өсөөд түүнээс цааш эрс буурч, 2003 оноос аажмаар өсөж байгаа ерөнхий хандлагатай.</p>	-Буудайн ургац баруун бүсэд 26.1%, төвийн бүсэд 36.0%, зүүн бүсэд 11.0%-иар буурах төлөвтэй, дунджаар 24.4% байна.
9	Аялал жуулчлал	<p>-Сүүлийн хорин жилийн хугацаанд Монгол оронд ирэх жуулчдын тоо тасралтгүй өссөөр 2019 онд хамгийн дээд хэмжээндээ буюу 577.3 мянган жуулчин хүлээн авч байв. Харин 2020, 2021 онд коронавирус (COVID-19) тахлын улмаас жуулчдын тоо огцом буурсан ба 2019 онтой харьцуулахад 95%-иар буурсан.</p> <p>-Аялал жуулчлалын уур амьсгалын индекс (Өмнөговь, Улаанбаатар, Баян-өлгий, Увс, Хөвсгөл) дундаж утга 61.3 буюу тохиромжтой байна.</p>	-Аялал жуулчлалын индекс утга ирээдүйд 3.4%-иар нэмэгдэхээр байна.
10	Дэд бүтэц	<p>-Манай орны зам, шугам сүлжээний газар 2010 онд 407 га байсан бол 2021 онд 477.2 мянган га болж нэмэгдсэн. Үүнээс авто замын 69.2%, төмөр зам 7.5%, агаарын тээврийн газар 2.0%, шугам сүлжээний газар 21.0%-ийг тус тус эзэлж байна.</p> <p>-Сүүлийн 20 жилийн хугацаанд (2000-2020) гамшигт үзэгдлийн давтагдал 2 дахин нэмэгдсэн. 1950 оноос хойш ажиглагдсан хоногт орсон хамгийн их хур тунадасыг хугацаагаар нь ангилж авч үзвэл нийт тохиолдлын 54%-ийг 2000 оноос хойших эрчимтэй тунадас эзэлж байна.</p>	-Хоногт орох хамгийн их хур тунадас Улаанбаатарт 41%, Монгол орны хэмжээгээр 19.2%-иар нэмэгдэхээр байна.
11	Байгалийн гамшиг	<p>-Сүүлийн 30 жилийг 3 арван жилд хувааж, жилийн дундаж давтагдлыг авч үзэхэд 1989-1998 онд 29 удаа, 1999-2008 онд 53 удаа бол сүүлийн 10 жилд 80 удаа тохиолдож хандлага нь нэмэгдэж байна.</p> <p>-Монгол улсад 2001-2021 онд цаг агаарын аюулт, гамшигт үзэгдлийн улмаас 539 хүн амь эрсдэж, 29.773 сая мал хорогдож, 681.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.</p>	<p>-Гангийн давтагдал 5-45%-иар нэмэгдэх, зудын давтагдал 5-40%-иар нэмэгдэхээр байна.</p> <p>-1966 оны үерийн нөхцөл байдлаар 24.9 км<sup>2</sup> талбай үерт автсан байх магадлалтай ба энэхүү талбай ирээдүйд уур амьсгалын өөрчлөлтийн төсөөлөл болох хоногийн хамгийн их хур тунадасны нэмэгдэлтэй холбоотойгоор 2050 онд 20.8%-иар нэмэгдэхээр байна.</p> <p>-Түймэр голомтот эрсдэлтэй зутаг 9%-иар нэмэгдэх төлөвтэй.</p>

12	Нийгмийн эрүүл мэнд	-Хүн амын өвчлөлийн гуравдугаар шалтгаан болсон зүрх судасны тогтолцооны өвчин нийт өвчлөлийн 11.1 хувийг эзэлж байна. -Монгол оронд тархсан шумуулаас Баруун нилийн халуурал, Япон энцефалит, Денгийн халдвар илэрч, улмаар шумуулаар дамжих зарим халдваруудын хүний өвчлөлийн тохиолдол зөөвөрлөгдөн бүртгэгдэж байна.	-Зуны улирлын дулааны долгионы үргэлжлэх хугацаа 2050 оны үед 3.5 хоногоор нэмэгдэхээр байна.
----	---------------------	--	---

Байгаль, нийгэм-эдийн салбарт сонгосон өнөөгийн болон ирээдүйн индикатор үзүүлэлтийг салбаруудын уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээнээс доор байдлаар сонгов. Үүнд:

1. Усны нөөц
  - a. Хойд болон Номхон далайн ай савын гол, мөрний өнөөгийн дундаж урсац, м<sup>3</sup>/с
  - b. Тэдгээрийн ирээдүйн өөрчлөлт
2. Мөстөл, мөсөн гол
  - a. Түргэн, Потанин, Цамбагарав, Сутай хайрханы мөстөл, мөсөн голын хайлалт, см
  - b. Тэдгээрийн ирээдүйн хайлалтын өөрчлөлт
3. Цэвдэг
  - a. Цэвдгийн тархалтын талбайн, мян.км<sup>2</sup>
  - b. Тэдгээрийн ирээдүйн өөрчлөлт (Үндэсний 3 дугаар илтгэлийн үр дүнгээр)
4. Бэлчээр, хөрс
  - a. Хөрсний органик нүүрстөрөгч агууламж, г
  - b. Ирээдүйн өөрчлөлт
5. Ойн нөөц
  - a. Ойн талбай км<sup>2</sup>
  - b. Хортон шавжид нэрвэгдэх талбай, км<sup>2</sup> (Үндэсний 3 дугаар илтгэлийн үр дүнгээр)
  - c. Тэдгээрийн ирээдүйн өөрчлөлт
6. Зэрлэг амьтан
  - a. Голомт нутгийн талбай, км<sup>2</sup>
  - b. Тэдгээрийн ирээдүйн өөрчлөлт
7. Байгалийн гамшиг
  - a. Ган, зудын давтагдал,
  - b. Тэдгээрийн ирээдүйн өөрчлөлт (Үндэсний 3 дугаар илтгэлийн үр дүнгээр)
8. Мал аж ахуй
  - a. Малын амьдын жин, кг
  - b. Ирээдүйн амьдын жингийн өөрчлөлт
9. Газар, тариалан
  - a. Буудайн ургац, кг/га
  - b. Ирээдүйн өөрчлөлт
10. Аялал жуулчлал
  - a. Аялал жуулчлал индексн өнөөгийн утга
  - b. Ирээдүйн өөрчлөлт
11. Дэд бүтэц
  - a. Хоногийн хамгийн их хур тунадас, мм
  - b. Ирээдүйн өөрчлөлт
12. Нийгмийн эрүүл мэнд
  - a. Зуны улирлын хамгийн их температурын 90% хангамшил
  - b. Зуны улирлын дулааны долгионы үргэлжлэх хугацаа


Эдгээр салбаруудын нөлөөллийн тоон үр дүнг НҮБ-ын хүний хөгжлийн индекс ашигласан нормчлох аргыг хэрэглэн нэг хэмжээс рүү шилжүүлж өнөөгийн эмзэг байдлын индекс, ирээдүйн эрсдэлийг индексээр үнэлэв. Индексийн утгыг дараахь 5 ангилалд авч үзэж Монгол орны хэмжээгээр үнэлэв. Ерөнхийдөө салбаруудын өнөөгийн байдал “эмзэг” гэсэн ангилалд багтаж байгаа бөгөөд цаашид 2046-2065 оны үед “их эрсдэлтэй” гэсэн ангилалд орохоор төсөөлөгдөж байна (Хүснэгт 2).

*Хүснэгт 2. Үнэлгээнд ашиглагдсан эмзэг болон эрсдлийн ангилалын босго утга*


№	Доод босго утга	Ангилал Өнөөгийн/ирээдүйн	Дээд босго утга
1	0.81<	Маш их эмзэг/эрсдэлтэй	<1.00
2	0.61<	Их эмзэг/ эрсдэлтэй	<0.80
3	0.41<	Эмзэг/ эрсдэлтэй	<0.60
4	0.21<	Бага эмзэг/ эрсдэлтэй	<0.40
5	0.00<	Эмзэг/ эрсдэлтэй биш	<0.20

Зураг 7-8 -т Монгол орны байгалийн нөөц, нийгэм-эдийн засгийн салбарын эрсдэлийг үзүүллээ. Ерөнхийдөө аялал жуулчлалаас бусад салбаруудад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэл нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл давамгайлах магадлалтай байна. Аялал жуулчлалын хувьд уур амьсгалын аятай байх нөхцөл, ялангуяа өвлийн улиралд нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрсдэл ялимгүй буурахаар байна. Харин бусад салбарын хувьд 1-2 ангилалаар эрсдэлтэй түвшин рүү шилжихээр байна. Тухайлбал бэлчээр хөрс, ойн нөөц, мал аж ахуй салбар 2 ангилалаар, бусад нь 1 ангилалаар эрсдэлтэй түвшин рүү орохоор байна.

Зураг 9-т эдгээр салбаруудын ирээдүйн эрсдэлийн индексийн тоон утгаас одоогийн утгыг хасаж зөрүүг үзүүлэв. Ингэснээр аль салбар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр эмзэг байдал, эрсдэл нь өнөөгийн түвшнээс хэр ихсэхийг харж болно. Харьцангуйгаар газар тариалан, бэлчээр хөрс, ойн нөөц, цэвдэг, мал аж ахуй, дэд бүтэц, мөстөл мөсөн гол зэрэг салбаруудын индексийн утга 0.23-0.38-аар өнөөгийн утгатай харьцуулахад нэмэгдэхээр байна.



Зураг 7. Монгол орны байгалийн нөөцийн салбаруудын ү уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн индекс




Зураг 8. Монгол нийгэм-эдийн салбаруудын уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн индекс

Хүснэгт 3. Байгаль, нийгэм-эдийн засгийн салбаруудын өнөөгийн болон ирээдүйн эмзэг болон эрсдлийн ангилалын өөрчлөлт

№	Салбар	Өнөөгийн эмзэг байдал/эрсдэлийн ангилал	Ирээдүйн эмзэг байдал/эрсдэлийн ангилал (2050)

Байгалийн нөөц			
1	Усны нөөц	3	3
2	Мөстөл мөсөн гол	4	3
3	Цэвдэг	3	2
4	Бэлчээр, хөрс	4	2
5	Ой нөөц	3	1
6	Зэрлэг амьтан	4	3
7	Байгалийн гамшиг	4	3
Нийгэм-эдийн засгийн салбар			
8	Мал аж ахуй	4	2
9	Газар тариалан	3	2
10	Аялал жуулчлал	2	3
11	Дэд бүтэц	4	3
12	Нийгмийн эрүүл мэнд	3	3



Зураг 9. Аймгуудын байгаль, нийгэм-эдийн засгийн салбаруудын уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн индекс

**1.2. Олон улсын конвенц, хэлэлцээрээр Монгол Улсын хүлээсэн үүрэг, хэрэгжүүлэх зорилтууд**

1992 онд “НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц”-ийг НҮБ-ын гишүүн улс орнууд баталсан. Уг конвенцыг хэрэгжүүлэх гол хөшүүрэг болсон “Киотогийн протокол” баримт бичгийг 1997 онд гишүүн орнууд гарын үсэг зурж албажуулсан. Улмаар 2015 онд “Парисын хэлэлцээр”-ийг хэлэлцэж дэмжсэн юм. Парисын хэлэлцээрийн голлох зорилт нь түүнд нэгдсэн улс орнууд хөгжлийн зорилтоо тодорхойлохдоо “тогтвортой хөгжил”-ийг баримталж дэлхийн агаарын дундаж температур өсөлтийг 19 дүгээр зууны дунд үетэй харьцуулахад цельсийн 2 хэмээс хэтрэхгүй байх, цаашлаад 1.5 хэм дотор барих гэж заасан. Энэ зорилттой уялдуулж 2015 онд Парисын хэлэлцээрт нэгдэх сонирхол бүхий улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулах үндэсний зорилтот хувь нэмэр (ҮЗХН) буюу INDC (Intended National Determined Contribution) гэсэн баримт бичгийг боловсруулж Конвенцын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн.

Монгол Улс ҮЗХН баримт бичгээ бусад улс орны нэгэн адил боловсруулж 2015 оны 10 дугаар сард Конвенцын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн бөгөөд 2016 онд Парисын хэлэлцээрийг соёрхон баталсан. Ийнхүү соёрхон баталснаар энэхүү олон улсын гэрээ үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хүчин төгөлдөр болсон<sup>7</sup>.

2016 оны 12 дүгээр сард Парисын хэлэлцээр хүчин төгөлдөр болж улмаар улс орнуудын өмнөө хүлээсэн ҮЗХН буюу INDC баримт бичиг нь Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН) буюу National Determined Contribution (NDC) болж нэгэн адил хэрэгжих болсон.

#### 1.2.1. Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, төлөвлөгөө

Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй. Энэхүү үүргийн хүрээнд Засгийн газар 2019-2030 онд Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор баталж байсан. Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргийн дагуу уг зорилтоо 5 жил тутамд шинэчлэх хүрээнд “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХН 3.0)-ыг шинэчлэн Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор баталсан.

ҮТХН 3.0 нь Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний суурь баримт бичиг бөгөөд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох чиглэлээр илүү амбицтай зорилтуудыг тодорхойлсон.<sup>8</sup> Үүнд:

#### А. Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт, арга хэмжээ:

Үндэсний хэмжээний хүлэмжийн хий ялгарлыг (суурь нөхцөл) эдийн засгийн хөгжлийн өнөөгийн нөхцлөөр хамгийн их ялгаруулагч зургаан тэргүүлэх салбарын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгасан арга хэмжээнд үндэслэн тооцоолж үзэхэд 2010 онд 26.4 сая.тн байсан бол 2035 онд 81.7 сая.тн нүүрстөрөгчийн давхар ислийн эквивалент (СО<sub>2</sub>-экв)-тай тэнцэх хэмжээтэй болж 3.2 дахин өсөх төлөвтэй байна. ҮТХН 3.0-ийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлснээр Монгол Улс хүлэмжийн хийн ялгарлыг суурь түвшинтэй харьцуулахад:

<sup>7</sup> Монгол Улсын Олон Улсын гэрээний тухай хууль,

<sup>8</sup> Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 91 дүгээр тогтоолын хавсралт

- 2030 он гэхэд 23.0 хувиар,
- 2035 он гэхэд 30.3 хувиар тус тус бууруулах зорилтыг дэвшүүлсэн.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд:

- 2030 он: 16,034.9 мян. тн CO<sub>2</sub>-эқв
- 2035 он: 24,735.5 мян. тн CO<sub>2</sub>-эқв хэмжээний ялгарлыг бууруулах боломжтой гэж тооцсон.

Эдгээр зорилтуудыг дараах салбаруудаар тоон үзүүлэлттэйгээр тодорхойлсон болно:

- Эрчим хүчний салбар Эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн салбарт 2030 он гэхэд 5,556.3 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 8,264.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна. Үүнд:
  - Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх (Усан цахилгаан станц, салхин цахилгаан станц, нарны цахилгаан станц, нарны дулааны станц, дулааны насос суурилуулах- 2030 он гэхэд 2,769.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 4,688.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Эрчим хүчний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх (дамжуулалт, түгээлтийн алдагдлыг бууруулах, дулааны цахилгаан станцуудын дотоод цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулах, дулаан хангамжийн үр ашгийг дээшлүүлэх) - 2030 он гэхэд 2,630.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 3,395.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Хатуу түлш солих (Улаанбаатар хотын дулаан хангамжид болон гэр хороололд хийн түлш ашиглах) - 2030 он гэхэд 157.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 181.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Хөдөө аж ахуйн салбарт 2030 он гэхэд 5,277.7 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 9,781.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна. Үүнд:
  - Мал, түүний гаралтай бүтээгдэхүүний эргэлтийг сайжруулж, экспортыг нэмэгдүүлэх - 2030 он гэхэд 4,151.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 7,481.8 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Дотоодын зах зээлд мах нийлүүлэлтийг нэмэгдүүлэх - 2030 он гэхэд 1,126.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 2,299.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Аж үйлдвэрийн салбарт 2030 он гэхэд 1,163.6 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 1,313 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна. Үүнд:
  - Цементийн үйлдвэрүүдийн хаягдал дулааныг ашиглах - 2030 он гэхэд 32.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 39.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Цементийн үйлдвэрлэлд нунтаг үнс ашиглах - 2030 он гэхэд 33.7 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 81.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэх - 2030 он гэхэд 511.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 564.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Эрчим хүчний хэрэглээний хэмнэлтийн менежмент (эрчим хүч хэмнэх техникийн болон техникийн бус арга)-ийг сайжруулах- 2030 он гэхэд 586.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 628.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Зам тээврийн салбарт 2030 он гэхэд 2,762.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 3,465.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна. Үүнд:
  - Евро-5 стандартын шатахуунд шилжих - 2030 он гэхэд 92.3 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 113.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Нүүрсний экспортын тээврийг автотээврээс төмөр замын тээвэрт шилжүүлэх - 2030 он гэхэд 2,459.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 2,940.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Цахилгаан автомашин болон нийтийн тээврийн хэрэглээг нэмэгдүүлэх - 2030 он гэхэд 124.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 266.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Импортын тээврийг төмөр замын тээвэрт шилжүүлэх - 2030 он гэхэд 86.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 145.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв;

- Барилгын салбарт 2030 он гэхэд 633.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 1,066.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна. Үүнд:
  - Ногоон орон сууцны барилга барих - 2030 он гэхэд 102.3 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 146.6 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Эрчим хүчний хэмнэлттэй амины шинэ орон сууц барих - 2030 он гэхэд 57.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 108.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Сургууль, цэцэрлэгийн барилгын дулаан техникийн шинэчлэл, засвар хийх - 2030 он гэхэд 68.8 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 131.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Төсөвт байгууллагын барилгын дулаан техникийн шинэчлэл хийх - 2030 он гэхэд 104.6 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 197.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Монгол гэрийн дулаан алдагдлыг бууруулах, халаалтыг шинэчлэх - 2030 он гэхэд 41.3 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 83.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Амины орон сууц (байшин)-ны дулаан алдагдлыг бууруулах, халаалтыг шинэчлэх - 2030 он гэхэд 206.8 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 300.7 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Угсармал орон сууцны барилгын дулаан техникийн шинэчлэл хийх - 2030 он гэхэд 52.7 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 98.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Хог хаягдлын салбарт 2030 он гэхэд 641.6 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 844.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна. Үүнд:
  - Хог хаягдлыг дахин боловсруулах, дахивар нөөцийн хэрэглээг нэмэгдүүлэх - 2030 он гэхэд 9.7 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 114.3 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Төвлөрсөн хог хаягдлын цэгээс ялгарах метан хийг хоргүйжүүлэх - 2030 он гэхэд 499.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 590.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, өргөтгөх - 2030 он гэхэд 132.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 139.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв;

Нэгдсэн дүнгээр Монгол Улс үндэсний хүлэмжийн хийн ялгарлыг нийт ялгаруулах суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 16,034.9 мян.тн, 2035 он гэхэд нийт 24,735.4 мян.тн нүүрстөрөгчийн давхар ислийн эквивалент (CO<sub>2</sub>-эқв)-тай тэнцэх хэмжээгээр бууруулна.

Үүнээс гадна ойн шингээлтийг нэмж тооцсоноор Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн хэмжээ 2030 онд 48.6 сая.тн CO<sub>2</sub>-эқв, 2035 он гэхэд 60.1 сая.тн CO<sub>2</sub>-эқв. тус тус байхаар байна. Ойн шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар үндэсний түвшинд нүүрстөрөгчийн хийн шингээлтийг 3.3 сая.тн-оор нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Үүнийг тооцож үзвэл Монгол Улс нийт хүлэмжийн хийн ялгарлыг 2035 он гэхэд хүлэмжийн хийн ялгарал болон шингээлтийн суурь түвшинтэй нь харьцуулахад 46.3%-иар бууруулах боломжтой.

### **В. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нөхцөлт арга хэмжээ:**

Дээрх эрчим хүчний болон эрчим хүчний бус салбаруудад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнээс гадна Монгол Улс өөрийн хүчин чармайлтаар хэрэгжүүлэх боломж одоогоор байхгүй боловч хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад ихээхэн нөлөө үзүүлэх зарим арга хэмжээг “нөхцөлт арга хэмжээ” байдлаар тодорхойлов. Үүнд:

- Эрчим хүч: Дараах усан цэнэгт цахилгаан станц (УЦЦС) барих төслийг хэрэгжүүлснээр 2035 он гэхэд 386.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна. Үүнд:
  - Сэлэнгэ аймгийн Жавхланта УЦЦС (100 МВт): 193.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Хэнтий аймгийн Цэнхэрмандал УЦЦС (100 МВт): 193.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Барилга: Эрчим хүчний үр ашигтай, ногоон барилга, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлснээр 2035 он гэхэд 613.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна.
  - Ногоон барилга, ногоон орон сууц: 215.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - 15-100 кВт усан халаалтын зуух шинэчлэх: 174.8 мян.тн CO<sub>2</sub>-эқв;

- Барилгын дулаан хангамжид сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх: 224.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Хөдөө аж ахуй: Малын эдийн засгийн эргэлт, үүлдэр, ашиг шимийг сайжруулах замаар 2035 он гэхэд 1,881.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна.
  - Хонины мах, ноос экспортлох: 398.4 + 99.6 = 498.0 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Ямааны мах, ноолуур экспортлох: 631.3 + 157.8 = 789.1 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - Адууны мах экспортлох: 594.2 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Аж үйлдвэр: Технологийн шинэчлэл, CO<sub>2</sub> барих технологи нэвтрүүлснээр 2035 он гэхэд 974.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна.
  - Цементийн үйлдвэрт нунтаг жонш ашиглах: 197.5 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - CO<sub>2</sub> ялган авч, газрын гүнд булшлах (CCS): 777.4 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Хог хаягдал: Дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх болон цэвэрлэх байгууламжийн шинэчлэл хийснээр 2035 он гэхэд 85.7 мян.тн CO<sub>2</sub>-эқв-аар бууруулна.
  - Бүсийн төвүүдэд дахин боловсруулах үйлдвэрүүд барих: 13.9 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
  - 6-аас доошгүй аймгийн төвд цэвэрлэх байгууламж барих: 71.8 мян.тн CO<sub>2</sub>-эқв;
- Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 129,339,500 га талбай бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байна (Газрын харилцаа, геодези зураг зүйн газар, 2024).
  - Цөлжилт, газрын доройтол болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр бэлчээрийн хөрсний нүүрстөрөгч шингээх чадвар алдагдаж байгааг Цаг уур, орчны шинжилгээний газар ын болон Газрын харилцаа, геодези зураг зүйн газар -ын олон жилийн судалгааны дүн нотолж байна. Бэлчээрийн улирлын сэлгээ нүүдлийг эрчимтэй хийх, хүчтэй доройтсон бэлчээрийг урт хугацаагаар өнжөөх, малын хөлийн ачааллыг зохицуулах уламжлалт арга технологийг үр дүнтэй хэрэгжүүлэн, ойт хээр, хээрийн хүчтэй доройтсон бэлчээрийн 10-аас доошгүй хувийг нөхөн сэргээж, хүлэмжийн хийн шингээх чадварыг нөхөн сайжруулах боломжтой.

### С. Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох зорилт:

Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эрсдэл, эмзэг байдлыг бууруулж, дасан зохицох, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд улсын хэмжээний бодлого, төлөвлөгөө, салбарын хөгжлийн хөтөлбөрүүдийг уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг харгалзан хэрэгжүүлэх, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн эмзэг салбаруудын уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг даван туулах чадамжийг сайжруулах зорилгоор дасан зохицох зорилт, арга хэмжээг дараах салбар бүрээр тодорхойлов. Үүнд:

- Биологийн олон янз байдал: Экосистем, биологийн олон янз байдлын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нөхцөлийг бүрдүүлж, хамгааллыг сайжруулна;
- Усны нөөц: Усны нөөцийг оновчтой ашиглаж, хамгаалж, нөхөн сэргээж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлнэ;
- Ойн нөөц: Ойн тогтвортой менежмент хэрэгжүүлж, ойн экосистемийн тэсвэрт чанарыг хамгаалж, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлнэ;
- Гамшгаас хамгаалах: Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулж, эрт сэрэмжлүүлэх тогтолцоог хөгжүүлэн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ;
- Мал аж ахуй, бэлчээр: Бэлчээрийн даацад нийцсэн, эрсдэл даах чадавхтай, тогтвортой мал аж ахуйг хөгжүүлнэ;
- Газар тариалан: Хөрсний үржил шимийг хамгаалж, уур амьсгалд тэсвэртэй, бүтээмжтэй газар тариаланг хөгжүүлнэ;
- Нийгмийн эрүүл мэнд: Уур амьсгалын өөрчлөлтийн эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг судалж, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна;

- Иргэдийн амьжиргаа, нийгмийн хамгаалал: Зорилтот бүлгийг тодорхойлж, тэднийг чадавхжуулах, эрсдэлт байдлаас урьдчилан сэргийлэх, халамж, хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ;
- Боловсрол: Уур амьсгалын талаарх мэдлэг, ойлголт, чадавхыг нэмэгдүүлж, хүүхэд, залуусын оролцоо, манлайллыг дэмжинэ;
- Соёлын салбар: Соёлын биет болон биет бус өв, уламжлалт соёл, мэдлэгийг хамгаалж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тогтолцоог бий болгоно.

#### D. *Салбар дундын зорилт, арга хэмжээ:*

- Хууль, эрх зүй, бүтэц зохион байгуулалтын чадавх: Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтын чадавхыг сайжруулна;
- Санхүүжилт: Үндэсний болон олон улсын санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн тогтвортой механизмыг бүрдүүлнэ;
- Жендер ба нийгмийн оролцоо: Нийгмийн бүх бүлгийг (эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эмзэг бүлэг г.м.) тэгш хамруулах, жендерийн мэдрэмжтэй уур амьсгалын бодлого хэрэгжүүлнэ;
- Мэдлэг ба боловсрол: Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх судалгааг өргөжүүлж, түүний үр дүнд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжинэ.

2025 оны Засгийн газрын 91 дүгээр тогтоолын 2 дугаар заалтаар зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, салбар дундын уялдааг хангаж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын Шадар сайд нарт, шинэчлэн баталсан зорилтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад тус тус даалгасан байна. Мөн тогтоолын 3 дугаар заалтаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох салбар тус бүрийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан байна.

ҮТХН 3.0-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө болон санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн БОУАӨЯ эцэслэн боловсруулж, 2026 оны 2 дугаар улиралд багтаан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ҮТХН-ийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн 90 хувь нь гадаадын зээл тусламжаар, үлдсэн 10 хувь улс, орон нутгийн төсвөөс санхүүжихээр тусгагдсан, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбар яамдын оролцоо голлох үүрэгтэй байгаа бөгөөд салбар яамдын хамтран хэрэгжүүлэх арга хэмжээнүүд ихэнх байна. Санхүүжилт хангалтгүй болон салбар яамдын чиг үүргийн оновчтой тогтолцоог бий болгохгүйгээр тус төлөвлөгөө хэрэгжихэд хүндрэлтэй байна. Иймд ҮТХН-ийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах тогтвортой санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, салбар хариуцсан яамдын чиг үүргийг тодорхойлох шаардлагатай байна.

### **1.3. Төрийн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үүрэг**

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон тооны бодлогын баримт бичгүүдийг батлан гаргасан бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг үнэлсэн, үнэлгээнд тулгуурлаж санал, дүгнэлт, зөвлөмж гаргасан тайлан, судалгаа цөөн байна.

2011 онд УИХ-аас баталсан Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр 10 жилийн хугацаанд 2 үе шаттай хэрэгжээд 2021 онд дууссан. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, түүнээс сургамж авах, цаашид анхаарах асуудлын талаарх тайлан, илтгэл байхгүй байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050”-д II үе шат буюу 2031-2040 онд уур амьсгалын өөрчлөлтийн шинэ хэлэлцээрийн хүрээнд хүлэмжийн хийн үндэсний ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлнэ, III үе шат буюу 2041-2050 онд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийн зөрүүг тэглэнэ гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд зааснаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 7 зорилтот хөтөлбөртэй байхаар тус хуульд тусгагдсан ба эдгээр хөтөлбөрийн нэг нь “Байгаль орчны зорилтот хөтөлбөр” юм. Уур амьсгалын өөрчлөлт нь зөвхөн байгаль орчны бодлого төдийгүй, хөдөө аж ахуй, эрчим хүч, уул уурхай, барилга, хот байгуулалт, эрүүл мэнд зэрэг эдийн засгийн бүхий л салбарт хамааралтай буюу салбар дундын асуудал болж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “3.4.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилтийн хүрээнд хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна, уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах, хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх зах зээлийн болон зах зээлийн бус хэрэгслийг ил тод, байгаль орчны үр нөлөөг тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Гэж заасан.

Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд “1.4.Ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангана. 1.4.1.1.Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна, эрчим хүчний хэмнэлттэй, гамшигт тэсвэртэй, дэвшилтэт технологи бүхий амины болон нийтийн орон сууц, дэд бүтцэд олгох ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ, ногоон хэрэглээг нэмэгдүүлэх бодит хөшүүргүүдийг үе шаттай бий болгож, төрийн худалдан авалтад ногоон худалдан авалтыг дэмжинэ, байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай үйлдвэр, технологийг хөгжүүлэн, ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.” гэж заасан.

## **1.4. Хууль тогтоомж**

### **1.4.1. Агаарын тухай хууль**

Монголд Улсад Уур амьсгалын өөрчлөлтийн тухай бие даасан хууль байхгүй Агаарын тухай хуулиар зарим асуудлыг зохицуулж байна. Агаарын тухай хуулийн зорилго нь хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын

хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой суурь харилцааг зохицуулах зорилгогүй байна. Агаарын тухай хуульд тусгагдсан Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хэм хэмжээний зохицуулалт, түүний хэрэгжилттэй холбоотой асуудлыг дараах байдлаар тоймлон авч үзлээ. Үүнд:

1. Хуулийн нэр томъёонд зөвхөн “хүлэмжийн хий”-г тодорхойлж тусгажээ. Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарал, шингээлт гэх мэт бусад нэр томъёог тодорхойлоогүй байна:
2. Тус хуулийн 6.1.2-т заасны дагуу Засгийн газар нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц /цаашид “Конвенц” гэх/-ийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, экологийн эмзэг байдлыг болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдсон арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий Уур амьсгалын үндэсний хороо байгуулах бүрэн эрхтэй. 2024 оны байдлаар Уур амьсгалын үндэсний хороог Монгол Улсын Шадар сайд тэргүүлж ажиллах бүтэц, ажиллах журмыг шинэчилсэн байна.
3. Тус хуулийн 24.1 дэх хэсгийн Уур амьсгалын өөрчлөлтийн ажлын албаны талаарх тусгайлсан заалтыг 2015 онд хүчингүй болгож ажлын албыг татан буулгажээ.
4. Мөн тус хуулийн 24.3-т “аж ахуйн үйл ажиллагааны явцад хүлэмжийн хийг ихээр ялгаруулах эх үүсвэрээс ялгарах хүлэмжийн хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг төрийн захиргааны төв байгууллага холбогдох бусад байгууллагатай хамтран батлах”-аар тусгасан хэдий ч одоо болтол тус журам батлагдаагүй байна.

Дээрхээс үзэхэд Агаарын тухай хууль нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгогүй нөгөө талаар уг хуульд уур амьсгалын өөрчлөлттэй бусад зохицуулалт тусгагдаагүйтэй холбоотойгоор уур амьсгалын өөрчлөлтийн хууль, эрх зүйн орчныг бий болгож чадаагүй байна.

#### 1.4.2. Ойн тухай хууль

ҮТХН-ийн ойн хүлэмжийн хийн ялгарлын шингээлтийг 2030 11% нэмэгдүүлэх, 2030 он гэхэд ойгоор бүрхсэн талбайг 9%-д хүргэх, Засгийн газраас Тэрбум мод хөтөлбөр хэрэгжүүлэх, ойн түймрийн дундаж талбайг 2025 онд 35%, 2030 онд 70% хүртэл бууруулна, ойн хөнөөлт шавж, өвчний хөнөөлийн тархалтын голомтыг 2025 онд 50% хүртэл бууруулж, 2030 онд бүрэн хяналтад авна гэсэн зорилтууд тусгагдсан байна.

Гэтэл Ойн тухай хуульд ойн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, ойн бүтэц, төлөв байдлыг сайжруулж, тэсвэрлэх чадавхи болон хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, зарчмын талаарх зохицуулалт бүрэн тусгагдаагүй байна.

#### 1.4.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

Тус хуулийн 3.1.3-т "байгаль орчны стратегийн үнэлгээ" гэж улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлохыг гэсэн байх бөгөөд одоогоор нэг ч бодлого, төлөвлөгөө, баримт бичигт стратегийн үнэлгээ хийгдээгүй байна. Мөн байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийн үнэлгээний асуудлыг зохицуулаагүй байна.

#### 1.4.4. “Эрчим хүчний тухай хууль”, “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль”, “Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль”

Эрчим хүчний салбарын хүрээнд хийн ялгарлыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах үндэсний эрх зүйн тогтолцоог бий болгох, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийг хүлэмжийн хийд хувиргаж тооцдог зохицуулалт, эрчим хүчний хэмнэлтийг CO<sub>2</sub>-ээр хэмжиж эхлэх, холбогдох аргачлалыг батлах тухай зохицуулалт тус тус тусгагдаагүй, нүүрсхүчлийн зах зээлийг хүлэмжийн хийн хэмжилт, бүртгэлийн тогтолцоотой уялдуулан хөгжүүлэх зэрэг зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

#### 1.4.5. Хөдөө аж ахуй, газар тариалангийн багц хууль

Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын хүрээнд хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг хэмжих, тайлагнах, баталгаажуулах хууль эрх зүйн тогтолцоог бүрдээгүй, карбон зах зээлийн болон энэ хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн нөлөөллийг үнэлэх, нөлөөллийг бууруулах, дасан зохицох төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийг үнэлэх зэрэг зохицуулалт байхгүй байна.

#### 1.4.6. Барилгын тухай хууль

Барилгын тухай хуульд барилга байгууламж, үйл ажиллагаанаас ялгарч болох хүлэмжийн хийн хэмжээг тооцох болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулахтай холбоотой зохицуулалт тусгагдаагүй байна.

#### 1.4.7. Гамшгаас хамгаалах тухай хууль

Тус хуульд уур амьсгалын өөрчлөлийг сааруулах, даван туулах бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээтэй холбоотой болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, уур амьсгалын төсөөллийн мэдээллийг гамшгийн эрсдэлийн төлөвлөлтөд харгалзан үзэх зэрэг зохицуулалт тусгагдаагүй байна.

#### 1.4.8. Эрүүл мэндийн тухай хууль

Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгаа, үнэлгээ хийх, түүнийг дасан зохицох төлөвлөлтөд ашиглах хууль, эрх зүйн орчны зохицуулалтыг бий болгох болгох, уур амьсгалын өөрчлөлт, хоол тэжээл, хүнсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийх зохицуулалт байхгүй байна.

#### 1.4.9. Статистикийн тухай хууль

Хүлэмжийн хийн ялгарлын тооллогын мэдээ, мэдээлэл хангалтгүй, хуулийн зохицуулалтгүй байгаа тул тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар холбогдох мэдээ мэдээллийг хуульд заасан шаардлагад нийцүүлэн цуглуулах, сайжруулах асуудлыг тусгах шаардлагатай.

### **1.5. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой процессын хувьд зохицуулах шаардлагатай асуудлууд**

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулахтай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалтыг бүрэн бүрдүүлээгүй, хийдэлтэй, зарим арга хэмжээг нэг удаагийн шинжтэй тогтоол, шийдвэрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа тул дараах харилцааг хууль, эрх зүйн хүрээнд хуульчлан зохицуулах шаардлагатай байна.

- Төрийн байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулахтай холбоотой харилцааны хүрээнд гүйцэтгэх болон хариуцах чиг үүргийг хуульчлах;
- Салбар дундын зохицуулалт, түүнийг хариуцах байгууллага байгуулах, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох асуудлыг шийдвэрлэх;
- Үндэсний болон салбарын түвшинд мэдээлэл солилцох, гаргаж өгөх асуудлыг зохицуулж, мэдээллийн сангийн асуудлыг нэмж тусгах;
- Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн баримт бичгийг боловсруулах (ҮТХН), түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хянах, мөшгөх, үнэлэх, тайлагнах процессыг хуульчлах;
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх үндэсний Хэмжих, Тайлагнах, Баталгаажуулах (ХТБ) тогтолцоог бий болгох, процессын зохицуулалтыг салбаруудын үйл ажиллагаатай уялдуулан нэгдсэн зохион байгуулалтаар хангах;
- Карбон зах зээлийн хэлбэр, карбон кредитийг үүсгэх, баталгаажуулах, бүртгэх, эзэмших, шилжүүлэгтэй холбоотой харилцааг хуульчлах.
- Хуульд тодорхойлон заасны үндсэн дээр зарим харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулах асуудлыг тусгах.

## **1.6. Зайлшгүй үүсгэх шаардлагатай тогтолцоо, институц, хүний нөөцийн дүн шинжилгээ**

### 1.6.1. Хүлэмжийн хийн тооллого болон ҮТХН-ийн хэрэгжилтийн ил тод байдал, хэмжиж, тайлагнах, нотлох тогтолцоо

НҮБУАӨСК-ын Киотогийн протоколын хүрээнд Монгол Улс үндэсний хүлэмжийн хийн тооллогыг IPCC-ийн зааврын дагуу боловсруулж, тогтмол хүргүүлж байх, ил тод байдлын тогтолцоог бүрдүүлэх үүргийг тус тус хүлээсэн. Ил тод байдал нь уян хатан-ҮТХН, ил тод, тогтмол давтамжтай, нотлох/нягтлах шаардлагуудтай байх ба ҮТХН-ийн хэрэгжилтийг хангах, үнэлэх, тодорхойлох гол арга зам байна.

Цаашид Парисын хэлэлцээрийн дагуу заавал мөрдөх буюу албан ёсны шаардлага, хангахыг зөвлөж буй шаардлага болон сайн дурын нэмэлт шаардлага тус бүрд нийцсэн дараах мэдээллийг Ил тод байдлын тайланд тусган, 2024 оноос хойш 2 жил тутамд НҮБУАӨСК-ын Нарийн бичгийн газарт хүргүүлэх үүргийг мөн Монгол Улс хүлээсэн. Үүнд:

- Суурь мэдээлэл;
- Үндэсний Хүлэмжийн хийн тооллого;
- Үндэсний хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийн явц ба түүний хураангуй;
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл ба дасан зохицохуй;
- Дэмжлэгийн хэрэгцээ ба дэмжлэг авсан талаарх мэдээлэл;
- Нүүрстөрөгчийн санхүүжилт ба Олон улсад шилжүүлсэн сааруулах үр дүн (ITMOs).

Хэмжих, тайлагнах, нотлох (ХТН) нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тоо мэдээ, мэдээллийг үнэлэх, тооцох, хянаж, шинжлэн, ил тодоор тайлагнадаг механизм бөгөөд үүнийг үр дүнтэй хэрэгжүүлснээр үндэсний, орон нутгийн түвшинд, иргэд, аж ахуйн нэгж, үйлдвэрийн

салбарууд буюу бүх оролцогч талууд хүлэмжийн хийн ялгарлаа бууруулж, ялгарал багатай үйл ажиллагаа руу шилжих боломжийг бүрдүүлдэг суурь ойлголт юм.

Монгол Улсын хувьд энэхүү тогтолцоог улсын хэмжээнд сайжруулах, ҮТХН-ийн хэрэгжилтийг бодиттойгоор үнэлэхэд дараах хүндрэл тулгарч байна. Үүнд:

1. ХТН үйл ажиллагаа, тогтолцоо нь НҮБУАӨСК-ын тайлагнах тогтолцоо дээр төвлөрсөн байдаг бөгөөд уур амьсгалын арга хэмжээний мэдээллийг үндэсний хүлэмжийн хийн тооллогод тусгах, үр дүнг магадлан нотлох чиглэлд төвлөрөөгүй байдаг. Иймд энэхүү тайлагнах тогтолцоог үндэсний түвшинд тодорхойлж, талуудын хүлээх чиг үүргийг тодорхой хугацаатайгаар тодорхойлох шаардлагатай байна.
2. Хэмжих: Үндэсний хүлэмжийн хийн тооллого хийх болон уур амьсгалын өөрчлөлтийг хянаж, шинжлэх зорилготой нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх. Тухайлбал, Үндэсний статистикийн хороо, Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн болон Байгаль орчны мэдээллийн төв, Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газар, Ойн судалгаа хөгжлийн төв, Эрчим хүчний зохицуулах хороо гэсэн байгууллагуудын мэдээллийг зөвхөн үндэсний хүлэмжийн хийн тооллого хийхэд ашигладаг бөгөөд уг тооллогыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв (УАӨСХАТ) ТӨААТҮГ олон улсын санхүүжилт, төсөл хөтөлбөрийн хүрээнд хариуцан гүйцэтгэж байна.
3. Тайлагнах: Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх салбар дундын, нэгдсэн судалгаа, төлөвлөлт нь зөвхөн байгууллага хооронд санамж бичиг байгуулах замаар зохицуулагдаж байна. Мөн НҮБУАӨСК-д хүргүүлэх тайланг боловсруулах ажлыг гүйцэтгэх хүний нөөц болон техникийн чадавх хязгаарлагдмал, сул хэвээр байна.
4. Нотлох: Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлын тооллогыг (2017) Конвенцын 20/СР.19 шийдвэрийн дагуу IPCC-2006 арга зүйг баримтлан үндэсний түвшинд боловсруулан хүргүүлсэн ба уг тооллогод олон улсын түвшинд Олон улсын мэргэжилтнүүдийн баг дүн шинжилгээ (ICA)-г хийн баталгаажуулж, цаашид сайжруулах зөвлөмж өгсөн байна. Харин чанарын баталгаа (QA)-г хүлэмжийн хийн ялгарлын тооллого хийж гүйцэтгэсэн баг гүйцэтгэдэг. 2017 оны тооллогыг бие даасан зөвлөх баг нягталсны дараа НҮБУАӨСК-д хүргүүлсэн. Үндэсний чанарын баталгааны зөвлөх нь нийт тооллогыг бүхэлд нь нягталж, ингэхдээ мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдал, нарийвчлал зэргийг магадлан, нотолдог. Энэхүү багийг хүлэмжийн хийн тооллогын адил мэргэжлийн Зөвлөхүүдээс бүрдүүлж төслийн хэмжээнд санхүүжүүлж байгаа бөгөөд цаашид салбарын яам, мэргэжилтнүүдийн оролцоотой байгуулах шаардлагатай байна.
5. ХТН тогтолцооны санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, зөвхөн төсөл хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлж байгаа тул цаашид тогтмол санхүүжилтийг бий болгох хэрэгтэй байна.
6. Одоогийн тогтолцоо нь олон улсын дэмжлэгтэй төслийн санхүүжилтээс бүрэн хамааралтай буюу төвлөрсөн тогтолцоотой, ганц байгууллага болох УАӨСХАТ-д хариуцуулж, бусад төрийн байгууллагын чиг үүрэг хуулиар тодорхойлогдоогүй тул оролцоо байхгүй байна.
7. Үндэсний онцлогт тохирсон Ил тод байдлын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлж, тогтвортой байдлаар хөгжүүлэхэд боловсон хүч, санхүү болон технологийн нөөц бололцоог эрх зүйн орчин бүрдүүлэх замаар шийдвэрлэх;

2021 онд боловсруулсан “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”- ний тайланд үндэсний

хэмжээнд хүлэмжийн хийн ялгарлын тооллого болон ҮТХН-ийн хэрэгжилтийг ил тодоор хэмжих тайлагнаж нотлох одоогийн тогтолцоог<sup>9</sup> өөрчлөх хувилбарыг<sup>10</sup> гаргажээ.

### 1.6.2. Уур амьсгалын үндэсний хороо

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д Үндэсний хороо байгуулах бүрэн эрхийг Засгийн газарт олгосон хэдий ч өнгөрсөн хугацаанд Уур амьсгалын үндэсний хороог өөр хэлбэрээр байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах зэргээр тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлээгүй байна. 2019 онд Засгийн газар Уур амьсгалын үндэсний хороог Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ахлуулан байгуулсан байна. Үндэсний хорооны дарга нь 2019 оны 01 тоот тогтоолоор Үндэсний хорооны дүрмийг, 2021 оны 01/21 тоот тогтоолоор “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан байна. Мөн Үндэсний хорооны 2021 оны 02/21 тоот тогтоолоор Үндэсний хорооны дэргэд ажиллах Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталжээ.

Засгийн газрын 2023 оны 155 тоот тогтоолоор Уур амьсгалын Үндэсний хорооны ажиллах журмыг, 2024 оны 21 дүгээр тогтоолын 27 дугаар хавсралтаар бүрэлдэхүүнийг тус тус баталж, одоогийн байдлаар Монгол Улсын Шадар сайд хороог даргалах бүтэцтэй байна.

Үндэсний хороо нь орон тооны бус, зөвлөмжийн шинжтэй салбар дундын зохицуулалтыг дэмжих чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд чиг үүргийн хувьд Засгийн газрын чиг үүрэгтэй давхцал үүсгэж байгаа тул хуулийн төслөөс Үндэсний хороотой холбоотой зүйл заалт, зохицуулалтыг хассан болно. Цаашид салбар дундын зохицуулалтыг нэгдсэн байдлаар Засгийн газрын зүгээс зохицуулах нь үр дүнтэй.

### 1.6.3. Уур амьсгалын өөрчлөлт, судалгаа, хамтын ажиллагааны төв

Засгийн газрын тогтоолоор Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохицуулах зорилгоор 2011 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын удирдлага дор Уур амьсгалын өөрчлөлтийн ажлын албыг байгуулсан. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор БОНХАЖЯ (хуучин нэрээр) нь 2015 онд Уур амьсгалын өөрчлөлтийн ажлын албанд түшиглэн Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж (УАӨТХН)-ийг Байгаль хамгаалах сан (хуучин нэрээр)-гийн харьяанд байгуулсан ба 2021 оныг хүртэл Байгаль орчин, уур амьсгалын сангийн дор үйл ажиллагаагаа явуулж байсан.

2020-05-20-нд “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг Засгийн газрын 181 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн чиг үүргийг 2021 оны Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/37 тушаалаар Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвд шилжүүлсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв нь төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар харьяалагдаж, БОАЖЯ-ны мэргэжил, арга зүйн удирдлага дор ажиллахаар дүрэмд тусгажээ. Мөн тус төв нь олон улсын Уур амьсгалын ногоон сангийн итгэмжлэгдсэн байгууллага,

---

<sup>9</sup> Хавсралтаар оруулав.

<sup>10</sup> Хавсралтаар оруулав.

Монгол Улс болон Япон Улсын Засгийн газар хоорондын “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” хэлэлцээрийн хүрээнд Хамтарсан кредит олгох механизмын нарийн бичгийн газрын үүргийг гүйцэтгэх байгууллага, “Уур амьсгалын үндэсний хороо”-нд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, Уур амьсгалын нөхцөл байдал, өөрчлөлтийн чиглэлээр эдийн засаг, нийгмийн салбар дамнасан олон улсын дэмжлэг, санхүүжилт бүхий төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Тус төв нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статустай болохын хувьд үйл ажиллагааны орлогоосоо санхүүжих бөгөөд энэ нь судалгаа, шинжилгээ, тайлан, мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байгаа бөгөөд цаашид тус байгууллагын гүйцэтгэж буй чиг үүрэгт тохирсон эрх зүйн статустай болгох, санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Тус төвийн гүйцэтгэж буй чиг үүргийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх холбогдох аргачлал, заавар, дүрэм, журмыг эрх бүхий байгууллагуудаас батлах шаардлагатай байгаа тул эдгээр нийтээр дагаж мөрдөх хэм, хэмжээний актыг батлах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

#### 1.6.4. Байгаль орчин, уур амьсгалын сан

Байгаль орчин, уур амьсгалын сан нь “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлд заасныг үндэслэн Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор анх “Байгаль Хамгаалах Сан” нэртэйгээр байгуулагдсан. Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор “Байгаль Хамгаалах Сан”-гийн зохион байгуулалт, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж бие даан үйл ажиллагаа явуулсан. 2019 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж “Байгаль хамгаалах сан”-гийн үйл ажиллагааг өргөтгөн “Байгаль орчин, уур амьсгалын сан” болгон өөрчлөн байгуулсан байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн эх үүсвэр нь улсын төсвөөс санхүүждэггүй бөгөөд хуульд заасны бүрдүүлэх эс үүсвэрүүдийн орлого хангалттай бус байна. Тухайлбал, 2017-2021 оны дундаж жилийн орлого нь 160.0-230.0 сая төгрөгийн хооронд байна. Мөн тус хуулийн дагуу сангийн орлогыг 11 төрлийн арга хэмжээнд зарцуулахаар заасан бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагаанд “дэмжлэг үзүүлэх” гэсэн ерөнхий зохицуулалт тусгагдсан байгаа ч ямар арга хэмжээнд яаж зарцуулах нь тодорхойгүй байна. Тус сангийн орлогоос Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулах цогц арга хэмжээнд зарцуулаагүй байна.

#### 1.6.5. Хүний нөөцийн бодлого

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг нарийн мэргэжлийн боловсон хүчний оролцоогүйгээр төлөвлөх, үнэлэх, хэрэгжүүлэхэд төвөгтэй бөгөөд олон улсад мэргэжлийн байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагад тусгайлан бэлтгэгдсэн нарийн мэргэжлийн болон салбарын мэргэжилтнүүдэд нэмэлт сургалтын хүрээнд бэлтгэж байна. Харин Монгол Улсын хувьд энэ талаар дараах анхаарах асуудлууд байна.

1. ҮТХН-ийн баримт бичигт тусгагдсан дүгнэлтээс үзэхэд энэ талын мэргэжилтнүүд дутагдалтай байгаа бөгөөд тэдний нийгэм, эдийн засгийн эрх зүйн баталгааг хангах, салбарын хүрээнд тогтвортой ажиллуулах хэрэгцээ шаардлагатай байна.
2. Тухайн салбар яамдын тухайн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг нэмэлт сургалтад хамруулах, ажлын байрны чиг үүрэгт уур амьсгалын асуудлыг хариуцахаар нэмэлт

оруулах, цалингийн тодорхой хувийн нэмэгдэл оруулах асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх нь чухал байна.

3. Олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн хүрээнд цөөн тооны мэргэжилтнүүдийн хүрээнд ҮТХН-ийн баримт бичгийг боловсруулах бус салбар яамд болон холбогдох байгууллагуудын оролцоо, санал, санаачилга шаардлагатай байна.
4. Уур амьсгалын Үндэсний хороо, салбар яамд, нийслэл, орон нутаг, УАӨСХАТ, Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн болон салбарын мэргэжлийн байгууллагууд, иргэн, аж ахуйн нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох хэрэгцээ шаардлага байна.

#### 1.6.6. Олон улсын хамтын ажиллагаа, мэдээллийн сан

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Олон улсад Монгол Улсыг төлөөлөн Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан Тусгай элч ажиллаж байна. НҮБУАӨСК-ийн талуудын бага хурлуудад үндэсний хорооны дарга, конвенцын үндэсний зохицуулагч болон БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагааны газар, зарим тохиолдолд том хэмжээний төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй оролцож, бүрэлдэхүүнд нь Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын болон хувийн хэвшлийн төлөөлөл оролцож байна.

Гадаад харилцааны яамны оролцоо, түүний төлөөллийн эрхийг хууль, эрх зүйн хүрээнд тодорхой болгох, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Монгол Улсыг төлөөлөх “Мандат”-ыг хэрхэн тодорхойлох, эрх, үүрэг, хариуцлагын талаарх тусгайлсан зохицуулалтыг бий болгох нь зүйтэй юм.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой төсөл, хөтөлбөрүүдийг олон яамд, агентлагууд зэрэг бүртгэж байна. Сангийн яам Олон улсын зээл, тусламжаар хэрэгжиж буй уур амьсгалын чиглэлийн төслүүдийн мэдээллийг авдаг, нэгэн зэрэг Даян дэлхийн байгаль орчны сан, Уур амьсгалын ногоон сан, Дасан зохицох сан, Хамтарсан кредит олгох механизмын хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн мэдээллийг БОАЖЯ хариуцдаг, ашгийн төлөөх төслүүдийг Монгол банк хариуцдаг зэрэг асуудлыг цэгцлэн, тэдгээрийн хэрэгжилтийн уялдаа, холбоог хангах тал дээр анхаарах шаардлагатай байна.

#### **1.7. Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүгийн тогтолцоо**

Монгол Улсын тэгш хүртээмжтэй ногоон шилжилтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн хэмжээ их тул улсын болон хувийн санхүүгийн эх үүсвэрийн аль алиных нь оролцоо зайлшгүй шаардлагатай. Ногоон шилжилтэд 2024 оноос 2050 онд цэвэр өнөөгийн үнэ цэнээр (NPV) 10.2 тэрбум ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай. Үүнээс сааруулах арга хэмжээний хөрөнгө оруулалтын хэрэгцээ 6.7 тэрбум ам.доллар буюу жил бүр ДНБ-ий 0.7 хувьтай тэнцэх бол дасан зохицох арга хэмжээний хөрөнгө оруулалтын хэрэгцээ 3.5 тэрбум ам.доллар буюу жил бүр ДНБ-ий 0.4 хувьтай тэнцэнэ.<sup>11</sup>

Монгол Улсын ҮТХН 3.0-ийг 2025 оноос 2035 онд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг 53.46 их наяд төгрөг буюу 2025 оны 8 дугаар сарын албан ханшаар ойролцоогоор 14.84 тэрбум ам.доллар гэж тооцсон. Энэхүү хэрэгцээ нь ҮТХН 3.0-д туссан сааруулах болон

---

11 Дэлхийн Банк - Монгол Улсын уур амьсгал, хөгжлийн тайлан

дасан зохицох арга хэмжээг хамрах бөгөөд Монгол Улс дотоодын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр хүлээсэн нөхцөлт бус болон олон улсын дэмжлэгтэйгээр нөхцөлт зорилтыг нь илэрхийлнэ.<sup>12</sup>

Сааруулах арга хэмжээний хэрэгцээ нь маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг цөөн тооны салбарт төвлөрч байна. Тээвэр 3.74 тэрбум ам.доллар, эрчим хүч 3.27 тэрбум ам.доллар бөгөөд эдгээр нь хамтдаа сааруулах арга хэмжээний нийт хэрэгцээний 70 гаруй хувийг бүрдүүлж байна. Барилгын салбар 1.83 тэрбум ам.долларын хэрэгцээгээр гурав дахь том сааруулах салбар бөгөөд үүний дараа ойн салбар 391 сая ам.доллар, хог хаягдал 303 сая ам.доллар, аж үйлдвэрийн процесс 106 сая ам.доллар байна. Дасан зохицох хэрэгцээнд усны нөөцийн менежмент 3.24 тэрбум ам.долларын тооцоогоор давамгайлж байгаа нь дасан зохицох нийт хэрэгцээний 62 хувийг эзэлж байна. Салбар дамнасан арга хэмжээнүүд мөн дасан зохицох нөхцөлт арга хэмжээний чухал хэсгийг бүрдүүлж байгаа бөгөөд санхүүжилтийн хэрэгцээ нь 1.5 тэрбум ам.доллар буюу дасан зохицох нийт хэрэгцээний 29 хувьтай тэнцэж байна. Мөн, ҮТХН 3.0-ын нийт хэрэгцээ 2025 оноос 2035 оны хооронд ойролцоогоор 14.847 тэрбум ам.доллар шаардлагатай. <sup>13</sup>

#### 1.7.1. Уур амьсгалын төсөвлөлт ба ногоон төсөв

Ногоон төсөв гэдэг нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтод хүрэхийн тулд төсвийн бодлогын арга хэрэгслийг ашиглахыг хэлнэ. Энэ нь төсвийн бодлогыг байгаль орчны зорилтуудтай илүү сайн уялдуулах зорилгоор төсвийн зүйл, бодлогын байгаль орчинд үзүүлэх хувь нэмрийг тодорхой гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр тодорхойлж, үнэлдэг үйл явц юм. Ногоон зорилтыг төсөв, санхүүгийн тогтолцоонд нэгтгэх цар хүрээ нь стратегийн төлөвлөлт болон дунд хугацааны төсвийн хүрээ, төсөв боловсруулах болон батлах, төсвийн хэрэгжилт, бүртгэл, тайлагнал, хяналт, аудит гэсэн дөрвөн үе шатаас бүрдэнэ.<sup>14</sup>

Монгол Улсын төсөв, санхүүгийн тогтолцоо болон төсвийн үйл явц нь ногоон зорилтыг хэрэгжүүлэхэд хангалттай ач холбогдол өгдөггүй байна. Урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулах, Дунд хугацааны төсвийн хүрээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл бэлтгэх удирдамж, Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн санал, Сангийн яамны төсвийн хяналт, Засгийн газраас төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар төсөв батлах, төсвийн хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлагнал, төсвийн гүйцэтгэл батлах, аудит хийх зэрэг төсвийн бүх үйл явцад ногоон зорилтыг тодорхой байдлаар авч үздэггүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 болон 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид уур амьсгалын өөрчлөлт болон ногоон зорилттой холбоотой зардал, бодлого, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг төсөвт хэрхэн тусгах талаар тусгайлсан чиглэл, зөвлөмж тусгаагүй байна.

Уур амьсгалын болон ногоон зорилттой төсвийн зардлыг тэмдэглэх (budget tagging) нь Засгийн газрын төсвийн систем дэх холбогдох зардлыг тодорхойлох, ангилал, жинлэх, тэмдэглэх арга хэрэгсэл гэж тодорхойлогддог. Тэмдэглэх ажлын үр дүнд Сангийн яам болон салбарын яамдын уур амьсгалын өөрчлөлт, ногоон зорилтын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн бодлого боловсруулах болон салбаруудын хооронд нөөц

---

12 ҮТХН 3.0-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хүрээ, Технологийн хэрэгцээний шаардлагын үнэлгээ болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээ.

13 ҮТХН 3.0-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хүрээ, Технологийн хэрэгцээний шаардлагын үнэлгээ болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээ

14 ҮТХН 3.0-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хүрээ, Технологийн хэрэгцээний шаардлагын үнэлгээ болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээ.

хуваарилах үйл явцыг дэмжих, санхүүжилтийн зөрүүг тодорхойлох, дотоодын болон олон улсын эх үүсвэрээс уур амьсгалын болон ногоон арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн зардлын хяналт, тайлагналыг сайжруулах зэрэг багтана. Төсвийн зардлыг холбохдоо ногоон болон уур амьсгалтай холбоотой зардлыг тайлбарлаж, ангилдаг тодорхой ангилал (таксономи)-ын систем ашиглах нь субъектив байдлыг бууруулахад тусалдаг. Хэрэгжүүлэх хугацааны хувьд төсвийн зардлыг холбох ажлыг хэрэгжүүлсэн улс орнууд үүнийг төсвийн мөчлөгийн эхний шатанд хийдэг. Уур амьсгал болон ногоон санхүүжилтийг Монгол Улсын төсвийн тогтолцоонд суурилуулах нь зайлшгүй шаардлагатай. Монгол Улс одоогоор уур амьсгалтай холбоотой зардлыг одоогоор системтэйгээр тэмдэглэдэггүй бөгөөд уур амьсгалын төсвийн зардлыг холбох, тайлагнах, гүйцэтгэлийн аудит хийх албан ёсны тогтолцоо байхгүй байна. Шинэчлэл хийхгүй бол уур амьсгалын хөрөнгө оруулалт зорилгодоо хүрэхгүй байх, хариуцлага сул байх эрсдэлтэй.

2024 онд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг ногоон зорилттой уялдуулан авч үзвэл нийт 1,430 төсөл, арга хэмжээнд 5,167.0 тэрбум төгрөг хуваарилснаас 1,532.0 тэрбум төгрөг буюу 29.6 хувь нь ногоон зорилттой холбоотой байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд 1,300 төсөл, арга хэмжээнд нийт 3,384.4 тэрбум төгрөг хуваарилснаас 172 төсөлд хамаарах 403.0 тэрбум төгрөг нь ногоон зорилттой уялдсан бөгөөд энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын 12 хувийг бүрдүүлж байна. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтийн хүрээнд 130 төсөлд нийт 1,783.0 тэрбум төгрөг хуваарилснаас 58 төсөлд хамаарах 1,129.0 тэрбум төгрөг буюу нийт дүнгийн 63 хувь нь ногоон зорилттой холбоотой байна. Салбарын ангиллаар авч үзвэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлийн төслүүд хамгийн өндөр хувийг эзэлж, 94 төсөл, арга хэмжээнд 680.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан байна. Ногоон төслүүдийг зургаан зорилтын хүрээнд ангилахад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой төслүүд 966.28 тэрбум төгрөгт хүрч, ногоон төсөлд хуваарилсан нийт 1,532.0 тэрбум төгрөгийн 63 хувийг бүрдүүлж байна.


Уур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн шууд төсвийн санхүүжилт харьцангуй бага байгаа хэдий ч ногоон болон уур амьсгалтай холбоотой зарцуулалтыг бүрэн мөшгөдөггүй нөхцөлд бодит санхүүжилтийн хэмжээ дутуу үнэлэгдэж, тооцогдож байх магадлалтай. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэж тодорхой тодорхойлох боломжтой төсвийн хөрөнгө оруулалт 2022 онд ДНБ-ий ердөө 0.3 хувьтай тэнцэж байсан бөгөөд үүний гуравны хоёр нь хөгжлийн түншүүдийн зээл, буцалтгүй тусламжаар санхүүжиж, голчлон сэргээгдэх эрчим хүч болон биологийн олон янз байдалд чиглэсэн байна.

Монгол Улсад ногоон зорилтыг төсөв, санхүүгийн тогтолцоонд нэгтгэх, төсөв, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг ногоон зорилтыг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилтод хүрэхэд илүү үр дүнтэй зохион байгуулах зайлшгүй шаардлага тавигдаж байна. ОУВС (ОУВС 2021)-аас ногоон зорилтыг төсөв, санхүүгийн тогтолцоонд нэгтгэх цар хүрээг Зураг 2 -т үзүүлсэн байна. Тус хүрээ нь зөвхөн улсын төсвийн зарлагыг хамарсан бөгөөд төсвийн орлого болон орон нутгийн төсвийг хамруулаагүй байна.

ОУВС ногоон зорилтыг төсвийн бүтэн цикл буюу дараах 4 үе шат тус бүрээр нарийвчлан авч үзсэн байна. Үүнд:

- Стратегийн төлөвлөлт болон дунд хугацааны төсвийн хүрээ
- Төсөв боловсруулах болон батлах
- Төсвийн хэрэгжилт, бүртгэл, тайлагнал
- Хяналт, аудит

*Зураг 1. Ногоон зорилтыг Төсөв, санхүүгийн тогтолцоонд нэгтгэх цар хүрээ*



Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан (2021)

Олон улсын туршлага дээр үндэслэн Монгол улсын өнөөгийн төсөв, санхүүгийн тогтолцоо нь ногоон зорилттой хэрхэн уялдаж байгаа талаар Зураг 2 дээрх 4 үе шат тус бүрт нөхцөл байдлын дүн шинжилгээг товч байдлаар хийж гүйцэтгэсэн. Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхдээ Хүснэгтэд туссан баримт бичгүүдийг ашигласан.

Хүснэгт. “Ногоон зорилт”-ыг төсөв, санхүүгийн тогтолцоонд хэрхэн тусгасан талаар дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан баримт бичгийн жагсаалт

#	Хөгжлийн төлөвлөгөө, төсөв, аудитын тайлан, дүгнэлтийн жагсаалт	Хамрах хугацаа
1	“Алсын хараа-2050”	2020-2050
2	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”	2021-2025
3	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	2023, 2024
4	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл	2023-2025, 2024-2026
5	Төсвийн төсөл бэлтгэх удирдамж,	2023, 2024
6	ТЕЗ-ын төсвийн төсөл (Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам)	2023, 2024
7	Засгийн газраас боловсруулсан жил бүрийн төсвийн төсөл	2023, 2024
8	Үндэсний аудитын газрын төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмж	2023, 2024
9	Батлагдсан төсөв (Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ)	2024
10	Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	2023

11	Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2023
12	Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын тайлан	2023

Эх сурвалж: Ногоон төсвийн ангилал зүй боловсруулж, төсвийг ногоон Зорилттой холбох үйл ажиллагааг гүйцэтгэсэн тайлан (туршилт) Г. Цэвээндорж нар

### 1.7.2. Хувийн санхүүжилт, ногоон зээл ба санхүүжилтийн арга хэрэгсэл

Монгол Улсад ногоон санхүүжилт харьцангуй бага хэвээр байгаа боловч хурдацтай өсөж, сүүлийн үед санхүүжилтийн шинэ санаачилгууд гарч, иж бүрэн зохицуулалтын хүрээг бүрдүүлэхэд ахиц гарч байна. Ногоон зээл нь нийт зээлийн үлдэгдлийн багахан хувийг эзэлж байгаа бөгөөд 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар арилжааны банкуудын нийт зээлийн багцын 3 хувийг бүрдүүлж байна. Монгол Улс 2023 онд сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, ногоон дэд бүтэц, уур амьсгалд ухаалаг хөдөө аж ахуйн төслүүдийг дэмжихэд чиглэсэн анхны ногоон компанийн бондыг гаргаснаар чухал амжилтад хүрсэн. Уур амьсгалын ногоон сан нь бусад олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотод хямд өртөгтэй ногоон орон сууцны зээл олгох холимог санхүүжилтийн схемийг хэрэгжүүлж байна.

2025 оны жилийн эцсийн мэдээллээр арилжааны банкуудын ногоон зээлийн үлдэгдэл 2.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 72.6 хувиар өссөн байна. Ногоон зээл нь нийт зээлийн багцын 5.3 хувийг эзэлсэн. Арилжааны банкууд ногоон зээлийг 2030 он гэхэд нийт зээлийн 10 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд одоогийн түвшин нь тус зорилтын ойролцоогоор тал хувьтай тэнцэж байна.<sup>15</sup>

Ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэхэд томоохон сорилтууд хэвээр байна. Санхүүжилтийн өндөр өртөг болон уур амьсгалын төслүүдийн урт хугацааны хөрөнгө оруулалтын хугацаатай нийцэх хүртээмжтэй дунд болон урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр дутмаг байгаа нь ногоон санаачилгад санхүүжилт хайж буй аж ахуйн нэгжүүд, ялангуяа жижиг, дунд үйлдвэрүүдэд саад болж байна. Зах зээлийн эрэлт болон нийлүүлэлтийн аль аль талд мэдээллийн зөрүү хэвээр байна. Санхүүжүүлэгчид боломжит ногоон төслүүдийг үнэлэхэд хүндрэлтэй байдаг бол бизнес эрхлэгчидэд боломжтой санхүүжилтийн арга хэрэгслийн хүрээний талаар ихэвчлэн мэдлэггүй байдаг. Ногоон зээлийн хамрах хүрээ, тайлагнал бүрэн бус хэвээр байгаа, дотоодын санхүүгийн байгууллагуудад ногоон төслийг хянах, үнэлэх шаардлагатай арга хэрэгсэл, мэргэжлийн чадавч дутмаг, гадаад хяналттай холбоотой ногоон бонд гаргах зардал нь ногоон бондын зах зээлийг хөгжүүлэхэд бас нэгэн саад болж болзошгүй байна.

Олон талт хөгжлийн банкууд нь хөнгөлөлттэй болон нөхцөлтэй зээл, өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалт, баталгаа, техникийн туслалцаа зэрэг санхүүгийн холимог хэрэгслүүдийг санал болгох боломжтой байдаг. Эдгээр эх үүсвэрүүд нь сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний сүлжээний дэд бүтэц, нийтийн тээврийн систем, эрчим хүчний хэмнэлттэй орон сууц зэрэг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой, өндөр хөрөнгө оруулалт шаардсан сааруулах арга хэмжээнд онцгой ач холбогдолтой.

Түүнчлэн олон талт хөгжлийн банкууд нь усны нөөцийн менежмент, гамшгийн эрсдэлийг бууруулах, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх зэрэг дасан зохицох чиглэлийн хөрөнгө оруулалтыг улсын зээл болон буцалтгүй тусламжийн санхүүжилтээр дэмждэг. Олон талт

<sup>15</sup> Монголбанкны Банкны салбарын ногоон зээлийн тайлан.

хөгжлийн банкуудын оролцоо нь хувийн хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулахын зэрэгцээ урт хугацааны бодлогын тогтвортой амлалтыг илэрхийлдэг тул Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн хэрэгжилтэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад чухал үүрэгтэй.<sup>16</sup>

Монголын Ногоон Санхүүжилтийн Корпораци нь Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн замын зураглал 2022–2030 -ын хүрээнд байгуулагдсан бөгөөд дотооддоо уур амьсгалын санхүүжилтийг нэмэгдүүлэх, чиглүүлэх гол байгууллага болохоор байна. Тус корпораци нь сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашигтай орон сууц, тогтвортой тээвэр зэрэг ногоон төслүүдэд хөрөнгө оруулж буй өрх, аж ахуйн нэгжүүдэд цааш дамжуулан зээлүүлэх зорилгоор орон нутгийн банк, санхүүгийн байгууллагуудад хөнгөлөлттэй зээл олгодог. Дотоодын банкууд нь эрчим хүчний үр ашиг, жижиг, дунд үйлдвэрийн ногоон хөрөнгө оруулалт болон өрхийн түвшний арга хэмжээг санхүүжүүлэх чухал эх үүсвэр хэвээр байна. Гэсэн хэдий ч өндөр хүү, богино хугацаа нь урт хугацааны уур амьсгалын дэд бүтцийг санхүүжүүлэх чадварыг хязгаарлаж байна.<sup>17</sup>

Олон улсын нүүрстөрөгчийн зах зээл нь эрчим хүч, тээвэр, хог хаягдал, ойн салбарт онцгой хамааралтай чухал арга хэрэгсэл хэвээр байна. Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн, Хамтарсан кредит олгох механизм болон сайн дурын зах зээл нь эрчим хүч болон аж үйлдвэрийн процесс, бүтээгдэхүүний хэрэглээний салбар дахь үр ашиг, процессын ялгарлыг их хэмжээгээр бууруулахыг дэмжих боломжтой бол ойн салбарт REDD+ болон биологийн олон янз байдлын кредитийг дэмждэг.<sup>18</sup>

## **1.8. Ногоон таксономи**

Аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч нарт Байгаль орчинд ээлтэй тогтвортой эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлох, тогтвортой хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад туслах ангиллын системийг Таксономи буюу Ангилал зүй гэж Европын Холбоо тодорхойлсон байна.

“Европын Холбооны Таксономи”-г олон салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүд, техникийн шинжээчдийн баг боловсруулсан бөгөөд тухайн таксономи нь шинжлэх ухаан, технологийн өөрчлөлт, дэвшилттэй уялдуулан тухай бүр шинэчлэгддэг. Тус таксономи нь олон улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн, шинжлэх ухаанд суурилсан, Европын холбооны хууль, дүрэм, журамтай нийцсэн дэвшилтэт таксономи юм. Мөн “Европын Холбооны Таксономи”-г цахим портал хэлбэрээр бэлтгэн гаргасан нь ашиглахад хялбар байна.

Зүүн Өмнөд Азийн Холбоо (ASEAN)-ны мөрдөж буй “Зүүн Өмнөд Азийн Холбооны Таксономи” нь “Европын Холбооны Таксономи”-ийн зарим зорилтод суурилсан байна. Цаашид олон улс орон “Европын Холбооны Таксономи”-г ашиглан өөрийн улсын таксономиг бий болгох хандлага ажиглагдаж байна.

“Европын Холбооны Таксономи”-д дараах үндсэн зарчмыг баримталж байна. Үүнд:

---

16 Дэлхийн Банк - Монгол Улсын уур амьсгал, хөгжлийн тайлан.

17 ҮТХН 3.0-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хүрээ, Технологийн хэрэгцээний шаардлагын үнэлгээ болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээ.

18 ҮТХН 3.0-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хүрээ, Технологийн хэрэгцээний шаардлагын үнэлгээ болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээ.

1. Эдийн засгийн үйл ажиллагаа нь 6 ногоон зорилтын 1-ээс дээш зорилттой уялдсан байх.
2. Эдийн засгийн үйл ажиллагаа нь бусад ногоон зорилтуудад сөрөг нөлөөгүй байх.
3. Аюулгүй ажиллагааны шаардлага (Хүний эрх, хөдөлмөрийн эрхийн холбогдох хууль, журамтай нийцсэн байх)-ыг хангасан байх.

“Европын Холбооны Таксономи” нь 5 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

1. Салбарын ангилал
2. Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал
3. Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын тодорхойлолт
4. Техникийн шалгуур үзүүлэлт
5. Ногоон зорилтууд:
  - (i) Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах,
  - (ii) Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох,
  - (iii) Усны нөөцийн зохистой хэрэглээ болон хамгаалалт,
  - (iv) Хаягдалгүй тойрог эдийн засаг руу шилжих,
  - (v) Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах,
  - (vi) Биологийн олон янз байдал болон экосистемийг нөхөн сэргээх, хамгаалах

Эх сурвалж: Ногоон төсвийн ангилал зүй боловсруулж, төсвийг ногоон Зорилттой холбох үйл ажиллагааг гүйцэтгэсэн тайлан (туршилт) Г. Цэвээндорж нар

### 1.8.1. Монгол Улсын Ногоон Таксономи болон Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийн таксономи

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын санхүүжилтийн таксономи нь 2019 онд батлагдсан Ногоон Таксономийн хүрээг өргөжүүлсэн бөгөөд Монгол Улсын тогтвортой хөрөнгийн оруулалтыг дэмжих анхны алхмуудын нэг юм. Ногоон Таксономи нь санхүүгийн байгууллагууд болон төсөл хэрэгжүүлэгчдэд ногоон санхүүжилтийн боломжийг тодорхойлох, харьцуулах боломж олгож, ногоон төслүүдэд илүү их хөрөнгө шилжүүлэхэд хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлдэг. Монголбанк Ногоон Таксономийг тайлагналын шаардлагадаа нэвтрүүлж, 2020 оноос хойш арилжааны банкуудаас Ногоон Таксономийн дагуу ногоон зээлийн өгөгдөл, мэдээллийг цуглуулж эхэлсэн.

2019 оны Ногоон Таксономи байсан хэдий ч тэгш хүртээмжтэй шилжилтийг хэрэгжүүлэх болон хүний эрх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанартай боловсрол, зохистой хөдөлмөр эрхлэлт, тэгш байдал, хэнийг ч орхигдуулахгүй байх зэрэг нийгмийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хоцрогдсон байна. Энэ зөрүүг харгалзан 2023 онд Ногоон Таксономийг Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийн таксономи болгон өргөжүүлж, боловсрол, эрүүл мэнд, мэдээлэл, харилцаа холбоо, хүртээмжтэй дэд бүтэц зэрэг нийгмийн салбаруудыг нэмснээр таксономийг 17 ТХЗ болон 142 шалгуур үзүүлэлтэд харгалзах эдийн засгийн үйл ажиллагаатай уялдуулсан.

Хүснэгт. ТХЗ-ын санхүүжилтийн таксономийн ангиллын бүтэц

Ангилал	Дэд ангилал
<b>1. Эрчим хүч үйлдвэрлэл болон дэмжих дэд бүтэц</b>	1.1 Салхи 1.2 Нар 1.3 Геотермал 1.4 Усан цахилгаан 1.5 Устөрөгч 1.6 Биоэнерги 1.7 Хог хаягдлаас эрчим хүч гаргах байгууламж

	1.8 Нүүрстөрөгч багатай эрчим хүчний нийлүүлэлтийн сүлжээ болон дэмжих дэд бүтэц
<b>2. Эрчим хүчний үр ашиг</b>	2.1 Эрчим хүчний нийлүүлэлтийн үр ашгийг сайжруулах 2.2 Бүх салбарын эрчим хүчний үр ашгийг сайжруулах
<b>3. Эрчим хүчний үр ашигтай болон ногоон барилга</b>	3.1 Эрчим хүчний үр ашигтай барилга 3.2 Ногоон барилга 3.3 Ногоон дэд бүтэц
<b>4. Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах</b>	4.1 Агаарын чанар 4.2 Хөрс
<b>5. Ус болон хог хаягдлын тогтвортой хэрэглээ</b>	5.1 Усны тогтвортой хэрэглээ болон усны үр ашиг 5.2 Хог хаягдал 5.3 Хуучин болон ашигласан хог хаягдлын цэгүүдийг нөхөн сэргээх 5.4 Цахим хог хаягдал 5.5 Уул уурхайн хаягдал
<b>6. Тогтвортой хөдөө аж ахуй ба хүнсний аюулгүй байдал</b>	6.1 Мал аж ахуй болон холбогдох үйл ажиллагаа 6.2 Хөдөө аж ахуйн тариалан, жимс, хүнсний ногооны аж ахуй 6.3 Хүнсний тогтвортой боловсруулалт, үйлдвэрлэл 6.4 Хөдөө аж ахуйг дэмжих бусад үйлчилгээ 6.5 Нэхмэлийн тогтвортой боловсруулалт, үйлдвэрлэл
<b>7. Газрын тогтвортой ашиглалт ба биологийн олон янз байдал</b>	7.1 Тогтвортой ойжуулалт 7.2 Ойн тогтвортой үйлдвэрлэл 7.3 Ой, модны хамгаалалт 7.4 Биологийн олон янз байдлын тогтвортой менежмент
<b>8. Ялгарал багатай тээвэр</b>	8.1 Ялгарал багатай тээврийн хэрэгсэл 8.2 Ялгарал багатай ачаа болон бараа тээвэрлэлт 8.3 Ялгарал багатай тээврийн дэд бүтэц 8.4 Ялгарал багатай мэдээлэл, харилцаа холбооны технологи 8.5 Аюулгүй, хүртээмжтэй нийтийн тээвэр
<b>9. Мэдээлэл, харилцаа холбооны технологи</b>	9.1 Хүртээмжтэй сүлжээ 9.2 Хүртээмжтэй, аюулгүй программ хангамж болон цахим платформ 9.3 Тогтвортой зүйлсийн интернэт 9.4 Ногоон дата төв
<b>10. Эрүүл мэнд</b>	10.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон ариун цэврийн үйлчилгээ 10.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологийн шинэчлэл ба дэмжлэг 10.3 Эмнэлэг, ариун цэврийн салбарын үйлдвэрлэл болон нийлүүлэлт 10.4 Эрүүл мэндийн логистикийн үйлчилгээ 10.5 Хадгалалт ба хүргэлт 10.6 Халдварт өвчний хяналт
<b>11. Боловсрол ба соёл</b>	11.1 Боловсрол 11.2 Соёл, спортын салбар
<b>12. Хүртээмжтэй суурь дэд бүтэц</b>	12.1 Боломжийн үнэтэй, хүртээмжтэй орон сууц 12.2 Түүхэн барилгыг дахин хөгжүүлэх, хадгалах 12.3 Ногоон дэд бүтэц 12.4 Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ба менежмент 12.5 Инженерийн шугам сүлжээний коридор

Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийн таксономи нь нөлөөллийг хэмжих, баталгаажуулах, тайлагнах шалгуурыг багтаасан бөгөөд ингэснээр Монгол Улс ТХЗ болон нийгмийн таксономи боловсруулсан анхны улсуудын нэг болсон.

Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийн таксономи нь арилжааны банкууд болон хувийн хэвшлийн байгууллагуудын тогтвортой хөгжлийн санхүүгийн урсгалыг тодорхойлох, ангилал, хэмжих үндсэн арга хэрэгсэл болохоор төлөвлөгдөж байна. Энэхүү таксономи нь 12 үндсэн салбар, 51 дэд салбараас бүрдэх бөгөөд 2025 оноос эхлэн заавал мөрдөх эрх зүйн баримт бичиг хэлбэрээр хэрэгжинэ.

Мөн уг зохицуулалтын хүрээнд нэг жилийн туршилтын хугацаа хэрэгжих бөгөөд энэ хугацаанд оролцогч талууд баримт бичгийн хэрэгжилтийг хянан үзэх, санал өгөх, шаардлагатай сайжруулалтыг хийх боломжтой байна. 2025 оноос эхлэн банкууд болон банк бус санхүүгийн байгууллагууд Монгол Улсын шинэ ТХЗ-ын санхүүжилтийн таксономийн дагуу санхүүгийн урсгалыг ангилан мөшгөж, холбогдох тайлан, мэдээллийг Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол хүргүүлэхээр төлөвлөж байна.

Монгол Улсын ТХЗ-ын санхүүжилтийн таксономийг 2025 оноос нэвтрүүлэхээр төлөвлөж байгаатай холбогдуулан 2024 онд АХБ, НҮБХХ болон ТОС Холбоо нь Голомт банк, Хаан банк гэсэн хоёр сонгосон банкинд шинэ таксономийг туршиж, тус таксономиг ашиглан банкуудын зээлийн багцыг ангилсан. Туршилтын үр дүнд үндэслэн 2025-2026 онд Сангийн яам оролцогч талуудтай хамтран ТХЗ-ын санхүүжилтын таксономийг сайжруулах ажлыг зохион байгуулан хийж байна.

### **1.9. Стратегийн төлөвлөлт болон дунд хугацааны төсвийн хүрээ**

Стратегийн төлөвлөлт болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь Засгийн газрын бодлогын тэрүүлэх чиглэлийг тодорхойлох, төсвийн харилцаа, төсвийн процесс, төсвийн хязгаарлалтыг тогтооход ашиглагддаг чухал баримт бичиг юм. Мөн “ногоон төсөв (уур амьсгалын өөрчлөлтийн төсөв)”-ийг нэвтрүүлэх хамгийн эхлэлийн цэг нь стратеги төлөвлөлт юм. Иймд ногоон зорилт, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтыг стратегийн төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгтгэх шаардлагатай талаар ОУВС зөвлөмж өгсөн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн зорилтыг Үндэсний хөгжлийн төлөвлөлт, төсвийн процесст нэгтгэх төсвийн шинэчлэлийн үндсэн нөхцөл бол сайтар тодорхойлогдсон хууль, эрх зүй, бодлогын хүрээ юм. Дийлэнх улс орнууд Үндэсний хөгжлийн төлөвлөгөөндөө уур амьсгалын өөрчлөлтийн талаар оруулдаг (тухайлбал, Хятад, Индонез, Ирланд, Непал, Өмнөд Африк гэх мэт). Энэ үйл явц нь хэд хэдэн үе шатаас бүрдэх бөгөөд эхний шатанд салбар дундын асуудлыг хамарсан ерөнхий хэсгийг оруулдаг. Тухайлбал, тус хэсэгт төрийн бодлого, шийдвэр гаргагч нар, яамдын мэргэжилтнүүд, хувийн салбар, иргэдэд уур амьсгалын өөрчлөлтийн талаар өгөх мэдлэг, мэдээллийг оруулдаг. Дараагийн шатанд, уур амьсгалын өөрчлөлтийн зорилтыг Үндэсний хөгжлийн төлөвлөгөөний харгалзах салбар бүрийн төлөвлөгөөнд нэгтгэж оруулах, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилтод эерэг хувь нэмэр оруулах салбарын хөтөлбөр, бодлогод тусгадаг. Олон тооны төрийн бодлого нь уур амьсгалын өөрчлөлтөд шууд болон шууд бус үр нөлөөг үзүүлж байдаг. Иймд уур амьсгалын өөрчлөлтийн зорилт нь үндэсний хөгжлийн төлөвлөгөө, салбарын төлөвлөгөө, бодлогын баримт бичигт тусгагдах ёстой юм.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ**

Энэхүү судалгааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх өнөөгийн эрх зүйн зохицуулалтын тодорхойгүй байдал, нэр томьёоны зөрүү, зохицуулалтын давхардал, институц хоорондын уялдаа сул, хэрэгжилт, тайлагнал, санхүүжилт болон хяналт-шинжилгээний тогтолцооны хийдэлтэй холбоотой асуудлуудыг судлан шинжилсний үндсэн дээр Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн тогтолцоонд шилжүүлэх, Парисын хэлэлцээр болон олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах, ногоон хөгжил, тогтвортой санхүүжилт, карбон зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж үзэв.

Иймд судалгааны үр дүнд дараах гол зохицуулалтын асуудлыг хуулийн төсөлд тусган хуульчлахаар тодорхойлов. Үүнд:

1. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх, тэг ялгаралд хүрэхтэй холбоотой Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлого, зорилт болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн эрх зүйн үндсийг тогтоох;
2. Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, төлөвлөлтийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны бодлогын баримт бичиг, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө болон салбарын хөгжлийн бодлого, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох;
3. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, бүрэн эрх, уялдаа холбоо, хариуцлагын тогтолцоог тодорхойлон салбар дундын нэгдсэн зохицуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх;
4. Төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, хувийн хэвшил, санхүүгийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, хамтын ажиллагааны зохицуулалтыг бий болгох;
5. Аймаг, нийслэл, орон нутгийн түвшинд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх, дасан зохицох болон эрсдэлийг бууруулах төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын тогтолцоог бүрдүүлэх;
6. Үндэсний зохицуулагч байгууллага, техникийн хороо, мэргэжлийн зөвлөл болон шаардлагатай бусад салбар дундын зохицуулалтын бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох;
7. Хүлэмжийн хийн үндэсний тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн ил тод байдлын тайлагнал, харгалзах тохируулгын зохицуулалтын нэгдсэн тогтолцоог бий болгох;
8. Ногоон болон уур амьсгалын санхүүжилт, ногоон таксономи, уур амьсгалын хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, эдийн засгийн хөшүүрэг, карбон зах зээлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх;
9. Мэдээллийн нэгдсэн сан, өгөгдөл солилцоо, мэдээллийн ил тод байдал, олон нийтийн оролцоо, мэдээллийн хүртээмжийн зохицуулалтыг бий болгох;
10. Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд нийцсэн хоёр талт, олон талт, сайн дурын болон үндэсний карбон зах зээлийн эрх зүйн үндсийг бүрдүүлж, сааруулалтын үр дүн, карбон кредит, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн, харгалзах тохируулга, бүртгэл, шилжүүлэг, баталгаажуулалтын тогтолцоог хуульчлах;

11. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, гарз хохирлын үнэлгээ, дасан зохицох болон даван туулах чадавхыг бэхжүүлэх бодлого, арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг тогтоох.

Дээрх зохицуулалтыг хуульчилснаар Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоотойгоор хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэж, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт болон олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах, хүлэмжийн хийн тооллого, ил тод байдлын тогтолцоог бэхжүүлэх, ногоон болон уур амьсгалын санхүүжилт татах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, олон улсын карбон зах зээлд үр ашигтай оролцох нөхцөл бүрдэх ач холбогдолтой болно.

## ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 5 дугаар хэсэгт заасны дагуу уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг зохицуулах боломжит хувилбаруудыг тодорхойлж, тэдгээрийн зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хэрэгжилтийн үр нөлөөг харьцуулан судлав.

Судалгааны хүрээнд дараах зохицуулалтын хувилбаруудыг авч үзсэн болно. Үүнд:

1. “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
2. хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
3. зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
4. төрөөс санхүүгийн интервенц хийх;
5. төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
6. захиргааны шийдвэр гаргах;
7. хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Дээрх хувилбаруудыг уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоотойгоор хэрэгжүүлэх, Парисын хэлэлцээр болон Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах, хүлэмжийн хийн тооллого, тайлагнал, ил тод байдлын тогтолцоог бүрдүүлэх, ногоон санхүүжилт болон карбон зах зээлийн эрх зүйн орчныг бий болгох зорилгод хүрэх эсэхээр нь харьцуулан судалсан.

№	Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилт, хүлэмжийн хийн тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, карбон зах зээл, ногоон санхүүжилт, мэдээллийн сан зэрэг харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах эрх зүйн үндэс бүрдэхгүй. Төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа, ил тод байдал, олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй хэвээр үлдэнэ.	Шууд нэмэлт зардал бага боловч уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, эдийн засгийн алдагдал, олон улсын санхүүжилт болон карбон зах зээлд оролцох боломжийн алдагдана.	Үр дүнгүй
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх боломжтой боловч хүлэмжийн хийн үндэсний тооллого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн	Соён гэгээрүүлэх, мэдээлэл түгээхтэй холбоотой төсөв шаардагдах боловч эрх зүйн болон институцийн суурь асуудлыг	Тодорхой үр дүнд хүрэхгүй

		тайлагнал, карбон зах зээл, харгалзах тохируулга, ногоон санхүүжилтийн тогтолцоо зэрэг хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг бүрдүүлэх боломжгүй.	шийдвэрлэх үр өгөөж хязгаарлагдмал.	
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Ногоон санхүүжилт, эдийн засгийн урамшуулал, карбон зах зээлийн тодорхой механизмыг хөгжүүлэх боломжтой боловч карбон кредит, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн, харгалзах тохируулга, бүртгэл, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, төрийн байгууллагын бүрэн эрх зэрэг суурь харилцааг дангаар зохицуулах боломжгүй.	Эдийн засгийн тодорхой хөшүүрэг бий болох боловч эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй нөхцөлд хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй байна.	Бүрэн үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжтой боловч Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилт, хүлэмжийн хийн тооллого, ил тод байдлын тайлагнал, институцийн уялдаа, карбон зах зээлийн зохицуулалт зэрэг суурь харилцааг бүрэн зохицуулахгүй.	Улсын төсөвт шууд ачаалал үүсэх бөгөөд урт хугацаанд тогтвортой эрх зүйн орчин, зах зээлийн итгэлцэл бүрдэхгүй.	Үр нөлөө хязгаарлагдмал
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх боломжтой боловч Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилт, олон улсын тайлагнал, хүлэмжийн хийн үндэсний тооллого, төрийн нэгдсэн бодлого, карбон зах зээлийн зохицуулалт зэрэг төрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэрэгжүүлэх боломжгүй.	Тодорхой чиг үүргийг харьцангуй үр ашигтай хэрэгжүүлэх боломжтой ч нэгдсэн тогтолцоо бүрдүүлэхэд хангалтгүй.	Хэсэгчилсэн үр дүнтэй
6	Захиргааны шийдвэр гаргах	Журам, аргачлал, дүрэм батлах замаар тодорхой асуудлыг зохицуулах боломжтой боловч уур амьсгалын өөрчлөлтийн талаар төрийн байгууллагын бүрэн эрх, карбон зах зээл, ногоон санхүүжилт, харгалзах тохируулга, хүлэмжийн хийн тайлагнал зэрэг суурь	Хэрэгжилтийн зардал бага боловч тогтвортой, нэгдсэн эрх зүйн орчин бүрдэхгүй.	Хангалтгүй

		харилцааг хуулийн түвшинд тогтоох боломжгүй.		
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилт, хүлэмжийн хийн тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, ногоон болон уур амьсгалын санхүүжилт, карбон зах зээл, харгалзах тохируулга, мэдээллийн сан, төрийн байгууллагын бүрэн эрх, оролцогч талуудын эрх, үүрэг зэрэг харилцааг нэгдсэн тогтолцоогоор цогц байдлаар зохицуулах эрх зүйн үндэс бүрдэнэ. Парисын хэлэлцээр болон олон улсын өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, олон улсын карбон зах зээл болон уур амьсгалын санхүүжилтэд оролцох эрх зүйн нөхцөл бүрдэх боломжтой.	Эхний шатанд институцийн болон хэрэгжилтийн тодорхой зардал шаардагдах боловч урт хугацаанд уур амьсгалын эрсдэлийг бууруулах, ногоон хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн тогтвортой шилжилтийг дэмжих өндөр үр өгөөжтэй.	Хамгийн үр дүнтэй хувилбар

Дээрх харьцуулсан судалгааны үр дүнд уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь олон салбар дамнасан, үндэсний болон олон улсын үүргийн хэрэгжилттэй шууд холбоотой, хүний эрх, эдийн засаг, байгаль орчин, тогтвортой хөгжлийн суурь харилцааг хамарсан шинжтэй тул зөвхөн захиргааны болон бодлогын түвшний арга хэмжээгээр бүрэн шийдвэрлэх боломжгүй гэж үзэв.

Түүнчлэн Монгол Улс Парисын хэлэлцээрийн хүрээнд Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, ил тод байдлын тайлагнал, карбон зах зээлийн зохицуулалттай холбоотой олон улсын үүрэг хүлээсэн бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн суурийг хуулиар тогтоох шаардлагатай байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 5.4.3-т заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулах хувилбарыг сонгосон болно.

## **ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Хууль санаачлагчийн зүгээс Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх эрх зүйн орчныг олон улсын чиг хандлага, Парисын хэлэлцээрийн үүрэг амлалт, үндэсний хөгжлийн бодлого, эдийн засаг, нийгэм, байгаль орчны онцлогтой уялдуулан шинэ шатанд хүргэх шаардлагатай гэж үзсэн. Энэ хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх, ногоон болон уур амьсгалын санхүүжилт, карбон зах зээлийг хөгжүүлэх, хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой харилцааг цогцоор нь зохицуулах Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулах зохицуулалтын хувилбарыг сонгосон болно.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу асуудлыг зохицуулах боломжит хувилбаруудыг харьцуулан судлахад уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь салбар дундын уялдаа холбоо, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, төрийн байгууллагын бүрэн эрх, хүлэмжийн хийн тооллого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, дасан зохицох төлөвлөлт, ногоон санхүүжилт, карбон зах зээл зэрэг өргөн хүрээний харилцааг хамарч байгаа тул зөвхөн бодлогын баримт бичиг, захиргааны шийдвэр, сайн дурын механизмын хүрээнд бүрэн зохицуулах боломжгүй гэж үзэв. Иймд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь зорилгод хүрэх хамгийн оновчтой зохицуулалтын хэлбэр гэж тогтоолоо.

Сонгосон зохицуулалтын хувилбарын үр нөлөөг хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, төрийн удирдлага, зах зээлийн тогтолцоо болон олон улсын харилцаанд үзүүлэх нөлөөллийн хүрээнд холбогдох аргачлалын дагуу тандан судалж, ерөнхий болон нарийвчилсан шалгуур асуултаар үнэлэв. Үнэлгээний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, салбар хоорондын уялдаа, Үндэсний зохицуулагч байгууллагын чиг үүрэг, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоо, Үндэсний платформ, ногоон санхүүжилт, карбон зах зээлийн зохицуулалт, дасан зохицох төлөвлөлтийн хэрэгжилт зэрэг нь хууль зүйн тодорхой зохицуулалттай болж байгааг харгалзан үзсэн.

Хуулийн төсөл батлагдсанаар уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг үндэсний хэмжээнд нэгдсэн бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоотойгоор хэрэгжүүлэх эрх зүйн суурь бүрдэх бөгөөд Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Үндэсний дасан зохицох төлөвлөгөө, урт хугацааны хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах боломж бүрдэнэ. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих, уур амьсгалын санхүүжилт болон карбон зах зээлд үр ашигтай оролцох нөхцөлийг бүрдүүлэх эерэг үр нөлөөтэй гэж дүгнэв.

Хуулийн төсөл нь хүний эрх, эрх чөлөөг хууль бусаар хязгаарлах, ялгаварлан гадуурхах, өмчлөх эрхэд халдах зохицуулалт агуулаагүй бөгөөд харин хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий бүлгийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэх, мэдээллийн ил тод байдал, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгасан. Мөн жендерийн эрх тэгш байдал, тэгш хүртээмжтэй шилжилтийн зарчмыг хуульд тусгасан нь хүний эрхэд суурилсан хандлагыг хангаж байна.

Эдийн засгийн үр нөлөөний хувьд хуулийн төсөл нь хувийн хэвшлийн оролцоо, ногоон хөрөнгө оруулалт, тогтвортой санхүүжилт, карбон зах зээлийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх бөгөөд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг нэмэгдүүлэх, инновац, хүлэмжийн хийн ялгарал багатай технологийн хөгжлийг дэмжих ач холбогдолтой. Хуулийн төслийн хүрээнд аж ахуйн нэгжид тодорхой хэмжээнд мэдээлэл, тайлагналын үүрэг үүсэх боловч энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн ил тод байдал, олон улсын тайлагналын шаардлагыг хангах, ногоон санхүүжилт татах, карбон зах зээлд оролцох боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд урт хугацаанд эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр өгөөж нь илүү өндөр байна.

Байгаль орчны үр нөлөөний хувьд хуулийн төсөл нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, шингээлтийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүч, нөөцийн үр ашиг, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих, агаарын бохирдол, газрын доройтол, цөлжилт, экосистемийн доройтлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэхээр байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээнд суурилсан бодлого, төлөвлөлт хэрэгжих эрх зүйн үндэс бүрдэх бөгөөд байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, биологийн олон янз байдлыг хамгаалах нөхцөл сайжирна.

Иймд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, Парисын хэлэлцээр болон холбогдох бусад олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд сөрөг үр дагавар үүсгэхгүй, харин тогтвортой хөгжил, ногоон шилжилт, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийг дэмжих эрх зүйн цогц орчныг бүрдүүлэх ач холбогдолтой гэж дүгнэв.

#### 4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 1

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Хуулийн төсөл нь аливаа этгээдийг ялгаварлан гадуурхах зохицуулалт агуулаагүй. Харин уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий бүлэг, салбарыг тэргүүн ээлжинд авч үзэх, тэгш хүртээмжтэй шилжилтийг дэмжих зарчмыг тусгасан.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Эмзэг бүлэг, орон нутгийн иргэд, шилжилтэд өртөх салбарын ажиллах хүчнийг хамгаалах зохицуулалт нь үндэслэлгүй давуу байдал бус, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд илүү өртөх эрсдэлийг бууруулах зорилготой тусгай арга хэмжээ юм.
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Хуулийн төсөлд талуудын оролцоог хангах зарчим тусгагдсан бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил,

			иргэд, сонирхлын бүлгийн оролцоог хангахаар зохицуулсан.
	1.2.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Хуулийн төсөлд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий бүлэгт бага орлоготой иргэд, алслагдсан бүс нутгийн оршин суугчид, малчид, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг бүлгийг хамруулан тодорхойлсон.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох, даван туулах бодлого, төлөвлөлт, санхүүжилт, мэдээллийн ил тод байдлыг бүрдүүлэх замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг дэмжинэ.
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төсөл нь Парисын хэлэлцээр, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг баримтлах зарчимд үндэслэсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Хуулийн төсөлд уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, тайлагнал, мэдээлэл, карбон зах зээл, санхүүжилттэй холбоотой чиг үүрэг, хяналт, хариуцлагын суурь зохицуулалтыг бүрдүүлэх бөгөөд зөрчил, хариуцлагын асуудлыг холбогдох хууль тогтоомжоор уялдуулан зохицуулна.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Хуулийн төсөл нь хүний эрхийг шууд хязгаарлах бус, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг дэмжих зорилготой.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Хүний эрхийг хязгаарласан тусгай зохицуулалт агуулаагүй тул хязгаарлалтын зайлшгүй байдлыг үнэлэх шаардлагагүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Иргэд, орон нутгийн иргэд, малчид, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага орлоготой иргэд, хувийн хэвшил, санхүүгийн байгууллага болон бусад оролцогч талууд хуулийн зохицуулалтад хамаарна.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Хуулийн төсөлд “уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий бүлэг” болон “уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий салбар”-ыг тусгайлан тодорхойлсон.

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэх, эмзэг бүлэг, салбарыг тэргүүн ээлжинд авч үзэх, санхүүжилт болон төлөвлөлтөд тусгах зохицуулалтаар дамжуулан эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Хуулийн төсөлд тэгш хүртээмжтэй шилжилт, жендерийн эрх тэгш байдал, орон нутгийн иргэд, эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг харгалзан үзэх зарчмыг тусгасан.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний зохицуулагч байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, бусад төрийн байгууллага, хуулийн этгээд болон оролцогч талуудын чиг үүрэг, эрх, үүргийг тодорхойлсон.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Хуулийн төсөлд жендерийн эрх тэгш байдлыг хангах зарчмыг тусгаж, уур амьсгалын бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтэд эмэгтэй, эрэгтэй хүмүүс болон жендерийн хувьд эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээ, оролцоог харгалзан үзэхээр зохицуулсан.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтэд тэгш оролцоо, шийдвэр гаргалтад оролцох боломж, үр өгөөжийг шударгаар хүртээх зарчмыг тусгасан тул жендерийн эрх тэгш байдлын шаардлагад нийцнэ.

#### 4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 2

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Хуулийн төсөл нь ногоон санхүүжилт, карбон зах зээл, олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлснээр дотоодын аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлнэ.
	1.2.Хил дамнансан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн)	Тийм	Парисын хэлэлцээрийн хүрээний хоёр болон олон талт хамтын ажиллагаа, карбон зах зээлийн зохицуулалт бий болсноор олон улсын хөрөнгө оруулалт,

	байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		уур амьсгалын санхүүжилтийн урсгалыг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Хуулийн төсөл нь хүлэмжийн хийн ялгарал багатай, тогтвортой эдийн засгийн шилжилтийг дэмжих замаар олон улсын зах зээлийн шаардлагад нийцэх, нүүрстөрөгчийн зохицуулалттай худалдааны эрсдэлийг бууруулах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Хэрэглэгчийн сонголтыг шууд хязгаарлах зохицуулалт агуулаагүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Үгүй	Шууд үнийн зохицуулалт, монополь нөхцөл үүсгэх зохицуулалт агуулаагүй бөгөөд урт хугацаанд ногоон шилжилтийн үр ашгийг нэмэгдүүлнэ.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ногоон санхүүжилт, инновац, карбон зах зээлтэй холбоотой шинэ бизнесийн боломжийг нэмэгдүүлж, хувийн хэвшлийн оролцоог дэмжинэ.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй бөгөөд олон талт оролцоог дэмжсэн зохицуулалттай.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой тодорхой хэмжээний зардал үүсч болох боловч олон улсын зах зээл, ногоон санхүүжилтэд нэвтрэх боломжийг нэмэгдүүлнэ.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ногоон санхүүжилт, уур амьсгалын санхүүжилт, карбон зах зээлтэй холбоотой шинэ эх үүсвэр бий болж, хөрөнгө оруулалтын хүртээмж нэмэгдэнэ.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Тодорхой бараа бүтээгдэхүүн худалдан авахыг үүрэгжүүлсэн зохицуулалт агуулаагүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Шууд хориг, хязгаарлалт тогтоогоогүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Хувийн хэвшлийн тогтвортой, ногоон шилжилтийг дэмжихэд чиглэсэн бөгөөд үйл ажиллагааг шууд хязгаарлахгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Хүлэмжийн хийн тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотой мэдээлэл гаргах шаардлага үүсэх боловч ил тод байдал, олон улсын шаардлагыг хангах суурь нөхцөл болно.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг)	Үгүй	Өмчлөх эрхийг шууд хязгаарласан зохицуулалт агуулаагүй.

	хөндсөн зохицуулалт бий болох эсэх		
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Карбон кредит болон сааруулалтын үр дүнтэй холбоотой бүртгэл, шилжүүлгийн зохицуулалт нь өмчлөх эрхийг хязгаарлах бус, эрх зүйн тодорхой байдлыг хангах зорилготой.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Оюуны өмчийн эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Шинжлэх ухаанд суурилсан бодлого, инновац, дэвшилтэт технологийг дэмжих зарчмыг хуульчилсан.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Хүлэмжийн хийн ялгарал багатай, нөөцийн үр ашигтай технологи, инновацыг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлнэ.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Шууд нөлөөлөх зохицуулалт агуулаагүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтвортой хэрэглээний боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг дэмжих замаар хэрэглэгчдийн урт хугацааны эрх ашигт эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах, эрсдэлд тэсвэртэй дэд бүтэц, нийгэм, эдийн засгийн орчныг дэмжих замаар урт хугацаанд эерэг нөлөө үзүүлнэ.
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Ногоон санхүүжилт, сэргээгдэх эрчим хүч, карбон зах зээл, дасан зохицох төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд шинэ ажлын байр бий болох боломжтой.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Тэгш хүртээмжтэй шилжилтийн зарчмыг баримталж, шилжилтэд өртөх салбарын ажиллах хүчийг дэмжихээр тусгасан.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Жижиг, дунд үйлдвэрүүдэд ногоон санхүүжилт, шинэ технологи, тогтвортой үйлдвэрлэлийн боломжийг нэмэгдүүлнэ.
9. Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, дасан зохицох, санхүүжилт, мэдээллийн тогтолцоотой холбоотой тодорхой төсөв шаардлагатай.

	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Одоо байгаа төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Карбон зах зээл, ногоон санхүүжилт, хүлэмжийн хийн тооллого, тайлагнал, Үндэсний платформ зэрэгтэй холбоотой шинэ чиг үүрэг нэмэгдэнэ.
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ногоон хөрөнгө оруулалт, тогтвортой дэд бүтэц, инновац, олон улсын санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжинэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Уур амьсгалын болон ногоон санхүүжилтийн эрх зүйн орчин бүрдсэнээр хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, урьдчилан таамаглах боломж нэмэгдэнэ.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Үгүй	Шууд инфляц өсгөх зохицуулалт агуулаагүй.
11. Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төсөл нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Парисын хэлэлцээр болон холбогдох олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн.

#### 4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Сэргээгдэх эрчим хүч, ногоон санхүүжилт, карбон зах зээл, уур амьсгалын дасан зохицох төсөл, хөтөлбөрийн хүрээнд шинэ ажлын байр бий болох боломжийг нэмэгдүүлнэ.
	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Тэгш хүртээмжтэй шилжилтийн зарчмыг баримталж, шилжилтэд өртөх салбарын ажиллах хүчний эрх ашиг, хөдөлмөр эрхлэлтийг хамгаалахад чиглэнэ.
	1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ногоон эдийн засаг, тогтвортой үйлдвэрлэл, байгальд ээлтэй технологитой холбоотой шинэ ур чадвар, үйлчилгээний хэрэгцээг нэмэгдүүлнэ.
	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Залуучуудын ногоон ажлын байр, инновац, мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй.
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл, хөдөлмөрийн орчныг дэмжих замаар ажлын чанар, стандартыг сайжруулахад эерэгээр нөлөөлнө.
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Агаарын бохирдол, орчны эрсдэлийг бууруулах бодлого нь урт хугацаанд ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	Хөдөлмөрийн эрх зүйн суурь харилцааг өөрчлөхгүй бөгөөд ажилчдын эрхийг хязгаарлах зохицуулалт агуулаагүй.
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлтэй холбоотой тодорхой стандарт, аргачлал боловсруулах шаардлага үүсч болно.
	2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлтэй холбоотой өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Ногоон технологи, эрчим хүчний хэмнэлттэй, бага ялгарлын технологийн хэрэглээг нэмэгдүүлж, ажлын байрны шинэчлэлд эерэгээр нөлөөлнө.
3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Хуулийн төсөл нь тэгш хүртээмжтэй шилжилт, жендерийн эрх тэгш байдал, эмзэг бүлгийн оролцоог хангах зарчимд тулгуурласан.
	3.2. Эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий бүлгийг тэргүүн ээлжид хамгаалах, дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэхээр тусгасан.
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Гадаадын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, төлөвлөлт, санхүүжилт, тайлагналын ил тод, нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Хүлэмжийн хийн тооллого, Үндэсний платформ, карбон зах зээл, ногоон санхүүжилттэй холбоотой шинэ чиг үүрэг, уялдаа холбоо бий болно.
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх чиг үүрэг, тайлагнал, мэргэжлийн чадавхтай холбоотой нэмэлт үүрэг хэрэгжинэ.
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Иргэний нийгэм, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх эерэг нөлөөтэй.
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтад нөлөөлөх эсэх	Тийм	Агаарын бохирдол, уур амьсгалын эрсдэлийг бууруулах бодлого нь урт хугацаанд нийтийн эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлнэ.
	5.2. Дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Байгаль орчны чанарыг сайжруулах, бохирдлыг бууруулахад чиглэсэн тул сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маягт нөлөөлөх эсэх	Тийм	Байгальд ээлтэй хэрэглээ, тогтвортой амьдралын хэв маягийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлнэ.
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд,	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Уур амьсгалын эрсдэлд тэсвэртэй дэд бүтэц, үйлчилгээний төлөвлөлтийг дэмжинэ.

боловсролын систем	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Ногоон ур чадвар, шинэ технологийн мэдлэг, мэргэшлийн хэрэгцээг нэмэгдүүлнэ.
	6.3. Иргэдийн боловсрол эзэмших, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад нөлөөлөх эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол, чадавх бэхжүүлэх, мэргэжлийн сургалтын боломжийг өргөжүүлнэ.
	6.4. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Үйлчилгээний хүртээмжийг бууруулах зохицуулалт агуулаагүй.
	6.5. Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Судалгаа, инновац, уур амьсгалын боловсрол, шинжлэх ухаанд суурилсан бодлогыг дэмжихэд эерэг нөлөө үзүүлнэ.
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Шууд нөлөөлөх зохицуулалт агуулаагүй.
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Карбон зах зээл, тайлагнал, бүртгэлийн ил тод байдлыг хангахтай холбоотой хяналтын тогтолцоо сайжирна.
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Шууд хамааралгүй.
	7.4. Гэмт хэргийн хохирогч, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэлээс байгалийн болон соёлын өвийг хамгаалах бодлогыг дэмжинэ.
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Хэл, соёлын ялгаатай байдлыг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Уламжлалт мэдлэг, орон нутгийн оролцоонд суурилсан дасан зохицох арга хэмжээг дэмжсэнээр эерэг нөлөө үзүүлнэ.

#### 4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүч, ногоон хөгжлийг дэмжих бодлого хэрэгжсэнээр агаарын бохирдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Түлшний үр ашигтай хэрэглээ, бага ялгарлын тээврийн хэрэгсэл, тогтвортой тээврийн бодлогыг дэмжсэнээр түлшний хэрэглээг бууруулах боломж бүрдэнэ.
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, бага ялгарлын технологийг дэмжих тул эрчим хүчний үр ашиг сайжирна.
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Сэргээгдэх эрчим хүч, цэвэр технологи, бага нүүрстөрөгчийн шилжилтийг

			дэмжсэнээр эрчим хүчний салбарын шинэчлэл, үр ашигт эерэг нөлөө үзүүлнэ.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Тээврийн салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого, технологийн шинэчлэлийг дэмжсэнээр агаарын бохирдлыг бууруулахад эерэгээр нөлөөлнө.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах бодлого хэрэгжих тул сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Биологийн олон янз байдлыг хамгаалах, дасан зохицох бодлоготой уялдсан тул сөрөг нөлөө үүсгэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь амьтдын амьдрах орчны тогтвортой байдлыг хамгаалахад чиглэнэ.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутаг, экосистемийн хамгаалалтыг дэмжих тул сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Усны нөөцийн тогтвортой менежмент, уур амьсгалын эрсдэлийг бууруулах бодлого хэрэгжсэнээр усны нөөцийг хамгаалахад эерэг нөлөөтэй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Усны чанарыг хамгаалах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зарчимд нийцсэн зохицуулалттай.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ундны усны чанарыг дордуулах зохицуулалт агуулаагүй бөгөөд усны нөөцийн хамгаалалтыг дэмжинэ.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хөрс, газрын доройтлыг бууруулах, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах бодлоготой уялдсан.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Шууд газар ашиглалтын өөрчлөлт үүсгэхгүй бөгөөд нөхөн сэргээлт, тогтвортой ашиглалтыг дэмжинэ.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Шууд шинэ газар ашиглалтыг шаардахгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Газрын зориулалтыг өөрчлөхтэй холбоотой зохицуулалт агуулаагүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Тусгай хамгаалалттай болон экологийн ач холбогдолтой газрын хамгаалалтыг сулруулахгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг нөхөн сэргээгдэх чадавхыг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, шингээлтийг нэмэгдүүлэх, экосистемийн хамгаалалтыг дэмжинэ.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Бага нүүрстөрөгчийн хөгжил, сэргээгдэх эрчим хүч, ногоон шилжилтийг дэмжих тул нөхөн сэргээгдэхгүй баялгийн хамаарлыг бууруулахад чиглэнэ.

## ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙСЭН БАЙДАЛ

Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг урьдчилан тандан судлахдаа тухайн хувилбар нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх боломж, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал-үр өгөөжийн харьцаа, урт хугацааны тогтвортой байдлыг харгалзан харьцуулан үнэлэв.

Судалгааны хүрээнд “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизм ашиглах, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх, захиргааны шийдвэр гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг зохицуулалтын хувилбаруудыг авч үзсэн болно.

Хүснэгт 1. Зохицуулалтын хувилбаруудын харьцуулалт

Зохицуулалтын хувилбар	Давуу тал	Сул тал	Зорилгод хүрэх түвшин
<b>“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах</b>	Шууд нэмэлт зардал, институцийн өөрчлөлт шаардахгүй	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх эрх зүйн хийдэл, салбар хоорондын уялдаа сул байдал, хүлэмжийн хийн тооллого, тайлагнал, карбон зах зээл, ногоон санхүүжилтийн зохицуулалтын тодорхойгүй байдал хэвээр үлдэнэ	Маш бага
<b>Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх</b>	Иргэд, аж ахуйн нэгжийн мэдлэг, ойлголт, оролцоог нэмэгдүүлнэ	Зөвхөн сайн дурын шинжтэй нөлөө үзүүлэх бөгөөд төрийн байгууллагын бүрэн эрх, тайлагнал, санхүүжилт, карбон зах зээл зэрэг суурь харилцааг зохицуулах боломжгүй	Бага
<b>Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх</b>	Ногоон санхүүжилт, эдийн засгийн урамшуулал, хувийн хэвшлийн оролцоог дэмжих боломжтой	Эрх зүйн суурь орчингүй нөхцөлд карбон кредит, ИТМО, харгалзах тохируулга, тайлагнал зэрэг нарийн харилцааг бүрэн зохицуулах боломжгүй	Дунд
<b>Төрөөс санхүүгийн интервенц хийх</b>	Ногоон төсөл, дасан зохицох арга хэмжээг шууд дэмжих боломжтой	Улсын төсөвт ачаалал үүсгэнэ. Тогтвортой эрх зүйн болон институцийн тогтолцоо бүрдүүлэхгүй	Дунд
<b>Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх</b>	Мэргэжлийн байгууллага, хувийн хэвшлийн оролцоо, инновацыг нэмэгдүүлнэ	Үндэсний хэмжээнд нэгдсэн бодлого, хяналт-шинжилгээ, олон улсын тайлагнал, төрийн бүрэн эрхийн асуудлыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй	Дунд
<b>Захиргааны шийдвэр гаргах</b>	Журам, аргачлал, дүрэм зэргийг богино хугацаанд баталж хэрэгжүүлэх боломжтой	Эрх зүйн тогтвортой байдал сул, төрийн байгууллагын бүрэн эрх, оролцогч талуудын эрх, үүрэг, карбон зах зээлийн	Дунд

		суурь зохицуулалтыг бүрэн тогтоох боломжгүй	
<b>Хууль тогтоомжийн төсөл боловсруулах</b>	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг бодлого, төлөвлөлт, санхүүжилт, хяналт-шинжилгээ, хүлэмжийн хийн тооллого, карбон зах зээл, ногоон санхүүжилт, төрийн байгууллагын бүрэн эрх зэрэгтэй нь уялдуулан нэгдсэн тогтолцоогоор цогцоор нь зохицуулах боломж бүрдэнэ	Эхний шатанд институцийн чадавх, мэдээллийн тогтолцоо, тайлагнал, хэрэгжилттэй холбоотой тодорхой хэмжээний зардал шаардагдана	Өндөр

“Тэг” хувилбар нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх өнөөгийн эрх зүйн хийдэл, институц хоорондын уялдаа сул байдал, хүлэмжийн хийн тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцооны тодорхойгүй байдал, карбон зах зээл болон ногоон санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтын дутагдлыг хэвээр үлдээх сул талтай байна. Түүнчлэн Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалтгүй байх, олон улсын тайлагнал, уур амьсгалын санхүүжилт болон карбон зах зээлд оролцох боломж хязгаарлагдах эрсдэлтэй гэж үзэв.

Олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизм ашиглах, төрөөс санхүүгийн интервенц хийх зэрэг хувилбарууд нь тодорхой хүрээнд эерэг нөлөөтэй боловч эдгээр нь зөвхөн салангид бодлогын арга хэмжээний түвшинд хэрэгжих боломжтой бөгөөд төрийн байгууллагын бүрэн эрх, хяналт-шинжилгээ, тайлагнал, нэгдсэн төлөвлөлт, Үндэсний платформ, харгалзах тохируулга, карбон зах зээл зэрэг олон талт харилцааг бүрэн зохицуулах боломжгүй байна. Иймээс эдгээр хувилбар нь хуулийн төслийн зорилт болох уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг нэгдсэн тогтолцоогоор зохицуулах зорилгод бүрэн хүрэхгүй гэж дүгнэв.

Захиргааны шийдвэр гаргах хувилбар нь тодорхой журам, аргачлал батлах замаар зарим асуудлыг богино хугацаанд зохицуулах давуу талтай боловч эрх зүйн тогтвортой орчин бүрдүүлэх, төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлох, оролцогч талуудын эрх, үүргийг тогтоох, олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах, карбон зах зээл болон ногоон санхүүжилтийн суурь эрх зүйн орчныг бүрдүүлэхэд хангалтгүй гэж үзэв.

Харин Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах хувилбар нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, даван туулах бодлого, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилт, хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, ногоон болон уур амьсгалын санхүүжилт, карбон зах зээл, Үндэсний платформ, төрийн байгууллагуудын бүрэн эрх, салбар хоорондын уялдаа холбоо зэрэг харилцааг нэгдсэн тогтолцоогоор цогцоор нь зохицуулах боломжтой хамгийн үр дүнтэй хувилбар гэж үнэлэгдэв.

#### Хүснэгт 2. Зардал үр өгөөжийн харьцуулалт

Үзүүлэлт	Сөрөг нөлөө	Эерэг нөлөө
<b>Аж ахуйн нэгж</b>	Шууд нөлөө бага	Ногоон болон уур амьсгалын санхүүжилт авах, карбон зах зээлд оролцох боломж бий болох, ногоон технологи, бага нүүрстөрөгчийн хөгжил, тогтвортой үйлдвэрлэл, инновац хөгжих, ногоон ажлын байр бий болох
<b>Төр</b>	Институцийн зардал	Олон улсын уур амьсгалын санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, карбон зах зээлд оролцох эрх зүйн нөхцөлийг

		бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эдийн засаг, нийгэм, байгаль орчны эрсдэлийг бууруулах
<b>Иргэд</b>	Шууд нөлөө бага	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл сайжрах, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлээс хамгаалах тогтолцоо бэхжих, ногоон ажлын байр болон тогтвортой орлогын боломж нэмэгдэх, орон нутгийн болон эмзэг бүлгийн дасан зохицох чадавх сайжрах

Зардал, үр өгөөжийн харьцааны хувьд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагын чадавх, мэдээллийн тогтолцоо, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалттай холбоотойгоор тодорхой хэмжээний институцийн болон захиргааны зардал үүсэхээр байна. Гэвч эдгээр зардал нь урт хугацаанд ногоон хөрөнгө оруулалт татах, олон улсын уур амьсгалын санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, карбон зах зээлд оролцох эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эдийн засаг, нийгэм, байгаль орчны эрсдэлийг бууруулах үр өгөөжөөс бага байна гэж үзэв.

Мөн хуулийн төсөл батлагдсанаар сэргээгдэх эрчим хүч, ногоон технологи, бага нүүрстөрөгчийн хөгжил, тогтвортой үйлдвэрлэл, инновац, ногоон ажлын байр бий болох, хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөмтгий бүлгийн дасан зохицох чадавх сайжрах зэрэг урт хугацааны эерэг үр нөлөөтэй байна.

Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хуульчлан зохицуулахгүй байх тохиолдолд Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилт сулрах, хүлэмжийн хийн тайлагнал, ил тод байдлын тогтолцоо олон улсын шаардлагад нийцэхгүй байх, карбон зах зээлд оролцох эрх зүйн чадамж хангалтгүй хэвээр үлдэх, улмаар олон улсын санхүүжилт, хөрөнгө оруулалт татах боломж буурах эрсдэлтэй байна.

Иймд зохицуулалтын хувилбаруудыг зорилгод хүрэх байдал, зардал-үр өгөөжийн харьцаа, урт хугацааны тогтвортой үр нөлөө, эрсдэлийн түвшин зэргээр харьцуулан үзэхэд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хамгийн оновчтой, үр ашигтай, тогтвортой зохицуулалтын хэлбэр гэж дүгнэв.

## ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙСЭН БАЙДАЛ

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсонтой холбогдуулан уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт, түүнчлэн бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн сайн туршлагыг харьцуулан судлав. Энэхүү харьцуулсан судалгааг хийхдээ Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, Парисын хэлэлцээрийн хэрэгжилт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох, ногоон санхүүжилт, карбон зах зээл, хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, ил тод байдлын тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг харгалзан үзсэн болно.

Олон улсын эрх зүйн зохицуулалтын хувьд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц, Парисын хэлэлцээр, Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл, түүний хэрэгжилттэй холбоотой Талуудын бага хурлын шийдвэр, ил тод байдлын хүрээ, үндэсний тодорхойлсон хувь нэмэр, хоёр болон олон талт хамтын ажиллагаа, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн, харгалзах тохируулга, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын шаардлагуудыг харьцуулан авч үзэв.

Одоогоор дэлхийн 70 гаруй улс уур амьсгалын өөрчлөлт, карбон зах зээл, ногоон хөгжлийн асуудлыг зохицуулсан тусгайлсан хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлээд байгаа бөгөөд энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн засаглалыг зөвхөн бодлого, стратеги, төсөл, хөтөлбөрийн түвшинд бус, харин нэгдсэн эрх зүйн тогтолцооны хүрээнд цогцоор нь зохицуулах дэлхий нийтийн чиг хандлага бүрдэж байгааг харуулж байна. Иймд бусад улсын хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийхдээ эрх зүйн соёл, газар зүйн болон эдийн засгийн нөхцөл, эрх зүйн эх сурвалжийн ангилал, мөн уур амьсгалын өөрчлөлт, карбон зах зээл, ногоон санхүүжилтийн зохицуулалтаар дэвшилтэт туршлага хэрэгжүүлж буй байдлыг харгалзан Их Британи, Герман, Австри, Йордан, Гана, Кени, Филиппин зэрэг улсыг сонгон судлав. Эдгээр улс нь уур амьсгалын өөрчлөлтийн эрх зүйн зохицуулалтыг өөрийн улс төр, эдийн засаг, институцийн онцлогт нийцүүлэн хөгжүүлсэн боловч нийтлэг байдлаар уур амьсгалын засаглал, хүлэмжийн хийн бууралтын зорилт, карбон зах зээл, ногоон санхүүжилт, ил тод байдал, тайлагналын тогтолцоог хуульчилсан цогц зохицуулалтын загварыг бүрдүүлсэн байна.

График 1. Уур амьсгалын өөрчлөлтийн суурь хуультай улсын нийт тоон мэдээлэл, батлагдсан оноор



## 6.1. Их Британи Улс

2008 онд Их Британи улс Уур амьсгалын өөрчлөлтийн хууль<sup>19</sup> (Climate Change law)-ийг баталснаар энэ чиглэл дэх анхдагч болж улс орнуудын уур амьсгалын чиглэлээр гаргаж мөрдүүлэх хууль эрх зүйн баримт бичгийн суурь болсон. Олон орнууд Их Британи улсын уур амьсгалын өөрчлөлтийн хуулиас (1) нүүрстөрөгчийн ялгарлын төсөв болон хугацаа, (2) бие даасан хүчтэй хяналтын тогтолцоо, (3) шинжлэх ухааны салбар болон мэргэжилтнүүдийн оролцоо зэрэг ойлголтуудыг<sup>20</sup> суурь болгон авсан байна.

Хуулийн гол зорилго нь “2050 гэхэд хүрэх хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээг тогтоох; нүүрстөрөгчийн ялгарлын төсвийн тогтолцоог бий болгох; Уур амьсгалын өөрчлөлтийн хороо байгуулах; хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлах, эсхүл ялгарлыг бууруулах, эсхүл агаар мандлаас хүлэмжийн хийг зайлуулах үйл ажиллагааг дэмжих зорилгоор арилжааны тогтолцоо бий болгох эрхийг олгох; уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар зохицуулалт хийх; ахуйн хог хаягдлыг бага үйлдвэрлэх, үйлдвэрлэсэн хог хаягдлыг дахин боловсруулахад санхүүгийн урамшуулал олгох тогтолцоо бий болгох эрхийг олгох; ахуйн хог хаягдлыг цуглуулах талаар зохицуулалт хийх; нэг удаагийн уутны төлбөр авах тухай зохицуулалт хийх эрхийг олгох; 2004 оны Эрчим хүчний тухай хуулийн сэргээгдэх тээврийн түлшний үүргийн тухай заалтад өөрчлөлт оруулах; нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилтын талаар заалт оруулах; уур амьсгалын өөрчлөлтийн талаар бусад заалт оруулах” гэж заасан байна.

Их Британийн Уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь дараах гол онцлог санаа, зохицуулалттай. Үүнд:

- Хуульд зааснаар 2050 он гэхэд нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээг Их Британи улсын 1990 оны төвшинд хүртэл 100 хувиар бууруулна (2019 онд өөрчлөлтөөр) гэж хүрэх зорилтоо тодорхойлсон.
- Нүүрстөрөгчийн ялгаралд төсөвлөх санааг оруулсан. Төсөв нь нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээ хэдэн онуудад ямар хэмжээнд хүрэхийг харуулдаг өөрөө хэлбэл үечилсэн хугацаа болон хэмжих үзүүлэлттэй. Хуулийн анхлан баталсан хувилбарт нүүрстөрөгчийн төсөв нь 2008-2012, 2013-2017, 2018-2022 гэсэн 5 жилийн үечлэл бүхий хугацаануудад хуваагдаж дараагийн үечлэлийг 2020 оны 6 сарын 31-ээс өмнө тогтоохоор заасан байна. Нүүрстөрөгчийн ялгарлын хэмжээг 2020 он хүртэлх хугацаанд 1990 оны төвшинтэй харьцуулахад 34 хувиар бууруулах, дараагийн хугацаануудад хамгийн багадаа 34 хувиар бууруулснаар 2050 онд 1990 оны төвшинд 100 хувь хүргэхээр тооцжээ.
- Хуулийн дагуу нүүрстөрөгчийн ялгарлын төсөвт өөрчлөлт оруулах боломжтой боловч Засгийн газар төсөвт ямар нэгэн өөрчлөлт оруулахаар бол Уур амьсгалын өөрчлөлтийн Хороо (Committee on Climate Change) болон бусад албан ёсоор томилогдсон төлөөллүүдтэй заавал зөвлөлдөх ёстой. Төсөвт оруулах өөрчлөлтийг Засгийн газар эсвэл Уур амьсгалын өөрчлөлтийн Хорооны санал, зөвлөмжийг үндэслэхээс гадна дараах шалтгаануудыг харгалзана. Үүнд:
  - 1) уур амьсгалын өөрчлөлтийн талаарх шинжлэх ухааны мэдлэг;
  - 2) уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой технологи;
  - 3) эдийн засгийн нөхцөл байдал, ялангуяа эдийн засгийн талаарх шийдвэрүүдийн нөлөөлөл, эдийн засгийн тодорхой салбаруудын өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөөлөл;

<sup>19</sup> Climate Change Act 2008 (с.27)

<sup>20</sup> Climate laws in Europe good practices in net-zero management, net zero 2050, Eco logic, February 2020

- 4) төсвийн нөхцөл байдлууд ялангуяа татвар ногдуулалт, төсвийн зарцуулалт, засгийн газар зээл авах зэрэгт гаргасан шийдвэрүүдийн нөлөөлөл;
  - 5) нийгмийн нөхцөл байдлууд ялангуяа эрчим хүчний хомсдолд гаргасан шийдвэрийн нөлөөлөл;
  - 6) эрчим хүчний бодлого, ялангуяа эрчим хүчний нийлүүлэлт, нүүрстөрөгчийн чиглэл мөн эдийн засаг дахь эрчим хүчний эрчимжилтийн талаарх шийдвэрийн нөлөөлөл;
  - 7) Англи, Уэльс, Шотланд, Умард Ирландын нөхцөл байдлын ялгаанууд;
  - 8) Европын болон олон улсын нөхцөл байдлууд;
  - 9) Төсвийн хугацаанд олон улсын агаарын тээвэр болон тээврийн үйл ажиллагаанаас хамаарсан хүлэмжийн хийн ялгарлын тооцоолсон хэмжээ.
- Хуульд мөн хүлэмжийн хийнд нийт 6 төрлийн хийг нэрлэж оруулснаас гадна Засгийн газрын шийдвэрээр хүлэмжийн хийн ангилалд хамруулах бусад хийг мөн оруулахаар заасан. Мөн нүүрсхүчлийн хийнээс бусад 5 төрлийн хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг жишиж хэмжин суурь онуудыг тогтоосон. Тухайлахад, метаны суурь он нь 1990 он гэх мэт.

Уур амьсгалын өөрчлөлтийн Хороо (Committee on Climate Change) нь 2050 онд хүрэх зорилтын хүрээнд нүүрстөрөгчийн ялгарлын төсөвтэй холбоотой зөвлөмж өгнө, мөн олон улсын агаарын тээвэр болон тээврийн үйл ажиллагаанаас хамаарсан хүлэмжийн хийн ялгарлын асуудалд зөвлөмж өгнө. Үүнээс гадна парламентад явцын талаар мэдээлэх болон шаардлагатай зөвлөмжийг Засгийн газрын төлөөллийн хүсэлтээр өгнө. Хороо нь гэрээ хийх, өмч хөрөнгө авах, эзэмших, шилжүүлэх, мөнгө зээлэх, мөнгөөр хөрөнгө оруулалт хийх эрхтэйгээс гадна мэдээлэл цуглуулж судалгаа, шинжилгээ хийх, энэ төрлийн ажилд бусад этгээдийг хөлслөх, судалгааны үр дүнг хэвлэх, нийтлэх эрхтэй. Засгийн газрын төлөөлөл нь хуульд заасан нөхцөл бүрдсэн гэж үзвэл Хороонд тодорхой мөнгөн тэтгэлэг өгч болно.

## 6.2. Герман Улс

Герман улс Уур амьсгалын өөрчлөлтийн холбооны хууль<sup>21</sup> (Federal Climate Change law) -аа 2019 онд анхлан баталж 2021 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хуулийн зорилго нь уур амьсгалын үндэсний болон Европын зорилтод хүрэх замаар дэлхийн дулаарлын нөлөөллөөс хамгаалах хамгаалалт бий болгох явдал гэж тодорхойлсон. Хууль нь 5 бүлэг 15 зүйлтэй. Дараах гол онцлог санаа, зохицуулалттай. Үүнд:

- Хуулийн үндэслэл нь Парисын хэлэлцээрийн дагуу Герман улсын хүлээсэн үүрэг гэж хуульдаа тодотгосон.
- Хүлэмжийн хийн ангилалд нийт 7 төрлийн хийг нэр болон химийн томьёоны хамт тодорхойлж оруулсан.
- Уур амьсгалын үндэсний зорилтыг “хүлэмжийн хийн хэмжээг 1990 оны төвшинд хүртэл бууруулна, мөн 2030 гэхэд хүрэх зорилтот хэмжээний 55 хувьд хүргэнэ” гэж тодорхой хугацаа, зорилтот хэмжээ зааж оруулсан.
- Тухайн жилийн хүлэмжийн хийн ялгарлын төсвийг (emission budget) 6 салбараар 2030 он хүртэл тооцож анхлан баталсан 2019 оны хуульд хавсралт болгон дараах байдлаар оруулсан:

---

<sup>21</sup> Federal Climate Change Act of 12 December 2019 (Federal Law Gazette I, p. 2513)

Салбарууд	Жилийн хүлэмжийн хийн ялгаруулалтын төсөв, мянган тонн CO <sub>2</sub>										
	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Эрчим хүч	280		257								175
Аж үйлдвэр	186	182	177	172	168	163	158	154	149	145	140
Барилга	118	113	108	103	99	94	89	84	80	75	70
Тээвэр	150	145	139	134	128	123	117	112	106	101	95
Хөдөө аж ахуй	70	68	67	66	65	64	63	61	60	59	58
Хог хаягдал	9	9	8	8	7	7	7	6	6	5	5

Эх үүсвэр: Уур амьсгалын өөрчлөлтийн хууль, Герман улс, 2019 он

- Засгийн газар 2025 онд хүлэмжийн хийн ялгарлын төсвийг 2030 оноос хойших хугацаануудад шинээр тогтооно.
- Хүлэмжийн хийн ялгарлын дата, мэдээллийг Байгаль орчин, байгаль хамгаалал, цөмийн энергийн аюулгүй байдлын яамны харьяа Хүрээлэн байгаа орчны агентлаг дээрх салбар бүрээр цуглуулж бүрдүүлнэ, мөн хэвлэж Уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтнүүдийн зөвлөлд хүргүүлнэ.
- Уур амьсгалын үйл ажиллагааны төлөвлөгөө (Climate action plan) нь Парисын хэлэлцээрийн амлалтыг хэрэгжүүлэх урт хугацааны стратегийн баримт бичиг бөгөөд Герман улсын Засгийн газар 2016 оны 11 сард баталсан. Энэхүү төлөвлөгөө дээр үндэслэн тухайн жилд хийгдэх үйл ажиллагаануудыг багтаасан Уур амьсгалын үйл ажиллагааны хөтөлбөрийг (Climate action programmes) баталдаг.
- Уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтнүүдийн зөвлөл (Council of expert on climate change) нь цаг уур, хүрээлэн байгаа орчин, эдийн засаг, нийгмийн салбарт мэргэшсэн 5 мэргэжилтнээс бүрдэнэ. Зөвлөл нь 6 салбараар гаргасан Хүлэмжийн хийн ялгарлын дата, мэдээллийг төсөвлөсөн хэмжээтэй харьцуулж шалгах, мөн Засгийн газарт зөвлөмж өгөх үүрэгтэй. Энэ зөвлөл Засгийн газраас уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг явуулж байгаа үйл ажиллагаанууд, Хүлэмжийн хийн ялгарлын дата, мэдээлэл, явуулж бүрэн бие даасан дүгнэлт, зөвлөмж гаргах эрхтэй, Уур амьсгалын үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт санал, зөвлөмж өгнө.
- Засгийн газар орон нутгийн төлөөлөл, бизнесийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд ажилладаг шинжлэх ухааны байгууллагууд, зөвлөхүүдийг уур амьсгалын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд олон нийттэй зөвлөлдөх хэлбэрээр татан оролцуулдаг.

### 6.3. Австри Улс

Австри улс Уур амьсгалын хамгаалалтын хуулиа<sup>22</sup> (Climate protection act) 2011 онд батлан гаргаж өнгөрсөн хугацаанд нэмэлт өөрчлөлтүүд хийсэн. Уур амьсгалын хамгаалалтын хууль дараах гол онцлог санаа, зохицуулалттай. Үүнд:

- Хууль нь “уур амьсгалыг хамгаалах үр дүнтэй арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэх боломжийг олгох зорилготой”.
- Хуулиар өмнө нь байгаагүй шинэ бүтэц болох Уур амьсгалыг хамгаалах үндэсний хороо (National Climate Protection Committee)-г шинээр байгуулсан. Энэ хороо өмнө байгуулсан бүтцүүдтэй уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хамтран ажиллах бөгөөд Хорооны үүргийг “Парисын хэлэлцээрийн зорилтуудын хүрээнд Австрийн уур амьсгалын бодлоготой

<sup>22</sup> Consolidated federal law; Entire legal regulation for the Climate Protection Act, version dated 05.12.2021

холбоотой үндсэн асуудлууд, ялангуяа нүүрстөрөгч багатай нийгэмд чиглэсэн хүлэмжийн хийн ялгарлыг урт хугацаанд бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн зайлшгүй үр дагаварт дасан зохицох мөн эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн эрчим хүчний эцсийн хэрэглээнд эзлэх хувийг нэмэгдүүлэх урт хугацааны хувилбарууд талаар зөвлөгөө өгнө” гэж тодорхойлсон.

- Уур амьсгалыг хамгаалах үндэсний хороог Хөдөө аж ахуй, ой, байгаль орчин, усны асуудал хариуцсан сайд толгойлно.
- Энэ хууль нь Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль (2014), Ногоон Цахилгааны тухай хууль (2011), Уур амьсгал болон эрчим хүчний сангийн тухай хууль (2007), Хүрээлэн байгаа орчны дэмжлэгийн тухай хууль (1993) гэсэн хуулиудаар дамжуулан зорилтоо хэрэгжүүлдэг<sup>23</sup>. Эдгээр хуулиудын зорилтуудад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь нэг хэсэг болж орсон нөгөө талаар уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд авч хэрэгжүүлэх зохицуулалтууд, авах арга хэмжээнүүд нь чухал салбарууд дээр нарийвчлан туссан. Тийм учраас Уур амьсгалын хамгаалалтын хууль нь эдгээр хуулиудтай нийцэж хэрэгжих бололцоо бүрдсэн, нөгөө талаар хууль нь бүтцийн хувьд олон тооны зохицуулалт, заалт бүхий нүсэр болоогүй.
- Олон улсын гэрээ хэлэлцээрээс Парисын хэлэлцээрийг Уур амьсгалыг хамгаалах үндэсний хорооны үүрэгт тусгасан өөрөөр хэлэлцээрийг дурдаагүй боловч хүлэмжийн хийн ялгарлын босго хэмжээг хог хаягдал, эрчим хүч, үйлдвэр, фторжуулсан хий, барилга байгууламж, хөдөө аж ахуй, тээвэр зэрэг салбаруудад тогтоосон.

#### **6.4. Йордан Улс**

Йордан улс уур амьсгалын өөрчлөлтийн тухайлсан хуульгүй харин энэ хүрээнд хийж байгаа алхмууд нь засгийн газрын бодлого, хөтөлбөрөөр явагддаг. 1999 оноос 2017 оны хооронд нийт 10 төрлийн үндэсний стратеги, төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүд гаргасан байна.<sup>24</sup>

Тус улс 2013 онд Ойрх Дорнодын орнуудаас анхлан Уур амьсгалын өөрчлөлтийн 2013-2020 оны үндэсний бодлогыг (National climate change policy 2013-2020)<sup>25</sup> баталсан. Энэхүү бодлого нь урт хугацааны 3 зорилттой. Үүнд:

- Йордан улсыг ус болон хөдөө аж ахуйн тогтвортой нөөцтэй, эрүүл экосистем, уур амьсгалд дасан зохицох суурин, нэгдлүүдтэй “бага нүүрстөрөгч бүхий эдийн засгийн хөгжил”-тэй хэвээр байлгаж, уур амьсгалын эрсдэлд уян хатан, илүү идэвх санаачилгатай болгох;
- Уур амьсгалын өөрчлөлтөд ялангуяа усны нөөц болон хөдөө аж ахуйтай холбоотой экосистемийн дасан зохицолтыг нэмэгдүүлэх, сөрөг үр нөлөөг нь бууруулахад бүх боломжийг ашиглаж чадахуйц мөн жендер болон эмзэг бүлгийн нийгмийн асуудлыг хамруулсан тийм суурин, нэгдлүүд болон институтүүдийн дасан зохицох чадавхыг бэхжүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицохыг нэн тэргүүнд тавих, гэхдээ Йордан улсын харьцангуй бага нүүрстөрөгч ялгаруулдаг эдийн засаг болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй усны хомсдолд өртөмтгий байдлыг харгалзан дасан зохицохыг илүүтэйгээр чухалчлах.

<sup>23</sup> Climate change legislation in Austria, An expert from the 2015 Global Climate Legislation study, Michael Nachmany and others, Grantham Research Institute on Climate Change and the Environment, Globe, Interparliamentary Union

<sup>24</sup> Climate Change Profile, Jordan, Ministry of Foreign Affairs, [https://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/Jordan\\_2.pdf](https://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/Jordan_2.pdf)

<sup>25</sup> The Globe Climate Legislation Study, Fourth Edition, Globe International, 2014

Энэ үед уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд тухайлсан хуульгүй, дээрх бодлого нь Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль болон Цахилгааны тухай хуульд тулгуурладаг байсан.

Тус улс 2017 онд Байгаль орчны хамгаалалтын тухай (Environmental Protection Law) хуулийг баталж 2019 онд энэхүү хуулийн хүрээнд Уур амьсгалын хамгаалалтын тухай тогтоолыг (Climate protection act) гаргасан нь уур амьсгалын чиглэлд тухайлан гаргасан хамгийн сүүлийн эрх зүйн баримт бичиг юм.

Тогтоолын зорилго, агуулга, бүтэц, зохицуулалтаас:

- Энэ тогтоол 9 бие даасан зүйлтэй, хуулийн хэлбэрээр бичигдсэн, уур амьсгалын чиглэлд Йордан улсын хийх ажлын төлөвлөгөө, авах арга хэмжээнүүдийг оруулаагүй харин энэ чиглэлд оролцож төрийн байгууллагууд, албан тушаалтнууд, хариуцах үүрэг зэргийг илүүтэйгээр тодотгосон.
- Энэ тогтоол нь Йордан улсын оролцсон Киотогийн протокол, Парисын хэлэлцээрийг<sup>26</sup> иш болгосон анхны баримт бичиг.
- Уур амьсгалын хүрээнд хамрах ойлголтууд, тодорхойлолтууд, нэршил (хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох, хүлэмжийн хийн үндэсний тооллого<sup>27</sup>), нэр томъёо, арга хэмжээнүүдийг тайлбарлаж оруулсан (Зүйл 1),
- Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороотой (National Committee Climate Change Committee) байх бөгөөд хороог Байгаль орчны сайд (Minister of Environment) тэргүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнд 14 яам, 1 хотын дарга, тусгай статустай хотын 1 төлөөлөгч орно.
- Хороо нь хийх ажлын хүрээнд Байгаль орчны яам голлон харьцдаг байгууллагуудаас (focal points) бүрдсэн ажлын хэсгүүд байгуулах, тухайлсан асуудлаар хөндлөнгийн мэргэжилтэн урих эрхтэй. Хороо дараах эрх, үүрэгтэй:
  1. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон улсын конвенц, хэлэлцээрийг үндэсний тэргүүлэх ач холбогдол, олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийн дагуу хэрэгжүүлэх, хянах чиглэлээр салбарын яамдаас ирүүлсэн төслийн саналыг батлах.
  2. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр болон Үндэсний дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх, шинэчлэх процессыг хянах мөн Йорданы олон улсын үүргийн дагуу бэлтгэх бусад тайлангуудыг батлах.
  3. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн мөрөөр холбогдох байгууллагуудад үнэлгээ өгөх; энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн тусгай зөвлөмжүүд бэлтгэх.
  4. Уур амьсгалын өөрчлөлттэй холбогдох шаардлагатай хууль тогтоомжийг үндэсний тэргүүлэх чиглэл, олон улсын өмнө хүлээсэн үүргийн дагуу санал болгох.
  5. Холбогдох байгууллагуудын уялдааг хангах үүднээс үйл ажиллагааны төлөвлөгөө, нөлөөллийг бууруулах, дасан зохицох хөтөлбөрүүдийг батлах,
  6. “Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн үндэсний стратеги” (National Climate Change Financing Strategy)-ийг боловсруулах талаар зөвлөмж батлах,
  7. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шинээр гарч ирж буй технологийг холбогдох байгууллагуудын санал болгож буй хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэвтрүүлэхийг зөвшөөрөх,
  8. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байгууллагуудыг чадавхжуулах хэрэгцээ шаардлагыг нь хүлээн авах,

<sup>26</sup> Climate Change Regulation No.() of 2018 Project, Jordan, 2019

<sup>27</sup> “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээний хувь нэмрийн зорилт” тайлангаас энэ нэршлийг авсан

9. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үндэсний судалгаа, судалгааны үр дүнг баталж, тэдгээрийг үндэсний тэргүүлэх чиглэлд тусгах, нэгтгэх.
- Тогтоолд заасны дагуу Байгаль орчны яам нь дараах үүрэг, эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
    1. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (UNFCCC), протоколууд болон сангуудын үндэсний төлөөлөгчийг үүрэг гүйцэтгэнэ,
    2. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хязгаарлах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, дасан зохицох бодлого, стратегитай холбоотой төслийн саналыг холбогдох байгууллагуудын салбарт суурилсан стратеги, бодлоготой уялдуулах зорилгоор Засгийн газарт өргөн мэдүүлэх, батлуулахын тулд Хороонд хүргүүлэх,
    3. Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, үндэсний мэдээ мэдээлэл, хоёр жил тутмын шинэчилсэн тайлан, Үндэсний дасан зохицох хөтөлбөр болон олон улсын өмнө хүлээсэн бусад баримт бичгийг боловсруулж, шинэчлэх,
    4. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх олон улсын агентлагуудын өмнө Йордан улсыг төлөөлөх,
    5. Хүлэмжийн хийг бууруулах, дасан зохицох арга хэмжээ, уур амьсгалын санхүүжилтийн өгөгдлүүдийг баримтжуулах зорилгоор Үндэсний хүлэмжийн хийн тооллого (National Inventory Registry) зориулан мэдээллийн сан байгуулж, удирдана,
    6. Үндэсний хүлэмжийн хийн тооллогын тайлангийн үр дүнг баталгаажуулахын тулд тусгайлан гаргасан зааварчилгааны дагуу тодорхой шалгуур, стандартаар баталгаажуулах байгууллагуудыг батална,
    7. Олон улсын уур амьсгалын ижил төстэй судалгааны төвүүдтэй харилцаа тогтоох замаар шинжлэх ухааны судалгааны төвүүдэд техникийн дэмжлэг үзүүлнэ.
    8. Хүлэмжийн хийн ялгарлыг богино хугацаанд мэдээлэх тал дээр холбогдох байгууллагуудтай уялдан ажиллах,
    9. Тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөний төрлийг тодорхойлсон уур амьсгалын санхүүжилтийн үндэсний төлөвлөгөөг Төлөвлөлт, олон улсын хамтын ажиллагааны яам (Ministry of Planning and International Cooperation) болон холбогдох байгууллагуудтай уялдуулна,
    10. Уур амьсгалын өөрчлөлтийн зах зээлийн механизмыг холбогдох байгууллагуудтай уялдуулах.
  - Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байгууллагууд нь тогтоолын дагуу (1) Хороонд тухайн байгууллагыг төлөөлөх төлөөлөгчөө томилох, (2) салбарт суурилсан төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэхдээ уур амьсгал бууруулах үндэсний стратеги, төлөвлөгөө, бодлогын зорилтыг уялдуулах, (3) Байгаль орчны яаманд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хүрээнд хийгдсэн дэвшлийн талаар мэдээлэх, (4) НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц Жендерийн шаардлага, эмзэг байдлыг харгалзан НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенцод нийцүүлэн технологи дамжуулах, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр Байгаль орчны яамны хэрэгцээг хангах.
  - Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байгууллагууд нь Үндэсний хүлэмжийн хийн тооллогод бүртгэгддэг хүлэмжийн хийн ялгарал, дасан зохицох үзүүлэлтүүдтэй холбоотой тухайн салбарын хүлэмжийн хийн мэдээллийн жилийн тайлан гаргана, мөн нэр бүхий байгууллагууд (тухайлахад Йорданы Боловсролын яам, Төв банк) Хүлэмжийн хийн үндэсний тооллогыг баталгаажуулах явцад өөрсдийн чиглэлийн дагуу шаардлагатай техник тусалцааг Байгаль орчны яаманд үзүүлнэ.

## 6.5. Гана улс

Гана улс нь Африк тивийн хэмжээнд Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл, тэр дундаа Олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн (ITMO) болон сайн дурын нүүрстөрөгчийн зах зээлийн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр тэргүүлэгч улсын нэг болж байна. Тус улс уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг зөвхөн байгаль орчны хамгааллын хүрээнд бус, харин эдийн

засгийн өсөлт, хөрөнгө оруулалт, тогтвортой санхүүжилт, олон улсын хамтын ажиллагааг дэмжих хөгжлийн шинэ боломж гэж үзэн бодлого, зохицуулалтаа хөгжүүлж байна. Энэ хүрээнд Гана улс нь Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд хэрэгжих олон улсын карбон зах зээлийн механизмыг бодитой хэрэгжүүлсэн анхны улсуудын нэг болж, хөгжиж буй орнуудын хувьд жишиг болохуйц туршлага бүрдүүлээд байна.

Гана улс нь хөгжиж буй орнуудын дундаас Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлд нийцсэн, карбон зах зээлийн бэлэн байдлыг хамгийн иж бүрэн, хөгжингүй түвшинд бүрдүүлсэн улсын нэг гэж үнэлэгддэг. Тус улс 2022 оны 9 дүгээр сард Засгийн газрын түвшинд баталсан “Олон улсын карбон зах зээл болон зах зээлийн бус арга механизмын үндэсний журам” (National Framework on International Carbon Markets and Non-Market Approaches)-гээр дамжуулан Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн зохицуулалтыг үндэсний хэмжээнд бүрэн ажиллагаатай тогтолцоо болгон хэрэгжүүлсэн байна. Энэхүү хүрээ нь зөвшөөрөл олголт, тооцоолол, үндэсний бүртгэлийн дэд бүтэц, харгалзах тохируулга, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын (MRV) тогтолцоог цогцоор нь зохицуулдаг бөгөөд Гана улсын Үндсэн хуульд заасан байгаль орчныг хамгаалах төрийн үүрэгтэй уялдсан байна. Мөн уг тогтолцоог 1994 оны Байгаль орчныг хамгаалах агентлагийн тухай хууль (Environmental Protection Agency Act 490)-д тулгуурлан хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид хууль эрх зүйн зохицуулалтыг улам бэхжүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлтүүдийг боловсруулж байна.

Түүнчлэн энэхүү үндэсний хүрээ нь Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлд заасан хамтын ажиллагааны механизмд оролцох Гана улсын үндэсний зохицуулалтыг тогтоохоос гадна 6.4 дүгээр зүйлийн механизмын хэрэгжилтийн дэлгэрэнгүй удирдамжийг тусгасан. Мөн сайн дурын карбон зах зээлд оролцох үйл ажиллагааг үндэсний нэгдсэн тооцоолол, бүртгэлийн тогтолцооны хүрээнд зохицуулсан нь онцлогтой юм. Энэ нь сайн дурын карбон зах зээл, Article 6-ийн хүрээний ITMO, үндэсний бүртгэл, харгалзах тохируулга болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн (NDC) хэрэгжилтийг нэгтгэсэн нэгдсэн засаглалын тогтолцоо бүрдүүлсэн хөгжиж буй орны анхны жишээнүүдийн нэг болж байна.

Гана улсын туршлага нь хэд хэдэн бодит үр дүнгээр баталгаажиг байна. Тухайлбал, тус улс 2022 онд Швейцар улстай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн (ITMO)-г шилжүүлэхтэй холбоотой анхны албан ёсны “Зөвшөөрлийн захидал” (Letter of Authorization)-ыг олгосон дэлхийн анхны улс болсон. Энэ нь Парисын хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлийн хэрэгжилтийг бодит хэлцлийн түвшинд хэрэгжүүлсэн олон улсын анхны жишээний нэг болсон гэж үздэг. Мөн сайн дурын нүүрстөрөгчийн зах зээл дээр нэг тонн нүүрстөрөгчийн кредитийн үнэ дунджаар 5–10 ам.долларын түвшинд байсан бол Гана улс Швейцартай байгуулсан Article 6.2-ын хүрээний хэлцлээр нэг тонн ITMO-г ойролцоогоор 25–30 ам.долларын үнээр арилжаалах нөхцөлд хүрсэн нь олон улсын шаардлага хангасан, өндөр чанартай сааруулалтын үр дүн нь илүү өндөр үнэ цэнтэй болохыг харуулсан байна. Одоогийн байдлаар Гана улс Швейцар, Швед, Сингапур, БНСУ зэрэг улстай Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулж, сэргээгдэх эрчим хүч, цэвэр хоол хийх технологи, хөдөө аж ахуй, эрчим хүчний үр ашиг зэрэг салбарт 20 гаруй томоохон төсөл хэрэгжүүлж байна.

Гана улсын зохицуулалтын хамгийн онцлог тал нь уур амьсгалын өөрчлөлтийн бие даасан суурь хууль бүрэн батлагдахыг хүлээлгүйгээр техникийн удирдамж, журам, зөвшөөрлийн тогтолцоонд тулгуурлан карбон зах зээлийн ажиллагааг үе шаттайгаар эхлүүлсэн явдал юм. Судлаачид үүнийг “хосолмол зохицуулалтын загвар” гэж үздэг бөгөөд энэ нь сайн дурын нүүрстөрөгчийн зах зээл болон Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээний механизмыг зэрэгцүүлэн хөгжүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Гана улсын зохицуулалтын тогтолцооны гол онцлог нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгчдэд эхний шатанд “Татгалзах зүйлгүй тухай бичиг” (Letter of No Objection) олгож, тухайн төсөл үндэсний бодлого, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (NDC)-тэй зөрчилдөхгүй болохыг баталгаажуулдаг. Харин төсөл олон улсад шилжүүлэх сааруулалтын үр дүн бий болгох түвшинд хүрсэн тохиолдолд “Албан ёсны зөвшөөрөл” (Letter of Authorization) олгодог шат дараалсан тогтолцоог нэвтрүүлсэн. Энэ нь хөрөнгө оруулагчдад эрх зүйн тодорхой байдал бий болгож, төслийн эрсдэлийг бууруулах чухал нөхцөл болж байна.
- Сайн дурын нүүрстөрөгчийн зах зээл болон Article 6-ийн хүрээнд ашиглах сааруулалтын үр дүнг ялгамжтайгаар зохицуулдаг. Өөрөөр хэлбэл бүх карбон кредитийг ITMO болгон зөвшөөрдөггүй бөгөөд үндэсний зорилтоо хамгаалах үүднээс тодорхой хувийг дотоодын хэрэгцээнд нөөцөлж, зөвхөн илүүдэл хэсгийг олон улсад шилжүүлэх бодлого баримталдаг байна. Зарим тохиолдолд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хангах үүднээс сааруулалтын үр дүнгийн 15–20 орчим хувийг үндэсний хэрэгцээнд үлдээх механизмыг ашиглаж байгаа нь үндэсний ашиг сонирхол болон олон улсын худалдааны тэнцвэрийг хангах зорилготой юм.
- Гана улс ITMO болгон зөвшөөрсөн нэгж бүрт “Харгалзах тохируулга” (Corresponding Adjustment) хийдэг бөгөөд энэ нь нэг сааруулалтын үр дүнг хоёр улс давхар тооцох эрсдэлээс сэргийлэх Парисын хэлэлцээрийн суурь шаардлагыг хэрэгжүүлж буй хэлбэр юм.
- Карбон төслийг зөвхөн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан хэмжээгээр бус, орон нутагт үзүүлэх нийгэм, эдийн засгийн үр өгөөжөөр хамтад нь үнэлдэг тогтолцоотой. Тухайлбал, тухайн төсөл ажлын байр бий болгосон эсэх, орон нутгийн иргэдийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлсэн эсэх, тогтвортой хөгжлийн зорилтод хувь нэмэр оруулсан эсэхийг үнэлгээний шалгуурт оруулдаг.
- Байгаль орчныг хамгаалах агентлаг (Environmental Protection Agency – EPA) нь Article 6 болон карбон зах зээлийн асуудлаарх үндсэн техникийн байгууллагын үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд төслийн үнэлгээ, зөвшөөрөл, MRV тогтолцоо, үндэсний бүртгэл, олон улсын тайлагнал, харгалзах тохируулгын тооцоолол зэрэг үндсэн чиг үүргийг хариуцдаг.

Гана улсын туршлагаас Монгол Улсын хувьд хэд хэдэн чухал сургамж, сайн жишгийг авч үзэх боломжтой байна. Тухайлбал, сайн дурын карбон зах зээл болон Article 6-ийн хүрээний ITMO-г ялгамжтайгаар зохицуулах, зөвшөөрлийг үе шаттайгаар олгох, үндэсний хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын тогтолцоо болон техникийн бүртгэлийн системийг эртнээс хөгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих уян хатан зохицуулалт бий болгох, тогтвортой хөгжлийн үр өгөөжийг карбон төслийн шалгуурт тусгах зэрэг нь Монгол Улсад ашиглах боломжтой туршлага юм.

Ялангуяа Монгол Улс олон улсад карбон кредит экспортлох тохиолдолд үндэсний хэмжээнд хүлээсэн ялгарлын бууралтын зорилтоо алдагдуулахгүй байх асуудал чухал бөгөөд Гана улсын адил ITMO шилжүүлэхдээ харгалзах тохируулгын тооцоолол, үндэсний зорилтын хамгаалалт, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийг хууль, журмын түвшинд нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Энэ утгаараа Гана улсын туршлага нь хөгжиж буй орнууд Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хүрээнд хэрхэн үе шаттай, уян хатан боловч олон улсын шаардлагад нийцсэн карбон зах зээлийн тогтолцоог бүрдүүлж болохыг харуулсан чухал жишээ болж байна.

## **6.6. Кени улс**

Кени улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь хуулийг Африк тивээс анхлан баталсан орон<sup>28</sup>. Анхлан уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг 1990-ээд оноос эхлэн цогц байдлаар шийдэх тал дээр нэлээд амжилт гаргасан. Хэдий тийм боловч Кени улс уур амьсгалын өөрчлөлтийг салбарын хуулиуд болон олон тооны бодлого, хөтөлбөрөөр дамжуулан шийддэг байсан. Байгаль орчны бодлогын баримт бичиг нь 1999 онд баталсан Байгаль орчны менежментийн зохицуулалтын тухай хууль (Environmental Management Coordination Act)-д тулгуурлаж байсан ч уур амьсгалын өөрчлөлтийн тухайлсан суурь хууль гаргах шаардлагатай тулгарчээ. 2010 онд Кенийн засгийн газар Уур амьсгалын өөрчлөлтийн албаны тухай хууль (Climate Change Authority Bill)-ийг парламентаар батлуулсан боловч тус улсын ерөнхийлөгч нь хориг тавьсан. Тус улс 2015 онд Парисын хэлэлцээрт нэгдсэнээр 2016 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухайн хууль (Climate Change Act) баталсан. Энэхүү хууль батлагдсанаар Кени улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрийг нутагшуулах талаар тодорхой алхам хийсэн үндэстнүүдийн лигт нэгдэв.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухайн хууль (Climate Change Act)<sup>29</sup> Кени улсын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль нь дараах гол онцлог санаа, зохицуулалттай. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн зорилго нь “Кени улсын тогтвортой хөгжлийг хангахын тулд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээг сайжруулах зохицуулалтын тогтолцоог бүрдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулах, нүүрстөрөгч багатай хөгжлийг дэмжих механизмыг боловсруулах, удирдах, хэрэгжүүлэх, зохицуулах явдал юм.”
- Хуульд 3 том зорилт тусгасан. Зорилт 1 нь Кени улсыг тогтвортой хөгжүүлэхэд уур амьсгалын өөрчлөлтөд уян хатан байх болон нүүрстөрөгч багатай хөгжлийг дэмжих тогтолцооны хөгжүүлэлт, удирдлага, хэрэгжүүлэлт, зохицуулалтад энэ хууль үйлчилнэ. Зорилт 2 нь хуулийг эдийн засгийн бүх салбарт хэрэглэхээр заасан бөгөөд хуулийг хэрэгжүүлэхэд тухайн салбарууд ямар арга хэмжээ авч ажиллахыг нарийвчлан оруулсан. Зорилт 3-т зааснаар энэхүү хуулийн хүрээнд олгосон эрх, үүрэг нь бусад хуулиар олгосон эрх, үүрэг дээр нэмэгдэнэ.
- Хуульд шинэлэг байдлаар орсон зохицуулалт нь Чиглүүлэх жишиг болон зарчмууд (Guiding values and principles) юм. Энэ зохицуулалтаар бүх төвшний төрийн байгууллагууд хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх, тайлбарлах, уур амьсгалын хүрээнд бодлогын шийдвэр гаргах зэрэгт бүгдээр хуульд оруулсан ёс зүйн болоод бусад хэм хэмжээг (үндсэн хуулийг сахих, шударга байдал болон ил тод, оролцоог хангах г.м) баримтлахаар заасан.
- Хуулиар Кени улсын ерөнхийлөгч нь даргалах Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл (Climate Change Council)-ийг байгуулсан нь хамгийн том эрх бүхий байгууллага юм. Зөвлөлийн дэд дарга нь тус улсын дэд ерөнхийлөгч, нарийн бичиг нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан сайд, бусад гишүүдийн зарим нь засгийн газрын гишүүд (сангийн яам, эдийн засгийн яам, эрчим хүчний яам, байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам) мөн тодорхой хэсэг нь хувийн хэвшил, иргэний нийгэм, шинжлэх ухааны салбарын төлөөллүүд байхаар хуульчилсан. Засгийн газрын бус төлөөллүүдэд тавих тодорхой шалгууруудыг хуульд оруулсан. Зөвлөл нь уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний зохицуулалтын механизмыг бүрдүүлж дараах үүргийг хангаж ажиллана. Үүнд:
  1. үндэсний болон орон нутгийн засгийн газруудын хариуцах уур амьсгалын өөрчлөлтийн чиг үүргийг хангах;
  2. үндэсний уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

<sup>28</sup> Legislating the Paris Agreement in Africa, Constance Dlamini and others, European Capacity Building Initiative, March 2021

<sup>29</sup> Climate Change Act, The Republic of Kenya, No. 11 of 2016

3. уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах болон нүүрстөрөгч багатай уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжилд хүрэхэд шаардлагатай бусад арга хэмжээнүүд, хууль тогтоох, бодлого боловсруулах зэрэгт үндэсний болон орон нутгийн засгийн газруудад зөвлөх;
  4. хүйсийн болон үе хоорондын талаарх нийтийн боловсролын стратеги, хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах;
  5. үндэсний болон орон нутгийн засгийн газар, олон нийт, бусад сонирхогч талуудтай холбоотой уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийг нэгтгэх, түгээх зэргийг хамруулсан уур амьсгалын өөрчлөлтийн талаарх судалгаа, сургалтад бодлогын чиглэл өгөх;
  6. энэ хуулийн зорилтод хүрэхийн тулд салбарын хууль тогтоомжууд, бодлогыг хянан үзэх, өөрчлөх, уялдуулах талаар зааварчилгаа өгөх;
  7. энэ хуулийн дагуу байгуулагдсан Уур амьсгалын өөрчлөлтийн санг удирдах;
  8. хүлэмжийн хийн ялгарлыг зохицуулах зорилтуудыг тогтоох.
- Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдын эрх хэмжээ, үүргийг хуульд дараах байдлаар тусгасан. Үүнд:
    1. уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, стратеги болон Уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг (National Climate Change Action Plan) боловсруулж, батлуулахаар Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөлд хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг нь тодорхой хугацаанд хянах;
    2. уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлаарх олон улсын хэлэлцээрийг засгийн газрын гадаад харилцааны асуудал эрхэлсэн сайдтай зөвлөлдөж удирдан зохицуулах;
    3. хүйсийн болон үе хоорондын хариуцлагын талаарх нийтийн боловсрол, уур амьсгалын өөрчлөлтийн стратеги, хэрэгжүүлэх хөтөлбөрийг батлах;
    4. Уур амьсгалын өөрчлөлтийн захиргаа (Climate Change Directorate)-аар дамжуулан уур амьсгалын өөрчлөлт, хариу арга хэмжээний асуудлаар орон нутгийн засаг захиргаанд харилцан тохиролцоо, хэрэгцээнд үндэслэн техникийн туслалцаа үзүүлэх;
    5. уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах, нүүрстөрөгч багатай, уур амьсгалд уян хатан хөгжлийн чиглэлд дэвшил гаргах талаарх олон улсын болон үндэсний үүрэг амлалтын хэрэгжилтийн талаар жилд хоёр удаа парламентад тайлагнах.
  - Хуулиар уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар ажиллах мэргэжлийн баг бүхий Уур амьсгалын өөрчлөлтийн захиргаа (Climate Change Directorate) байгуулсан. Захиргаа нь Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл болон Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдад зөвлөмж, мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. Мөн Зөвлөлийн өмнөөс энэхүү хуульд заасан зарим үүргүүдийг гүйцэтгэнэ. Захиргаа нь бүтцийн хувьд Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа байгууллага боловч удирдлагыг нь Төрийн/нийтийн албаны хороо (Public Service Commission) томилно. Захиргаа нь ажлын үр дүнгээ Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдад тайлагнана.
  - Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд төрийн болоод хувийн хэвшлийн хүлээх үүргийг тус бүрд нь заалтууд болгон оруулсан. Зөвлөл нь болон Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайдын санал болгосноор төрийн хамааралтай байгууллагад уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр үүрэг өгдөг. Ийм үүрэг авсан байгууллагууд нь энэ хуулийн дагуу ажиллана.
  - Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд явагдаж байгаа бүх үйл ажиллагааг хянах байгууллага нь Байгаль орчны менежментийн үндэсний алба (National Environmental Management Authority) гэж хуулиар тодорхойлсон. Энэ байгууллага нь 1999 онд батлагдсан Байгаль орчны менежментийн зохицуулалтын тухай хуулийн дагуу бий болсон бүтэц. Энэ албанаас хяналт хийх болон бусад ажилд нь саад учруулсан, тухайн газар нутагт нэвтрүүлээгүй, оруулаагүй, шаардсан мэдээ, мэдээлэл өгөөгүй, худлаа эсвэл төөрөгдүүлэх мэдээлэл өгсөн иргэд мөнгөн торгууль төлөхөөс гадна 5 хүртэл жилээр шоронд суух ялаар шийтгүүлнэ.

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн 23-р хэсэгт зааснаар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, дасан зохицох үйл ажиллагааны эсрэг үйлдэл хийсэн гэж үзвэл тухайн хүнийг өөр хэн нэгэн нь Байгаль, газрын шүүх (Environment and Land Court)-д өгөх эрхтэй. Шүүхийн шийдвэр нь эдгээр үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх эсвэл уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зөрчлийн хохирогчдод нөхөн төлбөр олгох зэргийг хамардаг.
- Уур амьсгалын өөрчлөлтийн сан (Climate Change Fund)-г хуулийн дагуу байгуулсан бөгөөд Сан нь Зөвлөлөөс баталсан уур амьсгалын өөрчлөлтийн тэргүүлэх арга хэмжээ, хөндлөнгийн оролцоог санхүүжүүлэх механизм байхаар хуульчилсан. Сангийн санхүүжилтийн эх үүсвэрт парламентаас баталсан бусад хуулийн дагуу нэгдсэн сангаас олгох хөрөнгө, хандив, хишиг, тусламж, бэлэг, мөн санд төлөх энэхүү хуулийн дагуу хуваарилсан мөнгө орно. Мөн тус сан нь Кени улс руу болон дотоодоос орох уур амьсгалын санхүүжилтийн урсгалыг хянана. Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл нь сангийн удирдлагыг хэрэгжүүлнэ.
- Хуульд уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулсан хүмүүст Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны сайд нь Сангийн сайдтай зөвшилцсөний үндсэн дээр дэмжлэг үзүүлэхээр заасан.
  1. хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах зэрэг уур амьсгалын өөрчлөлтийг арилгах арга хэмжээг дэмжиж хэрэгжүүлсэн;
  2. цаг агаарын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсан;
  3. уур амьсгалын өөрчлөлтийг арилгахад чиглэсэн хөтөлбөрүүдэд магадлан итгэмжлэгдсэн сургалт явуулахад оролцсон;
 Кени улсын уур амьсгалын хуулийн дүгнэлт:  
 Кени улсын Уур амьсгалын тухай хууль нь олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх явдлыг дан ганц зорилго болгоогүй. Парисын хэлэлцээр болон Киотогийн протоколын талаар хуульд огт дурдаагүй харин олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалт гэсэн нийтлэг томъёолол оруулсан.

Хууль нь шинэлэг зохицуулалтууд нэлээд оруулсан. Тухайлахад, хүний үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл энэ хүнийг өөр хүмүүс шүүхэд өгөх эрхтэй. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд хуульд заасан эерэг үйл ажиллагаа явуулсан иргэдэд тусламж, дэмжлэг өгч урамшуулна. Хувь хүн Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл (Climate Change Council) болон Уур амьсгалын өөрчлөлтийн захиргаа (Climate Change Directorate)-д өргөдөл гаргаж мэдээлэл хүсэх эрхтэй. Хуулийг хэрэгжүүлэх нийтлэг ёс зүйн зарчмыг Чиглүүлэх жишиг болон зарчмуудаар тогтоосон.

Хуулийн хэрэгжилтийг хянах, нийцүүлэх үйл ажиллагааг 1999 онд байгуулагдсан Байгаль орчны менежментийн үндэсний алба (National Environmental Management Authority) хэрэгжүүлнэ. Энэ нь шинэ хуулийн хэрэгжилтийг хянуулахаар өмнөх бүтцийг ашиглахаар зохицуулсан нь шинэ байгууллага, бүтэц бий болгохоос сэргийлсэн алхам болсон байх талтай.

Кени улсын хувьд 17 жилийн туршид дотооддоо уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хууль гаргах оролдлого хийсний эцэст 2016 онд Африк тивд анхны уур амьсгалын өөрчлөлтийн бие даасан хууль гаргасан. Хэдийн тийм боловч энэ хууль одоо болтол бүрэн хэмжээгээр бүрэн хэмжээгээр мөрдөгдөж эхлээгүй байгаа. Гол шалтгаан нь дотоодын улс төр түүнтэй холбоотой маргаан, улс төрчдийн сонирхол, байр суурийн ялгаанаас үүдэн хуулийн хэрэгжилтийн гол цөм болсон Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл бүрдэхгүй байгаа. Мөн авлига болон улс төрчдийн

нүүрсний орд газраас олох ашиг<sup>30</sup> олох сонирхол энэ хуулийг хэрэгжүүлэхэд гол саад болж байна.

## 6.7. Филиппин улс

Уур амьсгалын өөрчлөлтийн тухайн хууль (Climate Change Act of 2009) Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох тал дээр Филиппин улс хууль эрх зүйн зохицуулалтын уламжлал сайтай бөгөөд энэ чиглэлд бүр 90-ээд оны үеэс эхлэн тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлж эхэлсэн<sup>31</sup>. Улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн хуулиудаас Филиппиний хууль дээгүүр үнэлэгддэг<sup>32</sup>.

Хууль нь дараах гол онцлог санаа, зохицуулалттай. Үүнд:

- Хуулийн зорилго нь “Байгалийн хэмнэл, зохицолд нийцсэн эрүүл экологид байх ард нийтийн эрхийг бүрэн хамгаалж, сайжруулах нь төрийн бодлого юм. Энэ үүднээс тус улс хүний хэрэгцээг хангахын зэрэгцээ одоогийн болон ирээдүй хойч үеийнхний байгаль орчны чанарыг хадгалахын тулд тогтвортой хөгжлийг дэмжсэн Филиппиний хөтөлбөр 21-ийг баталсан”. Ингэж тунхагласны дараагаар НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцод нэгдэн орсон улсын хувьд хүлээх үүргийн хүрээнд хийх ажлуудаа томъёолсон байна.
- Хууль нь уур амьсгалын өөрчлөлтийг бүх шийдвэр гаргах бүх түвшинд үүний дотор гамшгийн эрсдэлийг бууруулах, хөгжлийн төлөвлөлт, ядуурлыг бууруулах зэргийг хамруулсан гэж үздэг. Уур амьсгалын өөрчлөлтийн үзэл санааг төрөөс боловсруулах бодлого, хөгжлийн төлөвлөгөө, ядуурлыг бууруулах стратегийн төрөл бүрийн төвшинд холбож уялдуулахаар заасан.
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль нь уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын үндсэн зарчмууд<sup>33</sup> болох (1) урьдчилан сэргийлэх зарчим, (2) нийтлэг боловч ялгаатай үүрэг хариуцлагууд, (3) гамшгийн эрсдэлийг бууруулах Хьюгогийн<sup>34</sup> үйл ажиллагааны хүрээ, (4) “агаар мандалд хүлэмжийн хийн агууламжийг тодорхой хэмжээнд тогтворжуулж уур амьсгалын системд хүний оролцоотой хөндлөнгийн нөлөөлөл осолтой төвшинд очихоос сэргийлэх” НҮБ-ын зорилт зэргийг агуулсан.
- Хуулийн зорилгод (1) орон нутгийн удирдлагын оролцоог нэмэгдүүлэх, бие даасан шийд гаргах эрх өгөх, (2) ядуу иргэд, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, гамшгаас хамгаалах, (3) уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс сэргийлэх, бууруулах үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагууд, бизнесийн байгууллагуудыг татан оролцуулах зэрэг олон шинэлэг санааг оруулсан.
- Хуулийн зорилтод хүрэх үр дүнг ямар нэгэн хэмжих нэгж ашиглан хугацаа зааж оруулаагүй.
- Хуулиар Филиппин улсын Ерөнхийлөгч даргалдаг, яамдын сайд нар, хот болон орон нутгийн төлөөлөл, бизнесийн төлөөлөл, академик байгууллагуудын төлөөлөл, төрийн бус

<sup>30</sup> Climate governance series Kenya, Climate governance, Climate Analytics, New Climate Institute, December 2020

<sup>31</sup> Climate change, coming soon to a court near you, National climate change legal frameworks in Asia and the Pacific, December 2020, ADB

<sup>32</sup> Is the Philippines’ climate law the best in the world?, Tierney Smith, May 05, 2012, <https://www.climatechangenews.com/2012/05/05/is-the-philippines-climate-law-the-best-in-the-world/>

<sup>33</sup> United Nations Framework Convention on Climate Change, New York, 9 May 1992, United Nations

Treaty Series, Vol. 1,771, No. 30822. Art. 2.

<sup>34</sup> Hyogo Framework for Action

байгууллагын төлөөлөл оролцсон Уур амьсгалын өөрчлөлтийн комисс (Climate Change Commission) байгуулсан. Комисс нь уур амьсгалын өөрчлөлтийн бодлогыг удирдан чиглүүлэхээс гадна (а) Үндэсний уур амьсгалын өөрчлөлтийн үндсэн стратеги (National Framework strategy on climate change), (б) Үндэсний уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө (National Climate Change Action Plan) боловсруулах мөн (в) орон нутгийн удирдлагуудад өөрсдийн төлөвлөгөөг боловсруулахад нь заавар, чиглэл өгөх үүрэгтэй. Мөн хуулиар заасны дагуу үндэсний хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхээс эхлэн энэ төрлийн үйл ажиллагаанд төсөв, санхүүжилт олгох, орон нутагт олон талын туслалцаа үзүүлэх, олон улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр Филиппин улсын эрх ашгийг Гадаад явдлын яамны удирдлагын дагуу төлөөлөх, орон нутаг болон бизнесийн байгууллагуудыг холбож чиглүүлэх зэрэг өргөн хүрээний эрх мэдэл, үүрэгтэй.

- Хуулиар мөн Уур амьсгалын өөрчлөлтийн алба (Climate Change Office)-ыг байгуулж нь гүйцэтгэх захирал нь Комиссын дэд дарга байхаар заасан. Энэ алба нь Уур амьсгалын өөрчлөлтийн комиссын шууд удирдлагад ажиллах бөгөөд Комиссоос уг албаны орон тоо, албан тушаалуудыг хуулийг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд тохируулан бүрдүүлнэ. Гүйцэтгэх захирал албан тушаалтнууд болон ажиллагсдыг сонгодог.
- Хуулийн дагуу орон нутгийн засаг захиргаа нь Үндэсний стратеги болон Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан Орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ёстой. Энэ нь орон нутагт томоохон эрх мэдэл өгч байгаа хэрэг бөгөөд тухайн орон нутаг өөрийн байгаль цаг уурын онцлог, нөхцөлд тохируулан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, гамшгаас сэргийлэх бололцоо олгосон.
- Комисс хуулийн дагуу уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн чиглэлээр мэргэшсэн Мэргэжилтнүүдийн баг (Panel of Technical Experts)-ийг байгуулах бөгөөд шалгуур болон орон тоог мөн Комисс тогтооно. Энэхүү Мэргэжилтнүүдийн баг уур амьсгалын өөрчлөлтийн болзошгүй нөлөөнд өртөмтгий хүн амын суурьшлын дасан зохицох чадавхыг сайжруулах, эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор уур амьсгалын шинжлэх ухаан, технологийн ололт, шилдэг туршлагын талаар Комисст техникийн зөвлөгөө өгнө.
- Хуульд мөн уур амьсгалын өөрчлөлтийн стратеги болон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд засгийн газрын бүрэлдэхүүн болсон яамд, төрийн өмчийн санхүүгийн байгууллагууд, төрийн мэдээллийн агентлаг ямар үүрэг гүйцэтгэхийг заасан.
- Засгийн газрын бүрэлдэхүүний агентлагууд, орон нутгийн удирдлагын төвүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулан өөрийн төсвөөс хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгийг өөрийн санд бүрдүүлэх үүрэгтэй.
- Хуулийн хэрэгжилтийг хянах зорилгоор сенатын 5 гишүүн, 5 төлөөлөл бүхий Конгрессын хяналтын хамтарсан хороог (Joint Congressional Oversight Committee) энэхүү хуулийн дагуу байгуулсан.

Филиппин улсын уур амьсгалын хуулийн дүгнэлт:

- 2015 оны Парисын хэлэлцээрийн дараа хуулиа шинэчлээгүй ер нь 2009 онд анхлан баталснаас хойш хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулаагүй. Олон улсын хэмжээнд хийсэн гэрээ хэлцэл, амлалтуудыг хуулийн гол зорилго болгоогүй харин Филиппин улсын эрх ашиг, иргэдийн амьжиргаа, нийгмийн тулгамдсан асуудлуудыг уур амьсгалын өөрчлөлтийн үед орхигдуулахгүйгээр шийдвэрлэхийг зорилго болгосон.
- Хуулиар шинэ бүтэц, алба, тогтолцоо байгуулаад тэдгээрийн үйл ажиллагаа, дотоод зохион байгуулалт, ажиллах процессын талаар хуульд оруулаагүй харин тухайлсан журмаар зохицуулахаар хуульчилсан. Энэ нь уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд гарч болох олон тооны тодорхойгүй нөхцөл байдалд нийцүүлэн тухайн бүр журмаа өөрчлөн (хууль өөрчлөхгүйгээр) асуудлыг шийдвэрлэдэг байх бололцоог хуулиар байгуулагдсан бүтэц, албанд олгосон гэж үзэж байна. Тухайлахад, Уур амьсгалын өөрчлөлтийн комисс хуулийн

дагуу Мэргэжилтнүүдийн багийг байгуулах бөгөөд шалгуур болон орон тоог мөн Комисс тогтоох эрхтэй. Энэ нь илүү уян хатан тогтолцоо бий болгох талтай, жишээ нь үерийн давтамж ихэссэн үед Комисс илүүтэйгээр энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг Мэргэжилтнүүдийн багт авах бөгөөд үерийн аюул өнгөрөх үед орон тоог нь багасгах бололцоо олгоно.

- Орон нутагтаа эрх мэдэл давуу олгосон нь Филиппиний өөрийнх нь газар нутгийн онцлогтой холбоотой. Энэ улс 7600 гаруй арлаас бүрддэг тул уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн үед төв засгийн газраас тухайн аралд хүрэх бололцоо муу, арал болгон нь өөрийн тогтоц, онцлогтой учраас нэгдсэн төлөвлөгөөг орон нутагт зориулан гаргах бололцоогүй нь гол шалтгаан болсон байх талтай.
- Филиппиний уур амьсгалын хууль нь анхнаасаа тухайн улсын өмнө тулгарч ирсэн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшигтай тэмцэх, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, урьдчилсан сэргийлэх зэрэг хэрэгцээ шаардлагыг хангах зорилготой гарсан. Өнөөг хүртэл энэ хандлагаа өөрчлөөгүй нь тухайн улсын өмнө тулгарсан үндэсний хэмжээний эрх ашгийг урьтал болгосон нь харагдаж байна.
- Засгийн газрын яамд, харьяа агентлагууд уур амьсгалын өөрчлөлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хэрхэн ажиллах, дэмжих мөн энэ ажилд зориулан жилийн төсвөөсөө сан бүрдүүлэхийг нь хуульчилсан нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд хийгдэх үйл ажиллагаа амжилттай хэрэгжих гол нөхцөлүүдийг хуулийн хүрээнд бүрдүүлсэн байна.
- Энэ улс байнга шахам байгаль цаг уурын гамшигт өртдөг, олон тооны арлаас бүрддэг, мөн иргэний (civil), нийтийн (common), лалын (Islamic), орон нутгийн (Indigenous) хуулиуд зэрэгцэн оршдог учраас уур амьсгалын хуулийг маш олон хүрээг хамарсан хирнээ цомхон, мөн эрх мэдлийг нэг газарт төвлөрүүлээгүй харин тухайн хэсгүүдэд нь эрх мэдлийг шилжүүлэх зарчим баримталжээ.
- Хуулийн хэрэгжилтийг хянах зорилго бүхий Конгрессын хяналтын хамтарсан хороо нь Комиссоос тусдаа байгууллага бөгөөд Комиссын гишүүдээс орохгүй. Хамгийн том эрх мэдэл бүхий байгууллагад хөндлөнгийн хяналтын эрхийг олгосон нь зөв шийдэл болсон байна.

## **ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ЮУ ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА ВЭ?:**

Олон улсын хэмжээнд Их Британи улс 2008 онд Уур амьсгалын хууль баталсан нь энэ чиглэлд гарсан анхны суурь хууль болсон юм. Улс орнууд 2015 оны Парисын гэрээгээр улс орнууд УТХН-ийн амлалт авснаас хойш уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд тухайлсан суурь хууль гаргах явдал хурдсаж Их Британи улсын анхлан гаргасан хуулийн зарчмууд дээр түшиглэн одоогоор Европоос 16, Америк тивээс 8 орон, Ази тивээс 10, Африк тивээс 1 орон уур амьсгалын өөрчлөлтийн суурь хууль батлаад байна. Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд тухайлсан суурь хууль гаргадаг одоогийн хандлагаас өмнө улс орнууд ой, ус, агаар, хүрээлэн байгаа орчин, газар зэрэг салбарын хуулиуд мөн эрчим хүчний хуулиараа дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийддэг практиктай байсан. Уур амьсгалын өөрчлөлтийн гол баримт бичиг нь энэ чиглэлд зориулж голдуу Засгийн газрын төвшинд баталсан үндэсний стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө байсан нь нийтлэг хандлага гэж үзэж болох юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн суурь хуультай байх нь хуульгүй байснаасаа илүүтэй гэсэн нотолгоо бүхий судалгаа одоогоор хийгдээгүй нь дараах шалтгаануудтай холбоотой гэж үзэж байна. Үүнд:

- 1) уур амьсгалын өөрчлөлтийн суурь хууль 2015 оноос хойш бий болсон хандлага;
- 2) хууль баталсан ихэнх орнууд хуулийн хэрэгжилтийг эхлүүлээд удаагүй байгаа;

- 3) судлаачдын хэлснээр “эдгээр төрлийн өргөн хүрээтэй, амбицтай, том хүрээг хамарсан эрх зүйн баримт бичгүүдийг тайлбарлах "уур амьсгалын суурь хууль" эсвэл " суурь уур амьсгалын хууль тогтоомж" гэсэн тодорхойлолт хараахан гараагүй байна<sup>35</sup>;
- 4) судалгаа хийх хэмжээний хангалттай дата, мэдээлэл, статистик мэдээ бүрдээгүй.

Хэдий тийм боловч энэхүү тандан судалгааны хүрээнд уур амьсгалын суурь хуультай болон хуульгүй байх үеийн үр дагаврын талаар бусад улсуудын туршлага, уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд хийсэн ажлууд зэргээс үндэслэн дүгнэлт хийлээ.

### **УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙЛСАН СУУРЬ ХУУЛЬГҮЙ БАЙХ:**

- Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр гарсан бодлогын баримт бичгүүд ихэнхдээ Засгийн газрын түвшинд батлагддаг учраас хуулийн хэмжээний хүчин чадал багатай. Хуульчлагдсан бусад үйл ажиллагааны дараа хийгддэг.
- Бодлогын төвшинд гарсан олон тооны баримт бичгүүд нь суурь хуульд үндэслэдэггүй болохоор хэрэгжилт сул, дийлэнх нь хэрэгждэггүй. Хуульгүй ихэнх орнууд ийм туршлагатай байна. Судалгаанд хамрагдсан Йордан улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг хамруулсан 10 гаруй төрлийн бодлогын баримт бичгүүд бий боловч хэрэгжилт нь хангалтгүй байсан нь үүний жишээ болно.
- Суурь хуульгүйн улмаас бодлогын баримт бичигт оруулсан үйл ажиллагаа, төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлэх хуулийн шаардлага байхгүй, хуулийн дагуу албадан хэрэгжүүлэх боломжгүй. Хэрэгжихгүй байх олон тооны эрсдэл үүсдэг. Балба улс уур амьсгалын суурь хуульгүй байх үеийн бодлогын баримт бичигтээ төлөвлөсөн ажлууд нь нэр бүхий 8 эрсдэлээс үүдэн хэрэгжихгүй байх талтайг онцолж дурдсан.
- Суурь хуульгүйн улмаас бодлогын баримт бичигт заасан ажлууд нэн тэргүүний бус, ач холбогдол багатай зардлын зүйлд хамаарч төсвийн хуваарилалтад орох магадлал бага байдаг. Өөрөөр хэлбэл тухайлсан зориулалтын сан, төсөвлөсөн хөрөнгөгүй үлдэж төлөвлөсөн ажлууд санхүүжилтгүй болдог.
- Суурь хуульгүй байхын хамгийн том сул тал нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг дангаар хариуцах үндэсний хэмжээний байгууллага үүсдэггүй. Үүнээс улбаалж энэ асуудал улс төрийн дэмжлэггүй орхигдож бусад салбарын яамд, агентлагууд хэрэгжилтийн явцад оролцдоггүй, дэмждэггүй. Суурь хуульгүй орнуудад голдуу байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцдаг бөгөөд энэ нь эрх мэдлийн хэмжээ талаасаа нөлөөлөл багатай.

### **УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙЛСАН СУУРЬ ХУУЛЬТАЙ БАЙХ:**

- Бодлогын баримт бичгүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн суурь хуульд үндэслэн боловсруулагдана. Засгийн газрын төвшинд боловсруулах хэдий ч хэрэгжилт нь хуулийн шаардлага болох учраас эрх зүйн хүч, нөлөөлөлтэй.
- Уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь энэ чиглэлд хийгдэх зарим ажлуудыг хуулийн зорилго, зорилт болгодог. Ийм байдлаар хуульд хамрагдсан ажлуудын жишээ нь улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн хуульдаа Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ хуулийн зорилго болгосон явдал юм.
- Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд гарах бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, хөтөлбөрүүд хэрэгжих магадлал ихтэй болно.

---

<sup>35</sup> Enacting Framework Legislation on climate Change: Rationale, Trends and Outlook, Michael A. Mehling & James Rawlings, 2019 (unpublished manuscripts)

- Тухайлсан төлөвлөгөөт ажил, үйл ажиллагаа нь санхүүжилтийн эх үүсвэрийг сан болон бусад хуулийн дагуу эх үүсвэрээр бүрдүүлнэ. Дийлэнх улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн сан байгуулахыг хуулиар шийдвэрлэсэн нь хуульчилсан санхүүжилтийн эх үүсвэр ямар чухал байсныг харуулж байна.
- Суурь хууль нь уур амьсгалын өөрчлөлтийг хариуцах хамгийн том эрх мэдэл бүхий байгууллага үүсгэж улс төрийн манлайлал, дэмжлэг бий болно. Судалгаанд хамрагдсан орнууд шинээр баталсан уур амьсгалын өөрчлөлтийн хуульдаа үндэсний хэмжээний эрх мэдэлтэй байгууллагыг уур амьсгалын өөрчлөлт хариуцсан хороо, комисс, зөвлөл нэрийн дор байгуулж ерөнхий сайд эсвэл ерөнхийлөгч нь даргалахаар хуульчилсан.
- Мөн Экологийн Институт болон Европын Уур Амьсгалын Фондоос<sup>36</sup> хийсэн судалгаагаар дөрвөн төрлийн шалтгаанаар улс орнууд уур амьсгалын хуультай болж байна.
  - 1) Хууль эрх зүйн хэлбэрээр тогтолцоо бий болгох нь өгсөн амлалтаасаа буцаж очиход хэцүү болгодог;
  - 2) Хууль бол чин сэтгэлийн илэрхийлэл мөн. Улс орнууд амлалтаа хуульчилснаар гадны оролцогчдод ч сонсогддог;
  - 3) Уур амьсгалын урт хугацааны зорилтыг хуульд тусгаснаар уур амьсгалын ажлыг илүү чухал, гол болгодог;
  - 4) Уур амьсгалыг нэн тэргүүний зорилт болгох замаар бодлогын чиглэлүүдийн уялдаа холбоог сайжруулдаг. Зөвхөн улс төрийн тунхаглал ийм нөлөө үзүүлэхгүй.

## **ОЛОН УЛС ДАХЬ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

Одоогоор дэлхийн 70 гаруй улс уур амьсгалын өөрчлөлт, карбон зах зээл, ногоон хөгжлийн асуудлыг зохицуулсан тусгайлсан хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлээд байна. Эдгээрээс Европын орнууд уур амьсгалын өөрчлөлтийн эрх зүйн тогтолцоог хамгийн эрт бүрдүүлж эхэлсэн бөгөөд хөгжиж буй орнууд сүүлийн жилүүдэд өөрийн улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөлд нийцүүлэн уур амьсгалын суурь хуулиудыг үе шаттайгаар баталж байна. Судалгаанд хамрагдсан орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан үзэхэд тэдгээрийн зохицуулалтын арга барил, институцийн бүтэц, хуулийн зорилго, хэрэгжилтийн механизм нь тухайн улсын хөгжлийн түвшин, институцийн чадавх, эдийн засгийн бүтэц, олон улсын өмнө хүлээсэн үүрэг болон үндэсний тулгамдсан асуудлаас ихээхэн хамаарч байв. Иймд судалгаанд хамрагдсан улс орнуудыг Европын орнууд болон бусад хөгжиж буй орнууд гэсэн хоёр бүлэгт ангилан авч үзэв.

### 1. Европын орнуудын зохицуулалтын нийтлэг онцлог

Европын орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь ихэвчлэн Парисын хэлэлцээр болон Европын Холбооны уур амьсгалын бодлогын зорилтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсэн хэрэгсэл болж хөгжсөн байна. Их Британи, Герман, Австри зэрэг улсын туршлагыг харьцуулан үзэхэд дараах нийтлэг шинж ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, эдгээр улсын хууль тогтоомж нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн зорилтыг хэрэгжүүлэхийг шууд болон шууд бусаар хуулийн зорилго, төрийн байгууллагын чиг үүрэгт тусгасан байдаг. Европын орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь үндсэндээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах,

<sup>36</sup> Climate laws in Europe -good practice in net zero management, Ana Barreira and others, Ecological Institute, European Climate Foundation, February 2020

нүүрстөрөгч багатай эдийн засагт шилжих бодлоготой шууд холбоотой байдаг бөгөөд ажилгүйдэл, дэд бүтцийн хомсдол, ядуурал зэрэг хөгжиж буй орнуудад нийтлэг тулгардаг асуудлууд харьцангуй бага байдаг нь ийм чиг хандлагад нөлөөлсөн байна.

Хоёрдугаарт, зарим улс Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн (ҮТХН/NDC) зорилтоо тодорхой хугацаа, тоон үзүүлэлттэйгээр шууд хуульчилсан байна. Тухайлбал, Их Британи болон Герман улс хүлэмжийн хийн ялгарлыг 1990 оны түвшинтэй харьцуулахад хэдэн хувь бууруулах зорилтыг тодорхой хугацаатайгаар хуульдаа тусгасан. Ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь бодлогын баримт бичгийн шинжийг давхар агуулсан, урт хугацааны чиглүүлэгч эрх зүйн механизм болж хөгжсөн байна.

Гуравдугаарт, Европын орнууд шинэ том бүтэц, байгууллага олноор байгуулахаас илүү өмнө нь байгаль орчин, эрчим хүч, хог хаягдал, аж үйлдвэр зэрэг салбаруудад ажиллаж байсан байгууллагуудын чиг үүргийг уялдуулан ашиглах хандлагатай байна. Энэ нь институцийн давхардал үүсгэхгүй байх, төсвийн үр ашигтай байдлыг хадгалах, хуулийн хэрэгжилтийг одоо байгаа бүтцээр дамжуулан хангах зорилготой гэж үзэж болно.

Дөрөвдүгээрт, Европын орнуудын зарим нь уур амьсгалын өөрчлөлтийн бодлогын тусгай баримт бичиг боловсруулахын оронд хуулиар тогтоосон зорилтын хэрэгжилтийн тайлан, нүүрстөрөгчийн төсөв, хэрэгжилтийн үнэлгээнд илүү төвлөрдөг байна. Өөрөөр хэлбэл, хууль өөрөө стратегийн шинжтэй тул бодлогын баримт бичгийн үүргийг давхар гүйцэтгэх хандлага ажиглагдаж байна.

## 2. Хөгжиж буй болон бусад орнуудын зохицуулалтын нийтлэг онцлог

Хөгжиж буй болон институцийн шилжилтийн нөхцөлтэй орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь зөвхөн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор хязгаарлагдахгүй, харин эдийн засгийн хөгжил, ядуурал, гамшгийн эрсдэл, дасан зохицох, байгаль орчны доройтол, санхүүжилт, институцийн чадавх зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарсан цогц шинжтэй байх хандлагатай байна. Энэ бүлэгт Гана, Кени, Филиппин, Йордан зэрэг улсын туршлагыг хамруулан судлав.

Нэгдүгээрт, эдгээр улсын хуулиуд Парисын хэлэлцээрийг шууд хэрэгжүүлэхээс илүүтэй “олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг”, “НҮБ-ын суурь конвенцын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа” гэх мэт ерөнхий томъёоллыг ашиглах хандлагатай байна. Учир нь хөгжиж буй орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь ядуурал, ажил эрхлэлт, хүнсний аюулгүй байдал, усны хомсдол, гамшгийн эрсдэл зэрэг дотоод хөгжлийн асуудалтай шууд холбогддог байна.

Хоёрдугаарт, эдгээр улс орнууд Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо ихэвчлэн бодлогын баримт бичиг, үндэсний төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх хандлагатай бөгөөд хуулиар шууд хатуу хугацаа, тоон үзүүлэлт тогтоох нь харьцангуй бага байна. Энэ нь эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн стратеги, улс төрийн өөрчлөлтөөс шалтгаалан зорилтоо уян хатан шинэчлэх шаардлагатай холбоотой гэж үзэж болно.

Гуравдугаарт, хөгжиж буй орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хэрэгжүүлэх шинэ бүтэц, зөвлөл, хороо, комисс, мэргэжлийн нэгж байгуулах шаардлага түгээмэл гарч байна. Тухайлбал, Кени улс Уур амьсгалын өөрчлөлтийн зөвлөл, захиргаа байгуулсан бол Филиппин улс Уур амьсгалын өөрчлөлтийн комисс, мэргэжилтнүүдийн баг

байгуулсан байна. Энэ нь өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг дагнан хэрэгжүүлдэг институцийн тогтолцоо хангалтгүй байсантай холбоотой.

Дөрөвдүгээрт, хөгжиж буй орнуудын ихэнх нь уур амьсгалын сан, тусгай санхүүжилтийн механизм байгуулах зохицуулалтыг хуульдаа тусгасан байна. Учир нь эдгээр улс орнууд өмнө нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр тогтмол төсөв, санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлдэггүй байсан тул шинэ хуулиар дамжуулан олон улсын санхүүжилт татах, дотоод сан бүрдүүлэх эрх зүйн үндсийг бий болгож байна.

Тавдугаарт, хөгжиж буй орнуудын хуулийн хамрах хүрээ илүү өргөн бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг эрчим хүч, хөдөө аж ахуй, ус, гамшиг, орон нутгийн хөгжил, нийгмийн хамгаалал, ядуурал зэрэг олон салбартай уялдуулан зохицуулах шаардлага үүсдэг. Энэ нь тухайн улс орнуудын салбарын хууль тогтоомж уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хангалттай зохицуулаагүй байдалтай холбоотой байна.

Зургаадугаарт, Гана улсын туршлагаас харахад хөгжиж буй орнууд уур амьсгалын өөрчлөлтийн бие даасан суурь хууль батлагдахаас өмнө техникийн журам, удирдамж, зөвшөөрлийн тогтолцоонд тулгуурлан Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл болон карбон зах зээлийн механизмыг хэрэгжүүлж болохыг харуулсан шинэ жишиг тогтож байна. Энэ нь хөгжиж буй орнуудын хувьд уян хатан, үе шаттай зохицуулалтын загвар хэрэгжүүлэх боломжтойг харуулж байна.

Ийнхүү харьцуулсан судалгаанаас үзэхэд Европын орнуудын уур амьсгалын хууль нь гол төлөв ялгарлын бууралтын зорилт, нүүрстөрөгчийн төсөв, тайлагнал, хяналтын тогтолцоонд төвлөрсөн бол хөгжиж буй орнуудын хуулиуд нь институцийн чадавх бүрдүүлэх, дасан зохицох, санхүүжилт, орон нутгийн оролцоо, олон салбарын зохицуулалтыг хамарсан илүү өргөн хүрээний шинжтэй байна. Монгол Улсын хувьд эдгээр хоёр загварын давуу талыг хослуулсан, үндэсний нөхцөл байдалд нийцсэн “хосолмол зохицуулалтын загвар” боловсруулах нь илүү оновчтой гэж үзэхээр байна.

## **УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА:**

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг улс орнууд суурь хуулиар эсвэл бодлогын баримт бичгийн хүрээнд эсвэл эдгээрийн хослол байдлаар зохицуулах гэсэн нийтлэг 3 хэлбэр байна. Үүнээс бодлогын баримт бичгээр зохицуулах хэлбэр нь цаашид халагдах төлөвтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн суурь хууль гарснаар

- (1) тухайн улсын олон улсын хэмжээнд авсан амлалтыг дотооддоо хуульчилдаг;
- (2) хуульчилснаар зорилт тодорхой болж биелэх боломж, магадлал ихэсдэг;
- (3) хууль баталснаар үндэсний хэмжээний эрх мэдэл бүхий байгууллага бий болж хуулийн хэрэгжилт сайжирна;
- (4) тухайлсан төсөв бүхий зориулалтын сан байгуулагдаж санхүүгийн эх үүсвэр нь шийдэгддэг;
- (5) уур амьсгалын асуудлыг дотоодын улс төрийн нөлөөллөөс хамгаалдаг гэсэн нийтлэг дүгнэлт хийж байна.

Цаашид дэлхийн уур амьсгалын өөрчлөлт сөрөг нөлөөлөл их үүсгэхийн хирээр улс орнуудын энэ чиглэлд авч байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны үр дүн хурцаар тавигдана. Энэ хүрээнд хийгдэх ёстой эхний ажил нь уур амьсгалын өөрчлөлтийн суурь хуулийг боловсруулж хууль тогтоох байгууллагаараа батлуулах явдал. Одоогоор уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг улс бүр заавал батлан гаргах үүрэг хүлээгээгүй, ийм шахалт байхгүй боловч олон улсын

хэмжээнд энэ чиглэлд тухайлсан суурь хуультай байх нь илүү гэсэн чиг хандлага давамгайл байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хууль цаашдаа олон улсын хэмжээнд байнга яригдах сэдэв бөгөөд хуулийг хэрэгжүүлэх явдал нь тухайн улсын хувьд дэлхий нийтийн өмнө хүлээсэн үүргүүдийн нэг болох юм.

Хэдийгээр ийм зураглал, төсөөллийн талаар судлаачид гаргаж тавиагүй боловч хөгжингүй орнуудаас буурай болон хөгжиж буй орнуудад үзүүлэх зээл, тусламжийн үндсэн шаардлагад уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд хийж байгаа үйл ажиллагааны үр дүн нэг хэсэг нь болж орох боломжтой. Энэ төсөөллийг цаашид үргэлжлүүлэхэд энэ нь олон улсын хэмжээнд хэлэлцэгдэх Climatepolitic буюу уур амьсгалын бодлого болон хэлбэршиж ч мэдэх юм.

Иймд манай улсын хувьд уур амьсгалын хуулийг боловсруулж батлуулах нь зайлшгүй шаардлага бөгөөд энэ чиглэлд хуультай болсноор дараах давуу талууд бий болж, тодорхой эрсдэлт нөхцөлөөс сэргийлнэ. Үүнд:

- Олон улсын хэмжээнд Монгол улсын хувь нэмэр, амлалт, үүрэг хуульчлагдана;
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал салбарын хуулиудын дунд тарж, шингэх эрсдэл үүсэхгүй;
- Үндэсний хэмжээнд батлах бодлогын баримт бичиг, хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө нь хуульд үндэслэж, хэрэгжих боломж нь нэмэгдэнэ;
- Одоогоор уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд иниституцын тогтолцоо, бүтэц, хөтөлбөр, үйл ажиллагаанууд энэ хуульд суурилна, эрх үүрэг, хоорондын уялдаа нь хуульчлагдана;
- Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд ажиллах байгууллагууд, бүтцүүд бий болж хугацаа алдахгүйгээр үйл ажиллагаагаа эхлүүлнэ, явц дундаа илүү хэлбэршиж хуулийн хүрээнд шаардлагатай тохируулга, засвар, өөрчлөлт хийгдэнэ;
- Олон нийт болон бизнесийн байгууллагуудад энэхүү хуулийн талаар тодорхой ойлголт үүсэж уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд хийгдэх дараагийн алхмуудад шаардлагатай соёл, хандлага сууна;
- Төрийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлэх, хамтран ажиллах зэрэгт суралцаж хэлбэршинэ;
- Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд явуулах үйл ажиллагаанууд сангаар дамжин хэрэгжих санхүүгийн эх үүсвэртэй болно;
- Хууль батлагдсанаар Монгол Улс алдагдал ба гарз хохирол, тэгш хүртээмжтэй шилжилт зэрэг шинээр бий болж буй арга хэрэгслүүдийн бэлтгэл ажлуудыг хийж эхлэх бололцоо бүрдэнэ.

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

### Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх одоогийн эрх зүйн зохицуулалтын анхаарах асуудлууд

Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл дэлхийн дунджаас илүү эрчимтэй илэрч, агаарын температур сүүлийн 85 жилийн хугацаанд 2.58°C-аар нэмэгдсэн, ган, зуд, усны хомсдол, цөлжилт, биологийн олон янз байдлын доройтол, дэд бүтэц болон нийгэм-эдийн засгийн салбарын эрсдэл нэмэгдэж байгаа нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн бодлогын түвшинд авч үзэх шаардлагатайг харуулж байна.

Олон улсын харьцуулсан судалгаа болон Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай бие даасан суурь хууль баталж, төрийн бодлого, олон улсын үүрэг, үндэсний хөгжлийн зорилтыг уялдуулах шаардлагатай. Хууль нь Парисын хэлэлцээр, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН), “Алсын хараа-2050”, тогтвортой хөгжлийн зорилтууд болон ногоон хөгжлийн бодлоготой нэгдмэл байдлаар уялдсан байх нь зүйтэй.
2. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх төрийн байгууллагуудын эрх хэмжээ, чиг үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох шаардлагатай. Ялангуяа Улсын Их Хурал, Засгийн газар, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн байгууллагууд, үндэсний хороо болон мэргэжлийн байгууллагуудын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах нь чухал байна.
3. Салбар дундын уялдаа холбоог хангах институцийн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь эрчим хүч, хөдөө аж ахуй, уул уурхай, тээвэр, барилга, ус, ойн нөөц, эрүүл мэнд зэрэг олон салбарыг хамардаг тул мэдээлэл солилцоо, төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилт, тайлагналын нэгдсэн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.
4. Хүлэмжийн хийн хэмжилт, тайлагнал, баталгаажуулалтын (MRV) үндэсний тогтолцоог хуульчлан бий болгох шаардлагатай. Үүнд хүлэмжийн хийн тооллого, салбарын мэдээллийн нэгдсэн сан, баталгаажуулалтын тогтолцоо, ил тод байдлын тайлагнал, үндэсний бүртгэлийн системийг үе шаттай хөгжүүлэх хэрэгтэй.
5. Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох болон сааруулах бодлогыг тусад нь системтэй зохицуулах шаардлагатай. Монгол Улсын хувьд ган, зуд, цөлжилт, усны хомсдол, бэлчээрийн доройтол, мөсөн голын хайлалт зэрэг эрсдэл өндөр байгаа тул зөвхөн ялгарлыг бууруулах бус, дасан зохицох бодлого эрх зүйн бие даасан зохицуулалттай байх шаардлагатай байна.
6. Уур амьсгалын санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, Уур амьсгалын өөрчлөлтийн сан байгуулах шаардлагатай. Тус сан нь олон улсын санхүүжилт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг татах, дасан зохицох болон сааруулах арга хэмжээг санхүүжүүлэх үндсэн механизм болох нь зүйтэй.
7. Хувийн хэвшил, банк, санхүүгийн байгууллага, иргэний нийгэм, шинжлэх ухааны байгууллагын оролцоог хуульд тодорхой тусгах шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг зөвхөн төрийн чиг үүрэг бус, нийгмийн хамтын оролцоонд тулгуурласан тогтолцоогоор хэрэгжүүлэх шаардлагатай байна.

8. Хуулийн хэрэгжилтэд шинжлэх ухаанд суурилсан, хараат бус хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг бий болгох шаардлагатай. Олон улсын туршлагаас үзэхэд мэргэжлийн зөвлөл, шинжээчдийн баг, эрдэмтэн судлаачдын оролцоотой хяналтын тогтолцоо нь улс төрөөс хараат бус, урт хугацааны бодлогын тогтвортой байдлыг хангахад чухал нөлөө үзүүлдэг байна.
9. Орон нутгийн оролцоо, чадавхыг бэхжүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгах шаардлагатай. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл орон нутагт илүү хүчтэй илэрч байгаа тул аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд төлөвлөлт, дасан зохицох арга хэмжээ, гамшгийн эрсдэлийн удирдлага, байгалийн нөөцийн хамгаалалттай холбоотой чиг үүргийг тодорхой болгох нь зүйтэй.
10. Карбон зах зээл, нүүрстөрөгчийн кредит, олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг үе шаттайгаар бүрдүүлэх шаардлагатай. Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлтэй нийцсэн зохицуулалт, карбон кредитийн өмчлөл, бүртгэл, шилжүүлэг, зөвшөөрөл, харгалзах тохируулгын үндсэн зохицуулалтыг хуульд тусгах нь Монгол Улсад олон улсын карбон зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.

### **Олон улсын харьцуулсан судалгаанд үндэслэн монгол улсын уур амьсгалын өөрчлөлтийн хуулийн төслийн агуулга, бүтцийн талаар:**

Олон улсын харьцуулсан судалгаанаас үзэхэд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх эрх зүйн зохицуулалт нь улс орнуудын хөгжлийн түвшин, төрийн байгуулалтын бүтэц, институцийн чадавх, эдийн засгийн онцлог, олон улсын өмнө хүлээсэн үүрэг болон үндэсний тулгамдсан асуудлаас хамааран харилцан адилгүй хэлбэрээр хөгжиж байна. Гэсэн хэдий ч улс орнуудын нийтлэг хандлага нь уур амьсгалын өөрчлөлтийг зөвхөн байгаль орчны асуудал гэж үзэхээс татгалзаж, харин эдийн засаг, нийгэм, санхүүжилт, хөрөнгө оруулалт, технологи, хүний эрх, орон нутгийн хөгжил, олон улсын хамтын ажиллагаатай шууд холбогдох цогц бодлогын асуудал болгон хуульчилж байгаа явдал юм.

Европын орнуудын туршлагаас харахад уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь ихэвчлэн урт хугацааны хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт, нүүрстөрөгчийн төсөв, салбарын ялгарлын хязгаар, тайлагнал, хяналт-шинжилгээ, хараат бус шинжээчдийн зөвлөл зэрэг механизмаар дамжуулан бодлогын тогтвортой байдал, хариуцлагыг хангахад чиглэж байна. Их Британи, Герман зэрэг улсын жишээ нь хуулиар хэмжих боломжтой зорилт, тодорхой хугацаа, институцийн хяналт, шинжлэх ухаанд суурилсан зөвлөмжийн тогтолцоо бүрдүүлэх нь уур амьсгалын бодлогыг улс төрийн богино хугацааны өөрчлөлтөөс хамгаалах чухал арга болохыг харуулж байна.

Харин хөгжиж буй болон уур амьсгалын эрсдэл өндөртэй орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь зөвхөн ялгарлыг бууруулах зорилгоор хязгаарлагдахгүй, харин дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах, орон нутгийн чадавхыг нэмэгдүүлэх, уур амьсгалын санхүүжилт татах, эмзэг бүлгийг хамгаалах, салбар дундын зохицуулалт бий болгох, шинэ институцийн тогтолцоо бүрдүүлэхэд чиглэсэн өргөн хүрээний шинжтэй байна. Кени, Филиппин, Йордан зэрэг улсын туршлагаас үзэхэд хөгжиж буй орнууд уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг үндэсний хөгжлийн бодлого, ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдал, усны нөөц, орон нутгийн гамшгийн эрсдэлтэй уялдуулан хэрэгжүүлэх хандлагатай байна.

Гана улсын туршлага нь хөгжиж буй орнууд Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл болон карбон зах зээлийн зохицуулалтыг заавал бүрэн хэмжээний шинэ хууль батлагдсаны дараа бус, харин техникийн журам, зөвшөөрлийн тогтолцоо, MRV, үндэсний бүртгэл, харгалзах

тохируулгын механизмыг үе шаттайгаар бий болгох замаар хэрэгжүүлж болохыг харуулж байна. Энэ нь Монгол Улсад карбон зах зээл, ИТМО, сайн дурын карбон зах зээл, үндэсний бүртгэл, MRV болон харгалзах тохируулгын зохицуулалтыг хуулийн суурь түвшинд тусгаж, нарийвчилсан журмаар үе шаттай хэрэгжүүлэх боломжтойг нотолж байна.

Харьцуулсан судалгаанаас мөн уур амьсгалын өөрчлөлтийн хууль нь дангаараа бүх асуудлыг шийдвэрлэхгүй боловч бодлого, институц, санхүүжилт, тайлагнал, оролцоо, хариуцлагын нэгдсэн суурийг бүрдүүлдэг үндсэн эрх зүйн хэрэгсэл болох нь тодорхой байна. Иймд хуульд бүх техникийн нарийвчилсан зохицуулалтыг шууд оруулах бус, харин үндсэн зарчим, институцийн чиг үүрэг, эрх зүйн мандат, хэрэгжүүлэх механизм, тайлагнал, хяналт, санхүүжилт, оролцооны суурийг тодорхой зааж, нарийвчилсан зохицуулалтыг Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагын батлах журам, аргачлалаар хэрэгжүүлэх нь илүү оновчтой байна.

Монгол Улсын хувьд Европын орнуудын хэмжих боломжтой зорилт, хяналт-шинжилгээ, шинжлэх ухаанд суурилсан зөвлөмжийн тогтолцоог хөгжиж буй орнуудын дасан зохицох, санхүүжилт, орон нутгийн оролцоо, эмзэг бүлгийн хамгаалал, институцийн чадавх бүрдүүлэх загвартай хослуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, Монгол Улсад тохирох загвар нь зөвхөн ялгарлыг бууруулахад төвлөрсөн Европын загвар эсхүл зөвхөн дасан зохицох, институц байгуулахад чиглэсэн хөгжиж буй орны загварын аль нэг бус, харин эдгээрийн давуу талыг нэгтгэсэн хосолмол зохицуулалтын загвар байна.

Ийм хосолмол загвар нь дараах үндсэн чиглэлд суурилах нь зүйтэй. Үүнд: хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангах; уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэх; хүлэмжийн хийн тооллого, MRV, ил тод байдлын тайлагналын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх; ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоох; карбон зах зээл, ИТМО, харгалзах тохируулга, үндэсний бүртгэлийн зохицуулалтыг бий болгох; төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, шинжлэх ухааны байгууллага, орон нутгийн оролцоог тодорхойлох; хуулийн хэрэгжилтэд хараат бус, шинжлэх ухаанд суурилсан хяналт-шинжилгээний тогтолцоо бий болгох зэрэг болно.

Дүгнэж үзвэл, Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл нь олон улсын сайн туршлагыг шууд хуулбарлах бус, харин Монгол Улсын газар зүйн байршил, эрс тэс уур амьсгал, мал аж ахуй, бэлчээр, усны нөөц, цөлжилт, гамшгийн эрсдэл, эдийн засгийн бүтэц, институцийн чадавх болон олон улсын үүргийг харгалзан боловсруулагдах шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь нэг талаас Парисын хэлэлцээр, ҮТХН, ил тод байдлын тайлагнал, карбон зах зээл зэрэг олон улсын шаардлагад нийцсэн, нөгөө талаас Монгол Улсын дасан зохицох хэрэгцээ, орон нутгийн эмзэг байдал, санхүүжилтийн хэрэгцээ, ногоон хөгжлийн зорилтыг хангах үндэсний эрх зүйн цогц зохицуулалт байх нь зүйтэй.

Судалгаанаас үзэхэд улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн хуулиуд нь дараах нийтлэг хэв шинжүүдтэй байна.

- Хуулийн зорилт нь:
  - (1) Тухайн улсын тогтвортой хөгжлийг уур амьсгалын өөрчлөлтийн үед хангах, нийгэм эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хадгалах,
  - (2) Олон улсын гэрээ болон Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Зарим улсууд аль нэг дээр нь төвлөрсөн, зарим нь хоёр зорилтыг хамтад нь хуульдаа оруулсан байна.

- Тухайн улс өөрийн хөгжлийн стратеги, нийгэм эдийн засгийн хөгжил, улс орны онцлог, зайлшгүй нөхцөлүүдээ хуульдаа тусгадаг.
- Өмнө нь байгуулсан бүтэц зохион байгуулалт, нэгжүүд, албад, ажил үүргийг уур амьсгалын өөрчлөлтийн хуулиар хумьж, цэгцэд оруулж нэгтгэдэг.
- Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ямар нэгэн мөнгөн дүн бүхий төсөв, төсөвлөсөн санхүүжилтийн хэмжээ хуульдаа оруулаагүй. Шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөсний дагуу тухайн жилийн төсөвтөө тусгахыг хуульчилсан. Хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай уур амьсгалын өөрчлөлтийн санг хуулийн дагуу байгуулдаг.
- Ихэнх орнууд (Европын бус) орнууд хуульдаа ямар нэгэн шинэ татвар, хураамж, төлбөр авах тухай оруулаагүй.
- Хуулийн хэрэгжилтийг хангах баримт бичиг (голдуу стратеги, бодлого, төлөвлөгөө гэсэн нэршилтэй) нь 5 болон түүнээс дээш жилээр төлөвлөгдсөн урт хугацааны төлөвлөгөө байх бөгөөд хуульд нэрээрээ тусаж, ямар хүрээг хамрах, ямар үйл ажиллагаа хийгдэх, тодорхой хугацаанд хүрэх үр дүн нь юу болох нь тусгагдана.
- Хуулиар уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээний эрх мэдэл бүхий байгууллага (хороо, зөвлөл, комисс гэсэн нэршилтэй) байгуулж ерөнхийлөгч, ерөнхий сайд, байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нарын аль нэг нь толгойлдог. Уур амьсгалын өөрчлөлтийн санг энэ байгууллага голлон удирддаг. Энэ бүтэц нь хуулийг хэрэгжүүлэхэд эрх зүйн том хүчин зүйл болохоос гадна улс төрийн нөлөөллийг бууруулдаг талтай.
- Хуулийн хэрэгжилтэд бусад төрийн байгууллагууд ямар үүрэгтэй орохыг нарийвчлан тусгадаг. Өмнө нь дан ганц бодлогын баримт бичгээр уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх оролдлого хийсэн орнууд дээр энэ хандлага түгээмэл ажиглагдаж байна.
- Хяналтын тогтолцоог хөндлөнгийн мэргэжлийн багаар бүрдүүлж хуулийн хэрэгжилтийг хянуулдаг. Мөн олон нийтийн хяналт, ил тод байдлыг хуульдаа тодорхой хэмжээгээр тусгадаг байна.
- Гарах шийдвэрт уур амьсгал, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн чиглэлээр мэргэшсэн эрдэмтэд, судлаачдын дүгнэлтийг хүлээн авч тусгахаар оруулсан. Энэ нь улс төрийн давуу тал олж авах гэсэн ямар нэгэн оролдлого мөн шинжлэх ухаанч бус байр сууриас шийд гаргах эрсдэлийг хаах зорилготой байна.

### **Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтийн хуулийн төслийн агуулга, бүтцийн талаар:**

Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль нь Парисын хэлэлцээр, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц, Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан, үндэсний онцлогт нийцсэн суурь эрх зүйн зохицуулалт байх шаардлагатай.

#### ***Хуулийн төслийн зохицуулалтад тусгах асуудлууд:***

- Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, тэг ялгаралд хүрэх чиглэл, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийн эрх зүйн үндсийг тогтоох;
- НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц, Парисын хэлэлцээр болон бусад олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалт, хамтын ажиллагааны механизм, олон улсын тайлагнал, ил тод байдлын шаардлагыг хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгох;
- Монгол Улсын газар зүйн байршил, эрс тэс уур амьсгал, цөлжилт, бэлчээрийн доройтол, усны нөөцийн хомсдол, мал аж ахуйн онцлог, хүн амын тархалт, нийгэм, эдийн засгийн

бүтэц, уламжлалт ахуй, соёлын онцлогтой уялдсан дасан зохицох болон даван туулах бодлогын суурийг тогтоох;

- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага болон бусад салбарын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын тогтолцоо, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүрэг, харилцан уялдаа, хариуцлагын тогтолцоог тодорхойлох;
- Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, эдийн засгийн шилжилт, ногоон хөгжил, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний зорилттой уялдсан уур амьсгалын бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд өмнө нь эрх зүйн хувьд бүрэн зохицуулагдаагүй асуудлууд болох хүлэмжийн хийн тооллого, хэмжилт, тайлагнал, баталгаажуулалт, ил тод байдлын тайлагнал, карбон зах зээл, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн, харгалзах тохируулга, үндэсний бүртгэл, гарз хохирол, эрсдэлийн үнэлгээ зэрэг асуудлыг зохицуулах;
- Хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч, эрдэм шинжилгээний байгууллага болон иргэдийн оролцоо, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгох;
- Ногоон болон уур амьсгалын санхүүжилтийн тогтолцоо, уур амьсгалын сан, түүний орлого, зарцуулалт, удирдлага, хяналт, ил тод байдлын зохицуулалтыг бий болгох;
- Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийн нэгдсэн сан, өгөгдөл солилцоо, олон нийтийн мэдээлэл авах эрх, ил тод байдал, шинжлэх ухаанд суурилсан бодлого боловсруулах тогтолцоог бүрдүүлэх;
- Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлтэй нийцсэн үндэсний, сайн дурын, хоёр болон олон талт карбон зах зээлийн эрх зүйн үндсийг тогтоож, сааруулалтын үр дүн, карбон кредит, олон улсад шилжүүлэн тооцох сааруулалтын үр дүн (ITMO), зөвшөөрөл, бүртгэл, харгалзах тохируулга болон давхар тооллогоос сэргийлэх тогтолцоог зохицуулах.

#### ***Хуулийн төслийн бүтэц нь дараах хэлбэртэй байна:***

- Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл. Үүнд: Хуулийн зорилго, хамрах хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, Парисын хэлэлцээр, Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт, тэг ялгарал, уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах зарчим, хүний эрх, шударга шилжилтийн суурь зарчмыг тусгана.
- Хоёрдугаар бүлэг: Төрийн байгууллагын бүрэн эрх, засаглалын тогтолцоо. Үүнд: Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний зохицуулагч байгууллага, орон нутгийн байгууллага болон салбар дундын зохицуулалтын бүтэц, чиг үүргийг тодорхойлно.
- Гуравдугаар бүлэг: Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, шинжлэх ухаан, мэдээллийн тогтолцоо. Үүнд: хүлэмжийн хийн үндэсний тооллого, эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, өгөгдөл мэдээлэл, ил тод байдлын тогтолцоог зохицуулна.
- Дөрөвдүгээр бүлэг: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах. Үүнд: үндэсний болон орон нутгийн дасан зохицох төлөвлөгөө, эмзэг бүлэг, салбарын дасан зохицох арга хэмжээ, гарз хохирол, эрсдэлийг бууруулах тогтолцоог тусгана.
- Тавдугаар бүлэг: Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах. Үүнд: УТХН-ийн хэрэгжилт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх бодлого, салбарын зорилт, MRV тогтолцоо болон тайлагналын асуудлыг зохицуулна.
- Зургаадугаар бүлэг: Карбон зах зээл ба Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйл. Үүнд: үндэсний, сайн дурын, хоёр болон олон талт карбон зах зээл, ITMO, харгалзах тохируулга, зөвшөөрлийн тогтолцоо, карбон бүртгэл, давхар тооллогоос сэргийлэх, сааруулалтын үр дүнгийн шилжүүлгийг зохицуулна.

- Долоодугаар бүлэг: Ногоон болон уур амьсгалын санхүүжилт. Үүнд: ногоон санхүүжилтийн бодлого, таксономи, уур амьсгалын санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалт, ESG, ногоон бонд, ил тод байдал болон хяналтын тогтолцоог тусгана.
- Наймдугаар бүлэг: Иргэн, хувийн хэвшил, олон нийтийн оролцоо. Үүнд: хувийн хэвшил, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд, залуучуудын оролцоо, олон нийтийн мэдлэг боловсрол, чадавхыг бэхжүүлэх асуудлыг зохицуулна.
- Есдүгээр бүлэг: Бусад зохицуулалт